

ISSN 2957-4285

ДОТООД ХЭРГИЙН ИХ СУРГУУЛЬ



ГЭМТ ЯВДАЛТАЙ ТЭМЦЭХ АСУУДАЛ

ОНОЛ, АРГА ЗҮЙН УЛИРАЛ ТУТМЫН СЭТГҮҮЛ

2024 №03 (90)
22 дахь жилдээ

СЭТГҮҮЛИЙН БОДЛОГЫН ЗӨВЛӨЛ

ЗӨВЛӨЛИЙН ДАРГА

Дорждамба ЗҮМБЭРЭЛЛХАМ

МОНГОЛ УЛСЫН ГАВЬЯАТ ХУУЛЬЧ, ДОКТОР (Ph.D), ПРОФЕССОР, ДОТООД ХЭРГИЙН ИХ СУРГУУЛИЙН ХҮНДЭТ ПРОФЕССОР

ЗӨВЛӨЛИЙН ГИШҮҮД

Пүрэвдорж БАТБААТАР

ДОКТОР (Ph.D), ПРОФЕССОР

Бөхчулуун БАТ-ЭРДЭНЭ

ДОКТОР (Ph.D), ПРОФЕССОР, ДОТООД ХЭРГИЙН ИХ СУРГУУЛИЙН ХҮНДЭТ ПРОФЕССОР

Бадам БАТЗОРИГ

ДОКТОР (Ph.D), ПРОФЕССОР

Жигжидсүрэн БОЛДБААТАР

ДОКТОР (Sc.D), ПРОФЕССОР, ДОТООД ХЭРГИЙН ИХ СУРГУУЛИЙН ХҮНДЭТ ПРОФЕССОР

Галбат ГАНТӨМӨР

ДОКТОР (Ph.D), ПРОФЕССОР, ДОТООД ХЭРГИЙН ИХ СУРГУУЛИЙН ХҮНДЭТ ПРОФЕССОР

Жамсран ДОЛГОРСҮРЭН

ДОКТОР (Sc.D), ПРОФЕССОР, ДОТООД ХЭРГИЙН ИХ СУРГУУЛИЙН ЭМЕРИТ ПРОФЕССОР

Думбурай МЯГМАРЦЭРЭН

ДОКТОР (Ph.D), ПРОФЕССОР

Наваанпэрэнлэй ЖАНЦАН

МОНГОЛ УЛСЫН ГАВЬЯАТ ХУУЛЬЧ, ДОКТОР (Ph.D), ПРОФЕССОР

Очирхуяг ЗОРИГТ

ДОКТОР (Ph.D), ДЭД ПРОФЕССОР

Чойжил НЯМСҮРЭН

ДОКТОР (Ph.D), ПРОФЕССОР, ДОТООД ХЭРГИЙН ИХ СУРГУУЛИЙН ХҮНДЭТ ПРОФЕССОР

Тамжид ОЮУНЧИМЭГ

ДОКТОР (Ph.D), ПРОФЕССОР, ДОТООД ХЭРГИЙН ИХ СУРГУУЛИЙН ХҮНДЭТ ПРОФЕССОР

Заяатхүү ТӨРМАНДАХ

ДОКТОР (Ph.D), ПРОФЕССОР

ХВАН И ГАБ

ДОКТОР, ПРОФЕССОР, ДОТООД ХЭРГИЙН ИХ СУРГУУЛИЙН ХҮНДЭТ ПРОФЕССОР

ДУГААРЫГ ЭРХЛЭН ГАРГАСАН

Энхсайхан ДАШГААДАН

ДОКТОР (Ph.D)

СЭТГҮҮЛИЙН РЕДАКЦЫН ЗӨВЛӨЛ

ЗӨВЛӨЛИЙН ДАРГА

Дорждамба ЗҮМБЭРЭЛЛХАМ

МОНГОЛ УЛСЫН ГАВЬЯАТ ХУУЛЬЧ, ДОКТОР (Ph.D), ПРОФЕССОР, ДОТООД ХЭРГИЙН ИХ СУРГУУЛИЙН ХҮНДЭТ ПРОФЕССОР

НАРИЙН БИЧГИЙН ДАРГА

Энхсайхан ДАШГААДАН

ДОКТОР (Ph.D)

ЗӨВЛӨЛИЙН ГИШҮҮД

Шаравдорж АРИУНБИЛЭГ

ДОКТОР (Ph.D), ДЭД ПРОФЕССОР

Вандан-Иш АМАРСАНАА

ДОКТОР (Ph.D)

Лувсан БАТ-ОЧИР

ДОКТОР (Ph.D), ДЭД ПРОФЕССОР

Рагчаасүрэн БАЯРМАГНАЙ

ДОКТОР (Ph.D), ПРОФЕССОР

Сэнгээ ГАНТУЛГА

ДОКТОР (Ph.D), ДЭД ПРОФЕССОР

Буриад ЛХАГВАРАГЧАА

ДОКТОР (Ph.D)

Жаргалсайхан МӨНХБОЛД

ДОКТОР (Ph.D), ДЭД ПРОФЕССОР

Намжилдорж МӨНХЗУЛ

ДОКТОР (Ph.D), ДЭД ПРОФЕССОР

Бат-Ерөөл МӨНХДОРЖ

ДОКТОР (Ph.D), ДЭД ПРОФЕССОР

Бадарч НАРМАНДАХ

ДОКТОР (Ph.D), ДЭД ПРОФЕССОР

Жутьяа НЯМДУЛАМ

ДОКТОР (Ph.D), ДЭД ПРОФЕССОР

Нямдорж ОДОНТУУЛ

ДОКТОР (Ph.D)

Шархүү ЧУЛУУНБАТ

ДОКТОР (Ph.D), ДЭД ПРОФЕССОР

Батзэвэг ЭНХБОЛД

ДОКТОР (Ph.D), ДЭД ПРОФЕССОР

Магмадорж ЭРДЭНЭБАЯР

ДОКТОР (Ph.D), ДЭД ПРОФЕССОР

Батсайхан ЭРДЭНЭБАТ

ДОКТОР (Ph.D), ДЭД ПРОФЕССОР

Дорж ЭНХТӨР

ДОКТОР (Ph.D)

ГАРЧИГ

ЭРҮҮГИЙН ЭРХ ЗҮЙН ОНОЛ, ПРАКТИКИЙН ТУЛГАМДСАН АСУУДАЛ		
Хууль сахиулагчийг эсэргүүцэх гэмт хэргийн зүйлчлэлд объектын үзүүлэх нөлөө	<i>В.Амарсанаа</i>	5
Гэм буруугийн холимог хэлбэр ба түүний гэмт хэрэгт илрэх нийтлэг шинж	<i>Б.Баярболд</i>	14
Хүүхдийн эсрэг бэлгийн хүчирхийллийн гэмт хэрэгтэй тэмцэх олон улсын эрх зүйн зохицуулалт, нийцэл	<i>Э.Товуудорж</i>	19
КРИМИНОЛОГИЙН ОНОЛ, ПРАКТИКИЙН ТУЛГАМДСАН АСУУДАЛ		
Амиа хорлох үзэгдлийн шалтгаан, нөхцөл, түүнд нөлөөлөх хүчин зүйлийг судалсан нь	<i>В.Номинчулуун</i>	26
Хүүхдийг гэмт хэрэгт өртөхөөс хүмүүжлийн аргаар урьдчилан сэргийлэх арга зам	<i>О.Одонбаатар</i>	33
Кибер орчинд телеграм платформ ашиглан үйлдэж буй залилах гэмт хэргийн нөхцөл байдалд хийсэн дүн шинжилгээ	<i>Б.Хатанзориг</i>	39
Өсвөр насны хүнийг амиа хорлох нөхцөл байдалд хүргэж буй шалтгаан, нөхцөл	<i>Б.Нямгэрэл</i>	44
ЭРҮҮГИЙН ПРОЦЕССЫН ЭРХ ЗҮЙН ОНОЛ, ПРАКТИКИЙН ТУЛГАМДСАН АСУУДАЛ		
Монгол Улсад авлигын гэмт хэргийг мөрдөн шалгах арга зүйн асуудал	<i>Р.Баярмагнай</i>	50
Үр ашигтай байх нь мөрдөн шалгах ажиллагааны үндсэн шинж болох нь	<i>Н.Сайнбаяр</i>	67
Өсвөр насны хүний үйлдсэн гэмт хэрэгт мөрдөн шалгах ажиллагаа явуулахад анхаарах асуудал	<i>Д.Бат-Эрдэнэ</i>	74
ШҮҮХИЙН ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭХ ЭРХ ЗҮЙН ОНОЛ, ПРАКТИКИЙН ТУЛГАМДСАН АСУУДАЛ		
ОХУ-ын Холбооны ял эдлүүлэх алба, түүний харьяа сургалт, эрдэм шинжилгээний байгууллагуудын тогтолцоо, харьцуулсан судалгаа	<i>О.Зоригт</i>	81
Монгол Улсад хорихоос өөр төрлийн ял эдлүүлж ирсэн эрх зүйн зохицуулалтын түүхэн уламжлал	<i>Т.Манлайбаатар</i>	88

ЭРҮҮГИЙН ЭРХ ЗҮЙН ОНОЛ, ПРАКТИКИЙН ТУЛГАМДСАН АСУУДАЛ

ХУУЛЬ САХИУЛАГЧИЙГ ЭСЭРГҮҮЦЭХ ГЭМТ ХЭРГИЙН ЗҮЙЛЧЛЭЛД ОБЪЕКТЫН ҮЗҮҮЛЭХ НӨЛӨӨ

OBJECT'S INFLUENCE ON ITEMIZATION CRIME RESISTING LAW ENFORCEMENT

В.Амарсанаа

*ДХИС-ийн Эрдэм шинжилгээний хүрээлэнгийн
Гэмт явдал, цагдаа, дотоодын цэрэг судлалын төвийн
эрдэм шинжилгээний ахлах ажилтан-багш, доктор (Ph.D),
цагдаагийн хошууч*

Товч агуулга: Хууль сахиулагчийг эсэргүүцэх гэмт хэрэг гэж үндэсний аюулгүй байдлыг хангах, гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журмыг хамгаалах чиг үүрэг бүхий албан хаагчийг хуулиар хүлээсэн үүргээ биелүүлэхтэй нь холбогдуулан эсэргүүцсэн, нийгэмд аюултай үйлдлийг хэлнэ. Энэ гэмт хэргийг нийтийн албаны ашиг сонирхлын эсрэг гэмт хэргийн бүлэгт багтаасан явдал нь уг гэмт хэрэг нь давхар объекттой гэмт хэрэгт хамаарахыг, тодруулбал, хууль сахиулагчийг эсэргүүцэж, эрүүл мэндэд нь халдах үйлдлээр давхар төрийн хэвийн үйл ажиллагаанд халдаж байгаа болохыг харуулж байна. Өөрөөр хэлбэл, нэгдүгээрт, төрийн байгууллагын хэвийн үйл ажиллагаанд, хоёрдугаарт, хууль сахиулагчийн эрүүл мэндийн халдашгүй байдалд халдаж буй нийгэмд аюултай үйлдэл юм.

Хууль сахиулагчийг эсэргүүцэх гэмт хэргийн халдлагад өртөгч болон объектын онцлог нь уг гэмт хэргийн зүйлчлэл ба Эрүүгийн хуулийн тогтолцоонд чухал нөлөө үзүүлэх онцлогийг харгалзаж, Эрүүгийн хуульд заасан “Хууль сахиулагч” гэх нэр томъёоны хамрах хүрээний учир дутагдалтай тал, уг гэмт хэргийн зүйлчлэлд объектын үзүүлэх нөлөөг судалж, шинжлэх ухааны үндэслэлтэй дүгнэлт, санал гаргахыг зорилоо.

Abstract: Resisting law enforcement officers is defined as an act of disobedience and endangering society when an officer carrying out his official duties—fighting crime, maintaining public order, and guaranteeing national security—does so.

The fact that the crime is listed among those that go against the interests of the public service indicates that it is a double-edged crime, meaning that it opposes law enforcement while also endangering the victim's health. This means that the crime falls under the category of crimes with a dual purpose.

To put it another way, it's a socially risky behavior that compromises the inviolability of law enforcement personnel's health as well as the regular operation of public institutions.

The goal is to examine the deficiencies in the Criminal Code's definition of "law enforcement" and the object's influence on it, drawing recommendations and conclusions based on science.

Түлхүүр үгс: Аюулгүй байдал, гэмт хэргийн объект, нийтийн хэв журам, олон нийтийн аюулгүй байдал, төрийн алба, хууль сахиулагч, хэвийн үйл ажиллагаа, эрүүл мэндийн халдашгүй байдал.

Keywords: Security, criminal object, public order, public safety, public service, law enforcement, normal operations, inviolability of health.

Удиртгал

Аливаа улс орны нийгмийн тогтвортой орших нөхцөл, иргэдийн аюулгүй байдал, ёс суртахууны хэм хэмжээг мөрдөх түвшин гэх зэрэг хүн хоорондын харилцааны үр дүнд үүсэх олон төрлийн зөрчил, цаашлаад гэмт хэргийн шинжтэй үйлдлийг таслан зогсоож, хамгаалах, урьдчилан сэргийлэх, аюулгүйжүүлэх чиглэлийн үүрэг гүйцэтгэдэг субъект бол хууль сахиулагч мөн. Хэдийгээр Монгол Улсын Үндсэн хуульд зааснаар “Эх орныхоо тусгаар тогтнолыг батлан хамгаалж, үндэсний аюулгүй байдал, нийгмийн дэг журмыг хангах нь төрийн үүрэг мөн”¹ боловч, дурдсан үйл ажиллагаа нь хууль сахиулагчдын нийтийн хэв журмыг хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах, гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэхэд чиглэсэн үүргийн гүйцэтгэлээр дамжин хэрэгжих нь гарцаагүй бөгөөд зайлшгүй зүйл юм.

Нийтийн хэв журмыг хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах үйл ажиллагааг үр дүнтэй явуулах үндсэн нөхцөл нь хууль сахиулах байгууллагын алба хаагчид албан үүргээ хуулийн хүрээнд, үр ашигтай гүйцэтгэх явдал байдаг. Ингэснээр гэмт хэрэг, зөрчилтэй хийх тэмцэл үр дүнд хүрнэ. Ю.Цэдэнбал 1960 онд зохион байгуулагдсан, хуулийн байгууллагуудын удирдах ажилтнуудын хамтарсан зөвлөгөөн дээр “Хөдөлмөрчдийн чинээлэг аж байдал, соёлын хэмжээ, тэдний социалист ухамсар, жилээс жилд дээшилж байна. Ингэхлээр гэмт хэрэг гарах нийгмийн шалтгаан тасран, арилжээ. Гэмт хэрэг хийх явдал гагцхүү хуучин заншлаас болох болжээ. Шударга ажиллахгүйгээс амьдралын зүйлийг хулгай, хуурамч аргаар олох, хүмүүжил сулаас нийгмийн хэв журмыг эвдэх, анхаарал, сахилгагүйгээс осолдож, цалгардаад, гэмт хэрэг гаргах ийм шалтгаанаар, гэмт хэрэг гарч байна. Эдгээр шалтгааныг арилгаж болох уу? Болно. Үүнийг багасгасаар байгаад гэмт хэрэг гарах явдлыг бүр мөсөн устгаж болох юм”² гээд, “...гэмт хэргийг үндсээр нь устгаж болно”³ хэмээн итгэлтэй өгүүлж байсан явдал нь тухайн үеийн нийгмийн хэв журам, олон нийтийн аюулгүй байдал өндөр хэмжээнд хангагдаж, өмнөх зуунтай харьцуулахад иргэдийн ухамсар өөр түвшинд хүрснээс гадна Эрүүгийн хууль тогтоомж гүйцэтгэх үүргээ хангалттай биелүүлж, механизм нь тогтвортой ажилласантай холбоотой юм. Мэдээж хэрэг, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, нийтийн хэв журам, олон нийтийн аюулгүй байдлыг хангах үндсэн үүрэгтэй албан хаагчдын хууль ёсны ажиллагаа хэрэгжээгүй тохиолдолд нийгмийн аль ч цаг үед улс орны тогтвортой байдал хангагдах боломжгүй билээ.

Үндсэн хэсэг

Аюулгүй байдлын эрх хэдий чинээ сайн хангагдана, төрөөс иргэдийн эрх чөлөө хэдий чинээ найдвартай баталгаажна, төдий чинээ ял, хариуцлага шударга байна⁴. Нийгэмд шударга ёсыг тогтоож, эмх журам сахиулах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах чиг үүргийн хүрээнд төрийг төлөөлж, тодорхой үүрэг гүйцэтгэсний хариуд эрүүгийн хуулийн хамгаалалт эдэлдэг тусгай субъект нь хууль сахиулагч бөгөөд, түүний аюулгүй байдлын баталгааг хангахын тулд хууль тогтоогч тусгай бүрэлдэхүүнт зүйл ангийг хуульчилсан. Тодруулбал, Эрүүгийн

¹ Монгол Улсын Үндсэн хууль // Төрийн мэдээлэл. Эмхэтгэл. УБ. 1992. №1.

² Цэдэнбал Ю. Залуу үеийг эрдэм мэдлэгтэй, ажилч хичээнгүй хүмүүс болгон хүмүүжүүлье. УБ. 1960. 49 дэх тал.

³ Мөн тэнд. 49 дэх тал.

⁴ Антология мировой правовой мысли : в 5 т. М., 1999. Т. 3. С. 155.

хуулийн тусгай ангийн 23.1 дүгээр зүйлд хууль сахиулагчийг эсэргүүцэх гэмт хэрэгт ямар үйлдлүүдийг хамааруулах, тэдгээрт ямар төрөл, хэлбэрийн шийтгэл оногдуулах талаар тодорхой заасан бөгөөд халдлагад өртөгч нь хууль сахиулагч байхаар тусгасан⁵.

Гэмт хэргийн бүрэлдэхүүний объектын тухай асуудлын хүрээнд зайлшгүй авч үзэх асуудал, түүний нэмэгдэл шинж бол халдлагад өртөгч юм. Гэмт хэргийн халдлагын зүйл, халдлагад өртөгч нь гэмт хэргийн бүрэлдэхүүний объектын нэмэгдэл шинж бөгөөд, Эрүүгийн хуулийн тусгай ангид хууль тогтоогчоос тодорхой гэмт хэргийн бүрэлдэхүүний шинж болгон урьдчилан заасан тохиолдолд, тухайн гэмт хэргийн бүрэлдэхүүний заавал байх, заавал тогтоох үндсэн шинж болно. Эрүүгийн хуулийн тусгай ангид халдлагын зүйл, халдлагад өртөгчийг хуульчилсан байдлыг судалж үзэхэд, хууль тогтоогч халдлагын зүйл, халдагад өртөгч нь тодорхой нийгэмд аюултай үйлдлийг гэмт хэрэгт тооцох эрүүгийн эрх зүйн гол шинж болох, тухайн хэргийн нийгмийн хор аюулыг ихэсгэх нөхцөл байдал, шинж болох, төсөөтэй гэмт хэргийг ялган зүйлчлэх гол шалгуур нь болж байгаа тохиолдолд л хуульчилдаг ба үүгээр түүний эрүүгийн эрх зүйн учир холбогдол тодорхойлогдоно⁶.

Хууль тогтоогч уг гэмт хэргийн халдлагад өртөгчийг хууль сахиулагчийг эсэргүүцэх гэмт хэргийн бүрэлдэхүүний шинж болгон урьдчилан заасан учир халдлагад өртөгчийн талаар судлах шаардлагатай.

2002 оны Эрүүгийн хуулийн тусгай ангийн 230 дугаар зүйлд “Төрийн албан хаагч, хэв журам хамгаалах олон нийтийн байцаагчийг эсэргүүцэх” гэх нэр томъёоны өргөн хүрээг хамарч, уг гэмт хэргийн хохирогч нь төрийн албан хаагч, олон нийтийн байцаагч байхаар хуульчилснаас гадна, хэрэгжүүлж буй үйл ажиллагааг нь тодотгох зорилгоор “...хэв журам хамгаалах” гэж тодотгосон бол одоо хэрэгжиж буй Эрүүгийн хуулийн тусгай ангийн 23.1 дүгээр зүйлд “Хууль сахиулагч” гэх нэршлээр хязгаарласан. Уг хуулийн 4.2 дугаар зүйлд “Хууль сахиулагч гэж цагдаа, тагнуул, шүүхийн шийдвэр гүйцэтгэх, төрийн тусгай хамгаалалтын албаны алба хаагч, хуулиар тусгайлан эрх олгосон эрх бүхий этгээд, байгаль хамгаалагчийг ойлгоно”⁷ гэж заажээ. Уг тодорхойлолтоос үзэхэд, хууль сахиулагчийг цагдаа, тагнуул, шүүхийн шийдвэр гүйцэтгэх, төрийн тусгай хамгаалалтын алба хаагчдаас гадна хуулиар тусгайлан эрх олгосон, эрх бүхий этгээдүүдээр хязгаарлаж, Дотоодын цэргийн байгууллагын алба хаагч, олон нийтийн цагдаагийн алба хаагч, Дотоод хэргийн их сургуулийн алба хаагч, Батлан хамгаалах яамны харьяа Зэвсэгт хүчний анги байгууллагын алба хаагчдыг орхигдуулжээ гэж дүгнэх үндэслэлтэй байна. Гэтэл нийтийн хэв журмыг хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах үүргийг тодорхойлолтод дурдсан байгууллагын албан хаагчдаас гадна, онцгой тохиолдолд цэргийн албан хаагч хүртэл гүйцэтгэдэг онцлогтой. Тухайлбал, Онц байдлын тухай хуулийн 21 дүгээр зүйл (Цагдаагийн ба цэргийн алба хаагч, төрийн албан хаагчийн хүлээх хариуцлага)-д “Онц байдлын үед хүч, галт зэвсэг, тусгай хэрэгсэл хэрэглэхдээ хууль зөрчсөн, бүрэн эрхээ хэтрүүлсэн, түүнчлэн албан үүргээ зохих ёсоор биелүүлээгүй буюу энэ хуулийн 18 дугаар зүйлд заасан иргэний эрх, эрх чөлөөний баталгааг зөрчсөн цагдаагийн ба цэргийн алба хаагч, төрийн албан хаагч нь хууль тогтоомжид заасан хариуцлага хүлээнэ”⁸ гэж зааснаас онц байдлын үед цагдаагийн байгууллагын алба хаагчаас гадна цэргийн алба хаагч, төрийн албан

⁵ Гантулга С., Энхболд Б. Эрүүгийн эрх зүйн тусгай анги. Сурах бичиг. УБ. 2018. 411 дэх тал.

⁶ Гантөмөр Г. Гэмт хэргийн бүрэлдэхүүний ерөнхий онол. Нэмж засварласан хоёр дахь хэвлэл. УБ. 2011. 57 дахь тал.

⁷ Эрүүгийн хууль // Төрийн мэдээлэл. Эмхэтгэл. УБ. 2016. №7. 4.2 дугаар зүйл.

⁸ Онц байдлын тухай хууль // Төрийн мэдээлэл. Эмхэтгэл. УБ. 1996. №2. 21 дүгээр зүйл.

хаагчид бүгд үүрэг гүйцэтгэдэг болохыг харж болохоор байна. Онц байдлын үед хэрэгжүүлэх онцгой арга хэмжээнд хэрэгжүүлэх ёстой үндсэн арга хэмжээнээс гадна дараах арга хэмжээг хуулийн дагуу гүйцэтгэх эрх үүсдэг. Үүнд:

Хүснэгт 1. Онц байдлын үед хэрэгжүүлэх шаардлагатай арга хэмжээний жагсаалт

1.	Нийтийн эмх замбараагүй байдал бий болгож хүч хэрэглэсэн үйл ажиллагаа явуулсан буюу явуулж байгаа байгууллагыг тараах, бүлэг хүмүүсийг албадан тараах, албадан саатуулах, тэдгээрийн зэвсэг, техник хэрэгслийг хураан авах;
2.	Хөл хорих, өөрөөр хэлбэл төрийн эрх бүхий байгууллагаас тусгайлан олгосон зөвшөөрлийн болон иргэний үнэмлэх, түүнтэй адилтгах баримт бичиггүйгээр гудамж, талбай, олон нийтийн бусад газарт хоногийн тодорхой цаг хугацаанд зорчихыг хориглох. Энэ заалтыг зөрчсөн этгээдийг цагдаа буюу цэргийн эргүүл хөл хорих цаг дуустал, иргэний үнэмлэх, түүнтэй адилтгах баримт бичиггүй бол хэн болохыг нь тогтоох хүртэл, гэхдээ 72 цагаас илүүгүй хугацаагаар албадан саатуулах, шаардлагатай гэж үзвэл албадан саатуулагдсан хүний бие, авч яваа эд зүйлд үзлэг хийх;
3.	Шаардлагатай гэж үзвэл иргэний үнэмлэх, түүнтэй адилтгах баримт бичгийг шалгах, галт зэвсэг, хүний амь нас, эрүүл мэндэд хохирол учруулж болох бусад зүйлийг хууль бусаар авч явах буюу хадгалж байгаа, эсхүл хэрэглэж болзошгүй гэж үзэх үндэслэл байгаа бол иргэдийн бие, орон сууц, тээврийн хэрэгсэл, эд зүйлд үзлэг хийх;
4.	Олшруулах болон дуу авиаг чангаруулах техник хэрэгслийн ашиглалтыг хязгаарлах буюу хориглох, шаардлагатай бол түр хураан авах, олон нийтийн мэдээллийн хэрэгсэлд хяналт тогтоох, эсхүл онц байдлыг цуцлах хүртэл үйл ажиллагааг нь зогсоох;
5.	Холбооны хэрэгсэл ашиглах тусгай журам тогтоох;
6.	Нийтийн эмх замбараагүй байдлыг арилгахад саад учруулж буй улс төрийн нам, эвсэл холбоо, олон нийтийн байгууллагын үйл ажиллагааг зогсоох;
7.	Онц байдал зарласан нутаг дэвсгэрт зохих зөвшөөрөлгүй оршин сууж байгаа бөгөөд онцгой дэглэм сахиулахад саад учруулсан этгээдийг байнга оршин суух газарт нь, эсхүл онц байдал тогтоогоогүй засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж рүү албадан гаргах;
8.	Зэвсэг, галт хэрэгсэл, хүчтэй үйлчлэх химийн хорт бодис, согтууруулах ундааны зүйл худалдах, тараахыг хориглох;
9.	Иргэдийн эзэмшилд байгаа галт болон хүйтэн зэвсэг, галт хэрэгсэл, аж ахуйн нэгж, байгууллагын үйлдвэрлэлийн технологид хэрэглэдэг тэсэрч дэлбэрэх, хүчтэй үйлчлэх химийн хорт болон цацраг идэвхт бодис, сургалтын зориулалттай байлдааны зэвсэг, техник хэрэгслийн ашиглалтад хяналт тогтоох, шаардлагатай гэж үзвэл ашиглалтыг зогсоох буюу тэдгээрийг түр хураан авах зэрэг хамаарна.

Эдгээр үүргийг гүйцэтгэх явцад цагдаагийн байгууллагын алба хаагчдаас гадна цэргийн алба хаагч, төрийн алба хаагчдыг үүргээ гүйцэтгэхтэй нь холбогдуулан эсэргүүцэх, заналхийлэх, бие махбодод нь халдаж, гэмтэл учруулсан тохиолдолд, Эрүүгийн хуулийн тусгай ангийн 23.1 дүгээр зүйлд заасны дагуу, тусгай бүрэлдэхүүнтэй гэмт хэргээр зүйлчилж, хариуцлага хүлээлгэх ёстой. Гэтэл эдгээр байгууллагуудын алба хаагчид албаны үүрэг, хариуцлагын хүрээнд нийтийн хэв журмыг хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах чиглэлийн үйл ажиллагааг шууд болон шууд бусаар гүйцэтгэдэг онцлогийг үл харгалзан, “хууль сахиулагч” ангилалд багтаагаагүй шалтгаан тодорхой бус байна. Үүний үр

дүнд хууль сахиулах чиглэлийн үүрэг гүйцэтгэж буй алба хаагчдыг эсэргүүцсэн, бие махбодод нь халдсан гэмт хэргийн зүйлчлэлийн асуудал өөрчлөгдөж, гэмт этгээд ял завших тохиолдол ч гарахыг үгүйсгэх аргагүй байна.

Хэдийгээр “хууль сахиулагч” гэх ойлголтыг Эрүүгийн хуульд тодорхойлсон боловч, үүнд хамаарах этгээдүүд нь “хууль сахиулах чиг үүрэг” гэх ойлголтод заагдсан зарим байгууллагын албан хаагчдыг хамааруулаагүй болох нь дараах тодорхойлолтоос харагдаж байна. Зөрчлийн тухай хуулийн 15.2 дугаар зүйлийн тайлбар хэсэгт “хууль сахиулах чиг үүрэг гэж цагдаа, дотоодын цэрэг, тагнуул, гааль, шүүхийн шийдвэр гүйцэтгэх, төрийн тусгай хамгаалалтын албаны болон авлигатай тэмцэх, хил хамгаалах, гадаадын иргэн, харьяатын асуудал эрхэлсэн байгууллагын алба хаагчийн хуульд заасан чиг үүргийг ойлгоно”⁹ гэж тодорхойлсон байна. Тэгвэл төрийн албан хаагч гэдэгт “...төрийн албан тушаалыг эрхэлж, эрх, үүргээ хэрэгжүүлсний төлөө төрөөс цалин хөлс авч, ажиллах нөхцөл, баталгаагаар хангагдан ажиллаж байгаа этгээдийг”¹⁰ ойлгохоор заасан. Тэгэхээр “төрийн албан хаагч” гэх ойлголт нь “хууль сахиулагч” гэх ойлголтоос хавьгүй өргөн хүрээг хамарсан төдийгүй, нийтлэг үйл ажиллагааны чиглэлийг багцалсан шинжтэй байна. “Хууль сахиулагч” гэх ойлголт нь “хууль сахиулах чиг үүрэг” гэх ойлголтын, тодруулбал, хууль сахиулах үйл ажиллагаа явуулах албан байгууллагуудын хамрах хүрээг өөртөө багтаасан ойлголт болж чадаагүй гэж үзэх үндэслэлтэй байна. Уг учир дутагдалтай байдал нь дотоодын цэрэг, гааль, авлигатай тэмцэх, хил хамгаалах, гадаадын иргэн, харьяатын асуудал эрхэлсэн зэрэг байгууллагуудын алба хаагчдыг хууль сахиулагч гэх тодорхойлолтод хамааруулан дурдаагүйгээс үүдэлтэй байж болох юм. Хэрэв уг нэр дурдагдаагүй байгууллагуудын албан хаагчдыг хуульд заасан чиг үүргээ хэрэгжүүлсэнтэй нь холбогдуулан эсэргүүцсэн, биед нь гэмтэл учруулсан тохиолдолд хэрхэн зүйлчлэх эсэх асуудал маргаан дагуулахаас гадна шударга ёсны зарчим¹¹ алдагдахад хүргэж байна.

Халдлагад өртөгч нь объектын нэмэгдэл шинжээр бүрэлдэхүүн хэсэгт багтдаг бол гэмт хэргийн объект нь хавьгүй өргөн хүрээг хамарсан ойлголт байдгаараа ялгаатай. Гэмт хэргийн объектыг Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 1.1 дүгээр зүйлд “Энэ хуулийн зорилго нь Монгол Улсын Үндсэн хуулиар баталгаажуулсан хүний эрх, эрх чөлөө, нийтийн болон үндэсний ашиг сонирхол, Үндсэн хуулийн байгуулал, үндэсний болон хүн төрөлхтний аюулгүй байдлыг гэмт халдлагаас хамгаалах, гэмт хэргээс урьдчилан сэргийлэхэд оршино”¹² гэж тодорхойлсон. Өөрөөр хэлбэл, дээр дурдсан харилцааг хамгаалахад Эрүүгийн хууль чиглэх бөгөөд, гэмт хэргийн объектыг өргөн утгаар тодорхойлбол, гэмт хэргийн улмаас гэмт этгээдийн халдлагад өртөгдөж байгаа нийгмийн харилцаа юм. Профессор Г.Совд “Гэмт хэргийн нийгэмд аюултай шинж нь түүний халдаж байгаа нийгмийн харилцааны агуулга, шинж чанараар тодорхойлогдох бөгөөд, тэр нь гэмт хэргийн бүрэлдэхүүний объект болно. Гэмт хэргийн бүрэлдэхүүний объект нь гэмт хэргийн улмаас хохирол амссан нийгмийн харилцаа юм”¹³ гэж тодорхойлсон. Профессор С.Жанцан “Гэмт хэргийн улмаас бодитой хор уршиг учирсан, учирч болох байсан Эрүүгийн хуулиар хамгаалагдсан хүн, нийгэм, төр, байгууллагын амин чухал эрх ашиг, сонирхлоор дамжин илэрдэг

⁹ Зөрчлийн тухай хууль // Төрийн мэдээлэл. Эмхэтгэл. УБ. 2017. №24. 15.2 дугаар зүйл.

¹⁰ Төрийн албаны тухай хууль // Төрийн мэдээлэл. Эмхэтгэл. УБ. 2018. №1. 3 дугаар зүйлийн 3.1.2 дахь хэсэг.

¹¹ Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 1.3 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Эрүүгийн хариуцлага нь тухайн хүн, хуулийн этгээдийн үйлдсэн гэмт хэрэг, гэмт хэргийн нийгмийн аюулын шинж чанар, хэр хэмжээ, гэм буруугийн хэлбэрт тохирсон байна” гэж заасан.

¹² Эрүүгийн хууль // Төрийн мэдээлэл. Эмхэтгэл. УБ. 2016. №7. 1.1 дүгээр зүйл.

¹³ Совд Г. Монгол Улсын Эрүүгийн хуулийн тайлбар. УБ. 2002. 23 дахь тал.

нийгмийн харилцаа”¹⁴ гэж, доктор (Ph.D) Г.Гантөмөр “Гэмт хэргийн улмаас халдагдаж, зөрчигдөж байгаа Эрүүгийн хуулиар хамгаалагдсан, хүн, нийгэм, төр, байгууллага, аж ахуйн нэгжийн эрх, ашиг сонирхол юм”¹⁵ гэж тус тус тодорхойлжээ. Эндээс гэмт хэргийн объектын талаар судлаачдын нэгдсэн ойлголт нийгмийн харилцаа гэх ухагдахуун дээр төвлөрч байгааг харж болохоор байна.

Гэмт хэргийн чиглэж буй нийгмийн харилцаа, түүний үр дүнд тэргүүн эгнээнд өртөж, хохирч буй зүйлээс улбаалан, эрүүгийн эрх зүйн шинжлэх ухаанд гэмт этгээдийн гэмт халдлагад шууд өртөж, хор уршиг учруулсан нийгмийн тодорхой нэг харилцааг шууд объект гэдэг. Тэгвэл хууль сахиулагчийг эсэргүүцэх гэмт хэргийн үндсэн шууд объект нь хууль сахиулагчийн хэвийн үйл ажиллагаа, нэмэгдэл шууд объект нь хууль сахиулагчийн эрүүл мэнд байна. Өөрөөр хэлбэл, энэ төрлийн гэмт хэргийн үед гэмт этгээд хууль сахиулагчийн нийтийн хэв журмыг хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах, гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэхэд чиглэсэн хэвийн үйл ажиллагаанд саад учруулахаас гадна хууль сахиулагчийн эрүүл мэндэд хохирол учруулдаг, хоёр харилцаанд нэгэн зэрэг халддаг, давхар объектод гэмт хэрэг юм. Хэдий чинээ олон харилцаанд халдана, төдий чинээ нийгэмд аюултай гэмт хэрэг гэх жишгийн дагуу хууль сахиулагчийг эсэргүүцэх гэмт хэргийн нийгэмд учруулах хор аюул давхар объектод байдлаар шууд тодорхойлогдоно.

Хууль сахиулагчийг эсэргүүцэх гэмт хэрэг зарим гэмт хэргээс давхар объектод байдлаараа ялгагдана. Өөрөөр хэлбэл, уг гэмт хэргийн үндсэн объект нь хууль сахиулагчийн хэвийн үйл ажиллагаа, нэмэгдэл объект нь хууль сахиулагчийн эрүүл мэнд байна. А.И.Марцев, Н.В.Вишнякова нар “Гэмт хэргийн объектыг тодорхойлохдоо нийгэм-эрх зүйн онцлогийг харгалзан үзэх ёстой. Гэмт хэргийн объект нь эрх зүйн нөлөөнд автдаг, нийгмийн хэвийн хөгжилд нөлөөлдөг, эрх зүйн хамгаалалтыг бодитоор шаарддаг, гэмт хэргийн улмаас ноцтой хохирол учирдаг, хавьгүй чухал нийгмийн харилцаа”¹⁶ гэжээ. Хууль сахиулагчийг эсэргүүцэх гэмт хэргийн нийгэм-эрх зүйн онцлог нь түүний нийгмийн хэв журмыг хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах чиглэлээр явуулах хууль ёсны үйл ажиллагаа юм. Хууль сахиулагчийн зүгээс нийгмийн хэв журмыг хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах явцад эсэргүүцэлтэй тулгарсан, цаашлаад биедээ гэмтэл авсан тохиолдолд субъектийн үйлдлийг Эрүүгийн хуулийн тусгай ангийн 23.1 дүгээр зүйлд зааснаар зүйлчлэх ёстой. Уг гэмт хэргийн мөн чанар нь хууль сахиулах байгууллагын албан хаагчийн албан үүргээ гүйцэтгэхтэй нь холбогдуулан эсэргүүцэх явдал юм. Хэрэв хууль сахиулагчийн албан үүргээ гүйцэтгэхтэй нь холбоотой бусаар маргаан үүсгэж, цаашлаад биед нь гэмтэл учруулсан бол эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэргийн аль тохирох (биед учруулсан гэмтлээс хамаарч) хэсгээр зүйлчилнэ. Тэгэхээр хууль сахиулагчийн нийтийн хэв журмыг хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангахад чиглэсэн албан үүргээ гүйцэтгэхтэй нь холбогдуулан эсэргүүцэх нь уг гэмт хэргийн заавал байх шинж бөгөөд, үндсэн объектыг тодорхойлох гол хүчин зүйл болж байна.

Цагдаагийн байгууллагын алба хаагчдын (170 алба хаагч) дунд анкетын судалгаа явуулж, “Та нийгмийн хэв журмыг хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах чиглэлийн үйл ажиллагаа явуулж байх үедээ эсэргүүцэлтэй тулгарч байсан уу?” гэх асуултад, судалгаанд оролцогчдын 5 хувь нь “Тийм,

¹⁴ Жанцан С. Монгол Улсын Эрүүгийн эрх зүй. Схемчилсэн тайлбар, зүйлчлэлийн асуудал. УБ. 2004. 19-20 дахь тал.

¹⁵ Гантөмөр Г. Гэмт хэргийн бүрэлдэхүүний ерөнхий онол. Нэмж засварласан хоёр дахь хэвлэл. УБ. 2011. 40 дэх тал.

¹⁶ Марцев А.И., Вишнякова Н.В. Развитие учения об объекте преступления. Лекция. Омск. 2002. С. 31.

эсэргүүцэлтэй тулгарч гэмтэж байсан” гэж хариулсан бол, 13.5 хувь нь “Тийм, эсэргүүцэлтэй тулгарч хувцас, мөрдэс зэргээ уруулж байсан”, 15.3 хувь нь “Үгүй, цагдаагийн алба хаагчдад тэр бүр хүч хэрэглээд байдаггүй” гэж хариулсан бол 62.4 хувь нь “Тийм, эсэргүүцэлтэй тулгарч байсан. Үр дүнд нь гэмтэх тохиолдол түгээмэл байдаг” гэх хариултыг тус тус сонгосон байна. Мөн судалгаанд оролцогчдын 3.8 хувь нь “Хөдөө орон нутгийн алба хаагч нар мэдэгдэлгүй их өртөж байдаг” гэсэн хариултыг нэмэлтээр тодотгосон. Үүнээс үзэхэд, нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах, гэмт хэрэгтэй тэмцэх чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг цагдаагийн алба хаагчид өдөр тутам ямар нэгэн байдлаар эсэргүүцэлтэй тулгарч, ихэнх тохиолдолд эрүүл мэндээрээ хохирох явдал ажиглагдаж байна.

Гэтэл хууль сахиулагчийн эрүүл мэндэд хохирол учруулсан үйлдлийг Эрүүгийн хуульд эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэргээр давхар зүйлчилж байгаа нь объектыг буруу тодорхойлсон явдал гэж үзэж байна. Учир нь хууль сахиулагчийг эсэргүүцэх гэмт хэрэг нь төрлийн объект болон шууд объектоос шалтгаалаад, захиргааны журмын эсрэг гэмт хэрэгт хамаарах учир хууль тогтоогчийн зүгээс аливаа гэмт хэргийн объектоос хамаарч Эрүүгийн хуульд системтэй байршуулах зарчмыг зөрчсөн явдал болсон гэж үзэх үндэстэй. Энэ тал дээр 2002 оны Эрүүгийн хууль илүү дэвшилттэй үзэл санааг баримталж ирсэн. Тодруулбал, 2002 оны Эрүүгийн хуулийн тусгай ангийн 230 дугаар зүйлийн үндсэн бүрэлдэхүүнд “Төрийн албан хаагчийг хуулиар хүлээсэн үүргээ гүйцэтгэж байхад нь болон олон нийтийн байцаагчийг хэв журам сахиулах үүргээ биелүүлж байхад нь хүч хэрэглэн эсэргүүцсэн буюу хүч хэрэглэхээр заналхийлсэн, түүнчлэн хууль бус үйлдэл хийлгэхээр албадсан” үйлдлийг хэлбэрийн бүрэлдэхүүнтэйгээр хуульчилж, уг зүйлийн 2 дахь хэсэгт “Энэ хэргийн улмаас төрийн албан хаагч болон олон нийтийн байцаагчийн бие махбодод хөнгөн, хүндэвтэр гэмтэл учирсан бол” гэж, 3 дахь хэсэгт “Энэ хэргийн улмаас төрийн албан хаагч болон олон нийтийн байцаагчийн бие махбодод хүнд гэмтэл учирсан бол” гэж тус тус гэмтлийн зэргээс хамаарч, хүндрүүлэх, онц хүндрүүлэх бүрэлдэхүүнтэйгээр хуульчилж, хүлээлгэх эрүүгийн хариуцлагыг хүндрүүлсэн. Бидний үзэж байгаагаар, 2002 оны Эрүүгийн хуулийн тусгай ангийн 230 дугаар зүйлд зааснаар хууль сахиулагчийг эсэргүүцсэн, биед нь гэмтэл учруулсан үйлдэлд хариуцлага хүлээлгэдэг байсан тогтолцоо нь хэрэгжиж буй Эрүүгийн хуулийн тусгай ангийн 23.1 дүгээр зүйлд заасан, хууль сахиулагчийг эсэргүүцэх гэмт хэрэгтэй харьцуулахад, төрийн албан хаагч, хэв журам хамгаалах олон нийтийн байцаагчийн, нийтийн хэв журмыг хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангахад чиглэсэн албан үүргээ гүйцэтгэхтэй нь холбогдуулан эсэргүүцэх, биед нь гэмтэл учруулах үйлдлийн хариуцлагын болон Эрүүгийн эрх зүйн хамгаалалтын тогтолцоог илүү дэвшилттэй, боловсронгуй байдлаар тусгажээ.

Өмнөх Эрүүгийн хуулийн уг заалтыг хэрэгжиж буй Эрүүгийн хуулийн тусгай ангийн 23.1 дүгээр зүйлд хүндрүүлэх нөхцөл байдлаар нэмэлтээр оруулснаар хууль сахиулагчийг эсэргүүцэх, биед нь гэмтэл учруулахаас урьдчилан сэргийлэх, хамгаалалтын чухал ач холбогдолтойгоос гадна иргэдийн хэвийн, эрүүл, аюулгүй орчинд ажиллаж, амьдрах нөхцөлийг төрөөс эрүүгийн бодлогоор хангаж буйн нэгэн илрэл болох учиртай юм.

Дүгнэлт

1. “Хууль сахиулагч” гэх ойлголт нь хууль сахиулах үйл ажиллагаа явуулах албан байгууллагуудын хамрах хүрээг өөртөө бүрэн багтаагаагүйгээс гадна, тодорхой хэдэн төрлийн алба хаагчийг хамааруулсан шинжээрээ бусад албан

хаагчдыг ялгаварласан шинжтэй байна. Дотоодын цэрэг, гааль, авлигатай тэмцэх, хил хамгаалах, гадаадын иргэн, харьяатын асуудал эрхэлсэн байгууллагын алба хаагчид болон цэргийн алба хаагчдыг хууль сахиулагчаас ангид үзэх шинжтэй тодорхойлолт гаргасан нь албан хаагчдыг хуульд заасан чиг үүргээ хэрэгжүүлсэнтэй нь холбогдуулан эсэргүүцсэн, биед нь гэмтэл учруулсан тохиолдолд хэрхэн зүйлчлэх эсэх асуудлыг ойлгомжгүй болгосон байна.

2. Хууль сахиулагчийн нийтийн хэв журмыг хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангахад чиглэсэн албан үүргээ гүйцэтгэхтэй нь холбогдуулан эсэргүүцэх нь уг гэмт хэргийн заавал байх шинж бөгөөд, үндсэн шууд объектыг тодорхойлох гол хүчин зүйл болдог. Хууль тогтоогч уг гэмт хэргийн үндсэн шууд объект нь хууль сахиулагчийн хэвийн үйл ажиллагаа болохыг хүлээн зөвшөөрч, Эрүүгийн хуулийн тусгай ангийн 23 дугаар бүлэгт хамааруулсан.

3. Хэрэгжиж буй Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 4.2 дугаар зүйлийн аутентик тайлбарын (Хууль сахиулагч гэж цагдаа, тагнуул, шүүхийн шийдвэр гүйцэтгэх, төрийн тусгай хамгаалалтын албаны алба хаагч, хуулиар тусгайлан эрх олгосон эрх бүхий этгээд, байгаль хамгаалагчийг ойлгоно) тодорхойлолт нь “хуулиар тусгайлан эрх олгосон эрх бүхий этгээд” гэж хэнийг ойлгох талаар нэгдсэн ойлголтыг өөртөө багтаагаагүйгээс гадна Зөрчлийн тухай хуульд заасан хууль сахиулах чиг үүргийн байгууллагуудтай харилцан уялдаагүй явдал нь уг ойлголтын зөрүү үүсгэж байна.

4. Хууль сахиулагчийн эрүүл мэндэд хохирол учруулсан үйлдлийг Эрүүгийн хуулийн 11 дүгээр бүлэгт заасан, эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэргийн тохирох зүйл (гэмтлийн зэргээс хамааран)-ээр давхар зүйлчилж байгаа явдал нь хууль тогтоогч аливаа гэмт хэргийн объектоос хамаарч Эрүүгийн хуульд системтэй байршуулах зарчмыг зөрчжээ.

Санал

1. Эрүүгийн хуулийн тусгай ангийн 23.1 дүгээр зүйлийг практикт хэрэглэхэд хүндрэл учрахаас сэргийлэх, илүү өргөн хүрээний бөгөөд тодорхой албан хаагчдыг хамгаалах боломж олгох, хууль хэрэглээний асуудлыг хоёрдмол, салаа утгагүй тодорхойлох зорилгоор, нэг бол “Хууль сахиулагч” гэх ойлголтын талаар илүү өргөн хүрээний тодорхойлолт гаргах, эсхүл гүйцэтгэж буй үүргийн онцлог, төрөл, хэлбэрийг харгалзан үзсэний үндсэн дээр хууль сахиулагч гэх ойлголтыг эцэслэн тодорхойлох хэрэгцээ, шаардлага урган гарч байна. Уг шаардлагын дагуу “хууль сахиулагч” гэх ойлголтыг “нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах” үүргээс нь хамаарч тодорхойлох;

2. Төрийн байгууллагын хэвийн үйл ажиллагаа алдагдахаас гадна хууль сахиулагчийн эрүүл мэндэд хохирол учруулж байгаа байдлаараа нийгмийн аюулын шинж чанар, хэр хэмжээ хавьгүй өндөртэйд тооцогдохын хувьд ч тэр, Эрүүгийн хуулийн тусгай ангид заасан зүйл ангиудыг дараалалд оруулахдаа гэмт халдлагад шууд өртөж байгаа харилцаанаас шалтгаалан тусдаа бүлэгт харьяалан, системчлэх зарчмын хувьд ч тэр, хууль сахиулагчийг эсэргүүцэхийн зэрэгцээ, түүний биед учруулах хохирол, тэдгээрээс урган гарах хор уршгийг ч тэр олон талаас нь бодолцон үзэж, уг гэмт хэргийн зүйл ангид өөрчлөлт оруулах шаардлагатай. Тодруулбал, Эрүүгийн хуулийн тусгай ангийн 23.1 дүгээр зүйлд дараах нэмэлт, өөрчлөлт оруулах саналтай байна. Үүнд:

23.1 дүгээр зүйл. Хууль сахиулагчийг эсэргүүцэх

2.Энэ гэмт хэргийн улмаас хууль сахиулагчийн эрүүл мэндэд хөнгөн хохирол учруулсан бол...;

3.Хууль сахиулагчийн эрүүл мэндэд хүндэвтэр хохирол учруулсан бол...;

4.Хууль сахиулагчийн эрүүл мэндэд хүнд хохирол учруулсан бол...

Ашигласан материал

А. Хууль, эрх зүйн баримт бичиг

- Монгол Улсын Үндсэн хууль // Төрийн мэдээлэл. Эмхэтгэл. УБ. 1992. №1.
- Зөрчлийн тухай хууль // Төрийн мэдээлэл. Эмхэтгэл. УБ. 2017. №24.
- Онц байдлын тухай хууль // Төрийн мэдээлэл. Эмхэтгэл. УБ. 1996. №2.
- Төрийн албаны тухай хууль // Төрийн мэдээлэл. Эмхэтгэл. УБ. 2018. №1.
- Эрүүгийн хууль // Төрийн мэдээлэл. Эмхэтгэл. УБ. 2016. №7.

Б. Сурах бичиг, гарын авлага, нэг сэдэвт бүтээл

- Гантөмөр Г. Гэмт хэргийн бүрэлдэхүүний ерөнхий онол. Нэмж засварласан хоёрдахь хэвлэл. УБ. 2011
- Гантулга С., Энхболд Б. Эрүүгийн эрх зүйн тусгай анги. Сурах бичиг. УБ. 2018.
- Жанцан С. Монгол Улсын Эрүүгийн эрх зүй. Схемчилсэн тайлбар, зүйлчлэлийн асуудал. УБ. 2004.
- Совд Г. Монгол Улсын Эрүүгийн хуулийн тайлбар. УБ. 2002. 23 дахь тал.
- Цэдэнбал Ю. Залуу үеийг эрдэм мэдлэгтэй, ажилч хичээнгүй хүмүүс болгон хүмүүжүүлье. УБ. 1960.

В. Гадаадын эх сурвалж

- Антология мировой правовой мысли : в 5 т. М., 1999. Т. 3.
- Марцев А.И., Вишнякова Н.В. Развитие учения об объекте преступления. Лекция. Омск. 2002.

ГЭМ БУРУУГИЙН ХОЛИМОГ ХЭЛБЭР БА ТҮҮНИЙ ГЭМТ ХЭРЭГТ ИЛРЭХ НИЙТЛЭГ ШИНЖ

MIXED FORMS OF CULPABILITY AND ITS COMMON FEATURES IN CRIME

Б.Баярболд

*ДХИС-ийн Цагдаагийн сургуулийн
Эрүүгийн эрх зүй, криминологийн тэнхимийн
багш, цагдаагийн ахмад*

Товч агуулга: Монгол Улсын Эрүүгийн хуульд гэм буруугийн холимог хэлбэрийг хуульчилсан боловч чухамхүү ямар гэмт хэргүүд гэм буруугийн болгоомжгүй хэлбэрээр үйлдэгдэж болох талаар тодорхой заагаагүй билээ. Энэ нь эрдэмтэн, судлаачдын дунд онолын тодорхой маргааныг бий болгох ба энэхүү өгүүллийн хүрээнд Эрүүгийн хуулийн тусгай ангид заасан гэмт хэргүүдэд дүн шинжилгээ хийж, гэм буруугийн холимог хэлбэр, түүний нийтлэг шинж, тэдгээр нь ямар гэмт хэрэгт илэрч байгааг тодорхойлохыг зорьсон.

Abstract: The criminal law of Mongolia has legalized mixed forms of guilt, but it has not been clearly specified in which crimes it can be manifested. This will create theoretical debates among researchers, and within the framework of this article, it is intended to analyze the crimes specified in the special class of the criminal law, to determine the common features of mixed forms of guilt and in which crimes they are manifested.

Түлхүүр үг: Гэм буруу, гэм буруугийн холимог хэлбэр, давхардсан гэм буруу, гэм буруугийн санаатай хэлбэр, гэм буруугийн болгоомжгүй хэлбэр.

Keywords: Fault, mixed fault, double fault, intentional fault, reckless fault

Гэмт этгээдийн өөрийнх нь хийсэн нийгэмд аюултай үйлдэл, үйлдэхүй, түүний улмаас учрах хохирол, хор уршигт хандах сэтгэхүйн харьцаа буюу гэм бурууг үнэн зөв тогтоох нь нарийн төвөгтэй үйл явц байдаг. Гэм бурууг нарийн тогтоох нь хэргийг зөв зүйлчлэх, цаашлаад ялыг шударга оногдуулахад ихээхэн ач холбогдолтой юм.

Амьдралд гарсан ихэнх гэмт хэргүүд гэм буруугийн санаатай болон болгоомжгүй хэлбэрээр үйлдэгддэг байхад зарим гэмт хэрэг нь гэм буруугийн онцлог хэлбэртэйгээр үйлдэгддэг. Үүнд гэм буруугийн үндсэн хоёр хэлбэр нэг гэмт хэрэгт зэрэг илэрч байдаг онцлогтой.

Гэм буруугийн холимог хэлбэрийг эрүүгийн эрх зүйн бүтээлд “Гэм буруугийн давхардсан хэлбэр”, “Гэм буруугийн хосолсон хэлбэр”, “Гэм буруугийн хоёр хэлбэр” зэргээр томъёолсон байдаг. Манай улсын эрүүгийн эрх зүйд профессор Г.Совд “Гэм буруугийн давхардсан хэлбэр”¹⁷ хэмээн томъёолж, анх судалсан байна. Академич С.Нарангэрэл “Гэм буруугийн хоёр хэлбэр”¹⁸, профессор С.Жанцан “Гэм буруугийн давхардсан хэлбэр”¹⁹ гэж тодорхойлсон бол профессор Г.Гантөмөр “Давхардсан гэм буруу”²⁰ гэж томъёолсон байдаг.

Монгол Улсын Эрүүгийн хуулийн 2.4 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт “Санаатай үйлдэл, эс үйлдэхүйн улмаас болгоомжгүйгээр хохирол, хор уршигт хүргэснийг гэм буруугийн холимог хэлбэр гэнэ” хэмээн заасан нь гэм буруугийн давхардсан

¹⁷ Г.Совд. БНМАУ-ын эрүүгийн эрх зүй дэх гэм буруугийн асуудал. УБ., 1966. 32 дахь тал

¹⁸ С.Нарангэрэл. Монгол Улсын эрүүгийн эрх зүй. Ерөнхий анги. УБ., 1999. 179-181 дэх тал

¹⁹ С.Жанцан. Монгол Улсын эрүүгийн эрх зүйн онол /Гэмт хэргийн тухай сургаал/. I боть. УБ., 2009. 512-516 дахь тал

²⁰ Г.Гантөмөр. Гэмт хэргийн бүрэлдэхүүний ерөнхий онол. УБ., 2003. 220-224 дэх тал

хэлбэр (цаашид “холимог хэлбэр” гэх)-ийн тухай хуульчилсан байх ба тухайн гэмт хэрэг анхнаасаа гэм буруугийн санаатай хэлбэрээр үйлдэгдсэн болохыг илэрхийлж байна.

Харин тухайн заалтын 2 дахь хэсэгт “Энэ хуулийн тусгай ангид гэм буруугийн холимог хэлбэрээр үйлдсэн гэмт хэргийн шинж, оногдуулах ялын төрөл, хэмжээг тусгайлан заана” хэмээн заасан хэдий ч яг ямар гэмт хэрэгт гэдгийг тухайлан заагаагүй байна.

Гэм буруугийн холимог хэлбэрийн агуулга нь гэмт этгээд эхлээд санаатай гэмт хэрэг үйлдэж, үүний үр дүнд хоёр үр дагавар бий болсон байх ба нэг үр дагаварт гэм буруугийн болгоомжгүй хэлбэрээр хандсан сэтгэхүйн харьцаа байна.

Манай улсын эрүүгийн хуульд гэм буруугийн холимог хэлбэрээр үйлдэгддэг гэмт хэргүүд цөөхөн байдаг ба тухайн гэмт хэргүүдийг үндсэн 2 төрөлд хувааж болно.

Нэгдүгээр төрөлд хамаарах гэмт хэргүүд нь материаллаг бүрэлдэхүүнтэй бөгөөд тэдгээрт илрэх нийтлэх шинжид дүгнэлт хийе.

1.Хүний эрүүл эрүүл мэндэд хүнд хохирол санаатай учруулах гэмт хэрэг (Эрүүгийн хуулийн 11.1 дүгээр зүйл).

Энэхүү гэмт хэргийн хувьд нэршлээс эхлээд гэм буруугийн санаатай хэлбэрээр үйлдэгддэг нь тодорхой байна. Мөн гэм буруугийн шууд болон шууд бус санаатай хэлбэрээр үйлдэгдэх боломжтой. Өөрөөр хэлбэл гэмт хэрэг үйлдсэн этгээд өөрийн үйлдэл, эс үйлдэхүйн нийгмийн аюулын шинж чанарыг ухамсарлаж, түүний улмаас нийгэмд аюултай хор уршиг учрах нь зайлшгүй, учрах боломжтойг мэдсэн атлаа тухайн хор уршигийг хүсэж үйлдсэн эсхүл гэмт хэрэг үйлдсэн этгээд өөрийн үйлдэл, эс үйлдэхүйн нийгэмд аюултай шинж чанарыг ухамсарлаж, түүний улмаас нийгэмд аюултай хор уршигийг учрах боломжтойг урьдаас мэдсэн, тийм хор уршигийг учруулахыг урьдаас хүсээгүй боловч, үйлдлээрээ хүргэсэн, эсхүл тухайн хор уршигийг ухамсартайгаар хүлээн зөвшөөрөх эсхүл ялгаваргүй хандсан байхыг ойлгоно.

Гэмт этгээд санаатайгаар хүний эрүүл мэндэд хохирол учруулахыг хүсэх нь тодорхой боловч гагцхүү ямар хохирол учруулах нь тухай бүр харилцан адилгүй байна. Гэвч хүний эрүүл мэндэд хүн хохирол санаатай учруулсны улмаас хүн нас барсан тохиолдолд давхардсан гэм буруугийн асуудал яригдаж эхэлнэ. Энэ тохиолдолд гэмт этгээдийн хохирогчийг алах хүсэл сонирхол үнэхээр байгаагүй болохыг маш нухацтай, нарийн детальтайгаар шалгаж, тогтоох нь чухал. Эс бөгөөс эрүүгийн хуулийн 10.1 дүгээр зүйлд заагдсан хүнийг алах гэмт хэрэг болох нөхцөл бүрдэнэ.

2.Аюултай байдалд орхих, тусламж үзүүлэхгүй байх (Эрүүгийн хуулийн 15.2 дугаар зүйл);

Энэхүү гэмт хэргийн хувьд бүхэлдээ гэм буруугийн холимог хэлбэрийг агуулах бөгөөд гэмт этгээдийн хийсэн үйлдэл нь зөрчлийн шинжийг агуулах ба дангаараа гэмт хэргийн шинжгүй. Харин уг зөрчлийн шинжтэй үйлдлийг зориуд хийж, улмаар эрүүгийн хуульд заасан материаллаг хохирол буюу хохирогчийн эрүүл мэндэд хүндэвтэр хохирол учирсан нөхцөл байдалд гэм буруугийн болгоомжгүй хэлбэрээр хандаж байдаг онцлогтой хэрэг юм. Өөрөөр хэлбэр хийж эхэлсэн зөрчлийн шинжтэй үйлдэлдээ санаатай, харин учирсан үр дагаврыг хүсээгүй буюу түүнд болгоомжгүй хэлбэрээр хандаж нэг гэмт хэргийн шинжийг агуулдаг онцлогтой.

3.Хууль бусаар үр хөндөх (Эрүүгийн хуулийн 15.5 дугаар зүйл);

Хууль бусаар үр хөндөх гэх ойлголт нь гэмт этгээд өөрийн хийж буй үйлдэлдээ санаатай буюу жирэмсэн эмэгтэйн амь бие, эрүүл мэндэд халтай

нөхцөл тогтоогдоогүй байхад хүч хэрэглэж, эсхүл хүч хэрэглэхээр заналхийлж, зориуд үр хөндсөн үйлдэл хийсэн байхыг ойлгох ба Эрүүл мэндийн сайдын 2014 оны 148 дугаар тушаалын хавсралт “ Үр хөндөлтийг зохицуулах журам”-д үр хөндөх хууль ёсны үндэслэлийг заасан байдаг. Харин уг гэмт хэргийн улмаас хохирогч нас барсан бол хүндрүүлэхээр хуульчилсан ба гэмт этгээд уг үр дагаврыг хүсээгүй буюу тухайн үр дагаварт гэм буруугийн болгоомжгүй хэлбэрээр хандсан байдаг онцлогтой.

4.Хүүхдийг асран хамгаалах үүргээ үл биелүүлэх (Эрүүгийн хуулийн 16.11 дүгээр зүйл);

Гэр бүлийн тухай хуулийн 67 дугаар зүйлд заасан журмын дагуу асран хамгаалагч, харгалзан дэмжигчээр тогтоогдсон этгээд нь зориуд мөн хуулийн 67 дугаар зүйлд заагдсан асран хамгаалах үүргийг зориуд биелүүлээгүй эс үйлдэхүйд гэм буруугийн санаатай хэлбэрээр хандсан байх ба үүний улмаас учирсан хүүхдийн эрүүл мэндэд учирсан хүндэвтэр хохиролд гэм буруугийн болгоомжгүй хэлбэрээр хандсан байдлаар холимог хэлбэр илэрч байна.

5.Тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалтын журам зөрчих (Эрүүгийн хуулийн 27.10 дугаар зүйл);

Уг гэмт хэргийн хувьд гэмт этгээдийн хийж эхэлж буй үйлдэл нь дангаараа зөрчлийн шинжийг агуулах ба замын хөдөлгөөний дүрмийг зөрчиж буй үйлдэлдээ гэм буруугийн санаатай хэлбэрээр хандаж, улмаар хүний эрүүл мэндэд хүндэвтэр хохирол учруулж байж л гэмт хэргийн үндсэн шинжийг агуулах ба тухайн учруулсан хохиролд гэм буруугийн болгоомжгүй хэлбэрээр хандсан байдаг онцлогтой.

6.Байлдааны машин жолоодох, ашиглалтын журам зөрчих (Эрүүгийн хуулийн 28.10 дугаар зүйл)

Энэхүү гэмт хэргийн хувьд гэмт этгээдийн хийж эхэлж байгаа үйлдэл нь гэм буруугийн санаатай хэлбэрээр, дангаараа зөрчлийн тухай хуульд заасан үйлдэл байх бөгөөд тухайн үйлдлийг хийсний улмаас хүний эрүүл мэндэд учирсан хүндэвтэр хохиролд гэм буруугийн болгоомжгүй хэлбэрээр хандсан сэтгэхүйн харилцааны үр дүнд тухайн гэмт хэргийн шинж бүрэн хангагдаж байна.

Дээрх 6 төрлийн гэмт хэргүүдэд буюу материаллаг бүрэлдэхүүнтэй гэмт хэргүүдийн хувьд гэм буруугийн холимог хэлбэр нь гэмт этгээдийн хийсэн гэм буруутай үйлдэл, эс үйлдэл болон үр дагаварт бус зөвхөн үр дагаварт хандсан гэм буруугийн хэлбэрээр тодорхойлогдохоор байна. Өөрөөр хэлбэл зарим гэмт хэргийн хувьд 1 үр дагаврыг үүсгэж байхад, зарим гэмт хэрэгт 2 болон түүнээс дээш үр дагаврыг үүсгэх тохиолдол байна. Гэм буруугийн холимог хэлбэрийг энэ үед тодорхойлохдоо учирсан үр дагавар тутамд гэмт этгээдийн хандаж буй сэтгэхүйн харьцааг тодорхойлох нь чухал юм.

Хоёрдугаар төрөлд хамаарах гэмт хэргүүд нь үндсэн бүрэлдэхүүний хувьд хэлбэрийн бүрэлдэхүүнтэй гэмт хэргүүд бөгөөд:

1.Хүчиндэх (Эрүүгийн хуулийн 12.1 дүгээр зүйлийн 4 дэх хэсэг);

Эрүүгийн хуулийн тусгай ангийн 12.1 дүгээр зүйлд заагдсан “Хүчиндэх” гэмт хэрэг нь давхар объектойд гэмт хэрэг бөгөөд үндсэн шууд объект нь хүний бэлгийн эрх, эрх чөлөө, халдашгүй байдал байх ба харин нэмэгдэл шууд объект нь халдлагад өртөгчийн амь нас, эрүүл мэнд байна. Гэмт этгээд хүчиндэх гэмт хэргийг үйлдэхдээ үндсэн шууд объектод гэм буруугийн санаатай хэлбэрээр халдах ба энэ гэмт хэргийн улмаас заавал хохирогчийн амь насанд хохирол учирсан байхыг шаардаггүй билээ.

Харин халдлагад өртөгч нь хүчиндүүлсэнтэй холбоотойгоор өөрийн амийг егүүтгэсэн, нас барах сонголтыг хийсэн тохиолдолд л эрүүгийн хуулийн 12.1

дүгээр зүйлийн 4 дэх хэсэгт заасан хариуцлагыг хүлээх ба харин гэмт этгээд халдлагад өртөгчийг алах туйлын зорилгогүй ч хүчиндэх явцдаа хүч хэрэглэж, тухайн хэрэглэсэн хүч нь амь насыг нь хохироосон тохиолдолд хүнийг гэм буруугийн шууд бус санаатай хэлбэрээр алсан үйлдэл болох ба улмаар 10.1 дүгээр зүйлд зааснаар хариуцлага хүлээлгэнэ.

2.Хүүхдийг согтуурах, мансуурах, донтох байдалд татан оруулах (Эрүүгийн хуулийн 16.2 дугаар зүйлийн 2 дахь хэсэг);

Уг гэмт хэрэг нь давхар объекттой гэмт хэрэг боловч гэмт этгээдийн гэмт этгээд нь хүүхдийг согтуурах, мансуурах, донтох байдалд татан оруулсан үйлдэлдээ гэм буруугийн санаатай хэлбэрээр хандах ба уг гэмт хэргийн улмаас заавал хохирогчийн эрүүл мэнд, амь насанд хохирол учирсан байхыг шаарддаггүй. Харин хүндрүүлэх шинжид заасан хүний эрүүл мэндэд хүнд хохирол учрах эсхүл нас барах хохиролд гэм буруугийн болгоомжгүй хэлбэрээр хандсан байна.

3.Хүүхдийг хаях, төөрүүлэх, тэнүүчлэлд хүргэх (Эрүүгийн хуулийн 16.3 дугаар зүйлийн 2 дахь хэсэг);

Энэхүү гэмт хэрэг нь мөн давхар объекттой гэмт хэрэг ба гэмт этгээд хүүхдийг хаясан, төөрүүлсэн, тэнүүчлэлд хүргэсэн идэвхтэй үйлдлийг гэм буруугийн санаатай хэлбэрээр үйлдэх ба хүндрүүлэх шинжид заасан хохирогчийн эрүүл мэндэд учирсан хүнд хохирол болон нас барсан хохиролд гэм буруугийн болгоомжгүй хэлбэрээр хандсан байдаг.

4.Аюултай хог хаягдал, химийн хорт, аюултай бодисыг хаях (Эрүүгийн хуулийн 20.11 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг)

5.Хууль бусаар эм, эмийн түүхий эд, биобэлдмэл, эмнэлгийн хэрэгслийг үйлдвэрлэх-экспортлох, импортлох-ханган нийлүүлэх, худалдах (20.14 дүгээр зүйлийн 3.1, 3.2);

6.Байгаль орчныг бохирдуулах (Эрүүгийн хуулийн 24.1 дүгээр зүйлийн 2.1, 2.2);

7.Химийн хорт, аюултай бодисыг хууль бус эргэлтэд оруулах (Эрүүгийн хуулийн 24.3 дугаар зүйлийн 2.1, 2.2);

8.Агаарын хөдөлгөөний аюулгүй байдалд халдах (Эрүүгийн хуулийн 27.7 дугаар зүйлийн 3 дахь хэсэг) зэрэг гэмт хэргүүд багтана.

Гэм буруугийн холимог хэлбэрээр үйлдэгддэг гэмт хэргийг бүхэлд нь хэлбэрийн бүрэлдэхүүнтэй гэмт хэрэг хэмээн үзэж болохгүй. Учир нь гэмт хэргийн улмаас материаллаг хохирол, хор уршиг учирсан бол материаллаг гэмт хэрэгт тооцогддог. Гэм буруугийн холимог хэлбэрээр үйлдэгддэг дээрх 8 төрлийн гэмт хэргүүдэд илрэх нийтлэг шинжийг тодорхойлъё:

- Эрүүгийн хуульд зааснаар үндсэн бүрэлдэхүүн нь хэлбэрийн бүрэлдэхүүнтэй гэмт хэрэг байна;
- Нийгэмд аюултай үйлдэл, эс үйлдэл нь зөвхөн гэм буруугийн санаатай хэлбэрээр үйлдэгдсэн байна;
- Тухайн үйлдэл нь нийгмийн аюулын шинжийг нэмэгдүүлж буй хүнд үр дагаврыг бий болгож байгаа тул, хүндрүүлэх шинжтэй байна;
- Тухайн гэмт хэргийг үйлдэх нь санаатай гэмт хэргийн шинж бүхий эрүүгийн эрх зүйн үр дагаварт хүргэдэг зэрэг шинжүүд ажиглагдаж байна.

Дүгнэлт

Дээрх гэмт хэргүүдэд илрэх нийтлэг шинжүүдэд тулгуурлан гэм буруугийн холимог хэлбэр нь дараах шинжтэй байна.Үүнд:

- Гэм буруугийн холимог хэлбэр нь зөвхөн гэм буруугийн санаатай болон болгоомжгүй хэлбэрүүдийн давхардлаар илэрдэг (гэм буруугийн шууд хэлбэр нь шууд бустай, эсхүл хөнгөмсгөөр найдах хэлбэр хайхрамжгүй хандах хэлбэртэй давхардсан байх нь гэм буруугийн давхардалд тооцогдохгүй);
- Гэм буруугийн холимог хэлбэртэй гэмт хэргүүдэд байх гэм буруугийн болгоомжгүй хэлбэр нь зөвхөн хүндрүүлэх үр дагаварт хамааралтай байна;
- Гэм буруугийн холимог хэлбэр нь зөвхөн гэмт хэргийн хүндрүүлэх нөхцөл байдлуудад илэрнэ;
- Гэм буруугийн холимог хэлбэрээр үйлдэгддэг гэмт хэргүүдийн үндсэн бүрэлдэхүүнд заасан үйлдэл нь зөвхөн санаатай үйлдэл байна.

Монгол Улсын Эрүүгийн хуульд заасан гэм буруугийн холимог хэлбэрээр үйлдэгддэг гэмт хэргүүдийг дан гэм буруугаар үйлдэгддэг гэмт хэргээс ялгах шинжийг зөв тодорхойлсноор эрүүгийн эрх зүйн шударга ёсны, гэм буруугийн зарчимд тулгуурлан ялыг ялгамжтай оногдуулах, оногдуулж буй ялын төрөл хэмжээг зөв тодорхойлоход чухал ач холбогдолтой байна.

Үүнээс дүгнэхэд, гэм буруугийн холимог хэлбэр гэдэг нь гэмт этгээд өөрийн хэрэгжүүлсэн, үйлдсэн нийгэмд аюултай үйлдэлдээ санаатай, харин түүний улмаас учрах хохирол, хор уршигт болгоомжгүй хандсан гэм буруугийн онцлог байдлаар гэмт хэргийг үйлдсэн байхыг ойлгохоор байна.

Ашигласан материал

- Совд, Г. БНМАУ-ын эрүүгийн эрх зүй дэх гэм буруугийн асуудал., УБ., 1966.
- Нарангэрэл, С. Монгол Улсын эрүүгийн эрх зүй: Ерөнхий анги. УБ., 1999
- Жанцан, С. Монгол Улсын эрүүгийн эрх зүйн онол., УБ., 2009
- Гантөмөр, Г. Гэмт хэргийн бүрэлдэхүүний ерөнхий онол. УБ., 2011
- Гантулга С, Энхболд Б. Эрүүгийн эрх зүй: Тусгай анги. /нэмж засварласан 2 дахь хэвлэл/. УБ., 2020

ХҮҮХДИЙН ЭСРЭГ БЭЛГИЙН ХҮЧИРХИЙЛЛИЙН ГЭМТ ХЭРЭГТЭЙ ТЭМЦЭХ ОЛОН УЛСЫН ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ, НИЙЦЭЛ

REGULATION AND COMPLIANCE WITH INTERNATIONAL LAW TO COMBAT CRIMES OF SEXUAL VIOLENCE AGAINST CHILDREN

Э.Товуудорж
ДХИС-ийн докторант,
цагдаагийн хурандаа

Товч агуулга: Хүүхдийн эсрэг бэлгийн хүчирхийллийн гэмт хэрэгтэй тэмцэх чиглэлээр баталсан олон улсын гэрээ, конвенцын зохицуулалт, түүнийг үндэсний хууль тогтоомжид нийцүүлэх хэрэгцээ, шаардлагын талаар дурдсан.

Түлхүүр үгс: Хүүхэд, олон улсын гэрээ, конвенц, бэлгийн хүчирхийлэл, үндэсний хууль тогтоомж.

Abstract: It is mentioned about the regulation of international agreements and conventions adopted in the field of combating the crime of sexual violence against children and the need and requirements for their compliance with national legislation.

Keywords: Children, international agreements, conventions, sexual violence, national laws.

Хүүхдийн нийгмийн бүхий л орчинд хүчирхийлэл, дарамт, мөлжлөг, үл хайхрах байдлаас ангид байлгах, тэдний хамгаалагдах эрхийг хуулиар баталгаажуулах бодлого хэрэгжүүлснээр манай улс хүүхдийн эсрэг хүчирхийллийг бүхий л орчинд хориглосон дэлхийн 49 дэх улс болсон.²¹

Монгол Улс НҮБ-ын гишүүн орон болсноос хойших 63 жилийн хугацаанд тус байгууллагаас гаргасан хүний эрхийн 50 гаруй олон улсын гэрээ, конвенцод нэгдэн орж, соёрхон баталсан байна. Үүнээс цөөнгүйг хүүхдийн эрхийг хамгаалах, хүүхдийн эсрэг бэлгийн хүчирхийллийн гэмт хэрэгтэй тэмцэх чиглэлээр баталсан олон улсын гэрээ, конвенц эзэлдэг.

НҮБ-аас хүүхдийг эрхийг хамгаалах, хүүхдийн эсрэг бэлгийн хүчирхийллийн гэмт хэрэгтэй тэмцэх чиглэлээр идэвхтэй үйл ажиллагаа явуулж, олон улсад нийтээр хэрэглэх стандарт дүрэм, журам, гэрээ, конвенциудыг²² цөөнгүйг баталсан. Тухайлбал,

- НҮБ-ын Дүрэм²³;
- Хүний эрхийн Түгээмэл тунхаглал²⁴;
- Хүүхдийн эрхийн тухай конвенц²⁵;
- Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пакт²⁶;

²¹ Монгол Улсын Засгийн газрын Хүүхдийн хөгжил, хамгааллын үндэсний хөтөлбөр.УБ., 2017. 270 дугаар тогтоолын хавсралт

²² НҮБ-ын Ерөнхий Ассамблейн эсхүл НҮБ-ын байгууллагын баримт бичгүүд, шийдвэр нь бие даасан олон улсын баримт бичгүүдийн төрөлд багтдаг.

²³ 1945 оны 6 дугаар сарын 26-нд АНУ-ын Сан-Франциско хотноо баталж, 1945 оны 10 дугаар сарын 24-нд хүчин төгөлдөр болсон. БНМАУ 1961 оны 10 дугаар сарын 27-нд хүлээн зөвшөөрч нэгдсэн.

²⁴ НҮБ-ын Ерөнхий Ассамблейн 1946 оны 12 дугаар сарын 10-ны 217/A/III/ тоот тогтоолоор баталж, түүний бүх заалтыг дагаж мөрдөхийг гишүүн улсуудад уриалжээ.

²⁵ НҮБ-ын Ерөнхий Ассамблей 1989 оны 11 дүгээр сарын 20-ны өдөр баталж, 1990 оны 9 дүгээр сарын 2-ны өдрөөс хүчин төгөлдөр болсон. 1990 онд БНМАУ соёрхон баталсан.

²⁶ НҮБ-ын Ерөнхий Ассамблейн 1966 оны 12 дугаар сарын 16-ны 2200A (XXI) тоот тогтоолоор баталж, 1976 оны 3 дугаар сарын 23-ны өдрөөс хүчин төгөлдөр болсон. БНМАУ 1974.11.18-нд соёрхон баталсан.

- Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн тухай олон улсын пакт²⁷;
- Хүүхдийг худалдах, хүүхдийн биеийг үнэлэх, хүүхдийг садар самуунд сурталчлахын эсрэг Хүүхдийн эрхийн тухай конвенцид оруулах нэмэлт протокол²⁸;
- НҮБ-ын Үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэргийн эсрэг конвенц²⁹;
- Дээрх конвенцийн нэмэлт болох Хүн, ялангуяа эмэгтэйчүүд, хүүхдийг худалдаалахаас урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, шийтгэх тухай протокол³⁰ зэргийг дурдаж болно.

Эдгээр дүрэм, журам, гэрээ, конвенциудад хүүхдийн эсрэг бэлгийн хүчирхийллийн гэмт хэрэгтэй тэмцэх чиглэлээр улсуудын Засгийн газрын хүлээх үүргээс гадна хүүхдийн эсрэг бэлгийн хүчирхийллийн гэмт хэргийг шууд хориглосон заалтууд тодорхойлогдсон байдаг.

НҮБ-ын Дүрмийн 1 дүгээр зүйлд тус байгууллагын зорилгыг “Олон улсын энх тайван, аюулгүй байдлыг сахиулах, энэ зорилгын үүднээс энх тайванд учрах аюул заналыг сэрэмжлэн зайлуулах, түрэмгийлэл буюу энх тайвныг бусниулах бусад явуулгыг дарахын тулд үр нөлөөтэй хамтарсан арга хэмжээ авах, олон улсын маргаан буюу энх тайвныг бусниулахад хүргэж болзошгүй байдлыг шударга ёс, олон улсын эрх зүйн зарчмын дагуу эв зүйгээр зохицуулах буюу шийдвэрлэж байх,

Улс үндэстний хооронд улс түмний тэгш эрх, өөртөө засан тохинох зарчмыг хүндэтгэсэн найрсаг харилцааг хөгжүүлэх, түүнчлэн бүх нийтийн энх тайвныг бэхжүүлэх үүднээс бусад зохистой арга хэмжээ авч байх, эдийн засаг, нийгэм, соёл болон хүмүүнлэгийн шинж чанартай олон улсын асуудлыг шийдвэрлэх, арьсны өнгө, хүйс, хэл шашин шүтлэгийг үл ялган хүний эрх, хэн бүхний үндсэн эрх чөлөөг хүндэтгэх явдлыг хөхүүлэн дэмжих, хөгжүүлэх талаар олон улсын хамтын ажиллагааг хэрэгжүүлэх, эдгээр нийтлэг зорилгыг хэрэгжүүлэхэд улс үндэстний үйл ажиллагааг уялдуулан зохицуулах төв болж байх”³¹ гэж заасан.

НҮБ-аас баталж буй хүний эрхийг хамгаалах баримт бичгүүд нь ихэнхдээ хүний эрхийн гол асуудлууд, хүн хууль ёсны болон жам ёсны эрхээ эдлэх бүх талын баталгааг бий болгох дэлхийн хүн амын аюулгүй байдалд заналхийлж буй мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлт, терроризм, хүн худалдаалах, бэлгийн мөлжлөг болон галт зэвсэг хууль бусаар худалдаалах зэрэг үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэрэгтэй тэмцэх, энэхүү тэмцэлд олон улсын хамтын ажиллагааг идэвхжүүлэхэд чиглэгдэж ирсэн. НҮБ-ын Дүрэмд “...хүний эрхийг хамгаалах, хөхүүлэн дэмжихэд улс орнуудын хамтын ажиллагааг хөгжүүлэхийг чухалчилна”, Хүний эрхийн Түгээмэл тунхаглалын 1 дүгээр зүйлд “Хүн бүр төрөхөөсөө эрх чөлөөтэй, нэр төр, эрхийнхээ хувьд адил тэгш байна”, 4 дүгээр зүйлд “Хэнийг ч боолчлох буюу бусдын эрхшээлд байлгах ёсгүй.”³² гэж заасан нь бэлгийн мөлжлөг, тэр дундаа хүүхдийн эсрэг бэлгийн мөлжлөгийн гэмт хэрэгтэй тэмцэх ажиллагааны эх суурь болж өгсөн.

НҮБ-аас баталж буй хүний эрхийг хамгаалах баримт бичгүүд нь ихэнхдээ хүний эрхийн гол асуудлууд, тэр дундаа бэлгийн мөлжлөгийг бүрэн хориглох, хүн

²⁷ НҮБ-ын Ерөнхий Ассамблейн 1966 оны 12 дугаар сарын 16-ны 2200А (XXI) тоот тогтоолоор баталж, 1976 оны 1 дүгээр сарын 3-ны өдрөөс хүчин төгөлдөр болсон. БНМАУ 1968.01.05-нд гарын үсэг зурж, 1974.11.18-нд соёрхон баталсан.

²⁸ НҮБ-ын Ерөнхий Ассамблей 2000 онд баталж, 2002 онд Монгол Улс соёрхон баталсан.

²⁹ НҮБ-ын Ерөнхий Ассамблей 2000 онд баталж, 2008 онд Монгол Улс соёрхон баталсан.

³⁰ НҮБ-ын Ерөнхий Ассамблей 2000 онд баталж, 2008 онд Монгол Улс соёрхон баталсан.

³¹ Нэгдсэн үндэсний байгууллагын дүрэм. 1945. 1 дүгээр зүйл

³² Д.Баярсайхан, Т.Золбоо. Олон Улсын гэрээ, хэлэлцээрийн эмхэтгэл. УБ., 2012. 8 дахь тал

хууль ёсны болон жам ёсны эрхээ эдлэх бүх талын баталгааг бий болгох, бэлгийн мөлжлөгийн улмаас хохирсон хүнд учирсан хохирлыг хамгийн үр ашигтай байдлаар нөхөн сэргээх арга замыг хангахад чиглэгдэж ирсэн.

Хүний эрхийн Түгээмэл тунхаглалыг батлан гаргасны дараа Хүний эрхийн олон улсын билл³³ хэмээн нэрлэгддэг 5 баримт бичгийн нэг болох Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пактын 8 дугаар зүйлд *“...Хэнийг ч бусдын эрхшээлд байлгаж болохгүй. Хэнийг ч албадан хөдөлмөрлүүлэх буюу заавал ажилд тулгаж болохгүй”*³⁴, 24 дүгээр зүйлд *“Аливаа хүүхэд арьс үндэс, арьсны өнгө, хүйс, хэл, шашин шүтлэг, үндэсний буюу нийгмийн гарал, хөрөнгө чинээ болон төрсөн байдлаар алагчлагдахгүйгээр өөрийн гэр бүл, нийгэм, төрийн зүгээс насанд хүрээгүйнхээ хувьд шаардлага бүхий хамгаалалт эдлэх эрхтэй.”* гэсэн заалт нь хүүхдийн эсрэг бэлгийн мөлжлөгийн гэмт хэрэгтэй тэмцэх ажиллагааны эрх зүйн үндсийг бүрдүүлж байна.

Олон улсын хэмжээнд бэлгийн мөлжлөг, бэлгийн хүчирхийллийн гэмт явдалтай тэмцэх талаар явуулж ирсэн үйл ажиллагааны өрнөлөөс үзэхэд, эхэн үедээ дэлхийн улсууд дотооддоо энэ төрлийн гэмт явдалтай тэмцэж, хориглож байсан бол сүүлийн жилүүдэд дэлхий нийтээр энэ гэмт явдлын хор уршгийг хүлээн зөвшөөрч, улс орнууд үндэсний хууль тогтоомжийг олон улсын нийтийн эрх зүйн жишигт нийцүүлж, бэлгийн мөлжлөг, бэлгийн хүчирхийллийн зохион байгуулалттай гэмт хэрэгтэй тэмцэх олон улсын хамтын ажиллагааг дэмжсэн.

Хүүхдийн эрхийн олон улсын конвенц³⁵-ийн 19 дүгээр зүйлд *“Оролцогч улсууд эцэг эх, хууль ёсны асран хамгаалагч, хүүхдийг асран халамжилж байгаа бусад хүн хүүхдийг бие бялдар, сэтгэл зүйн хувьд бүхий л хэлбэрээр дарамтлах, доромжлох, сөргөөр ашиглах, хайр халамжгүй орхих, зүй бусаар хандах, хэрцгийгээр харьцах, албадан хөдөлмөрлүүлэх буюу бэлгийн хүчирхийллээс хамгаалах зорилгоор хууль тогтоох, захиргааны, нийгмийн болон гэгээрлийн бүхий л шаардлагатай арга хэмжээ авна.”*, 34 дүгээр зүйлд *“Оролцогч улсууд хүүхдийг бэлгийн замаар ашиглан мөлжих бүхий л хэлбэрээс хамгаалах үүрэг хүлээнэ. Энэ зорилгоор оролцогч улсууд дараах зүйлээс урьдчилан сэргийлэхэд чиглэсэн үндэсний, хоёр талт болон олон талт шаардлагатай бүх арга хэмжээг авна: а/ хүүхдийг бэлгийн хууль бус аливаа ажиллагаанд татан оролцуулах буюу шахалт үзүүлэх, б/хүүхдийн биеийг үнэлүүлэх буюу бэлгийн хууль бус бусад ажиллагаанд ашиглан мөлжих в/хүүхдийг садар самуун үзүүлбэр болон түүнийг сурталчилсан материалд ашиглах”*, 35 дугаар зүйлд *“Оролцогч улсууд хүүхдийг аливаа зорилго хэлбэрээр хулгайлах, худалдах буюу хил дамжуулан худалдах явдлаас урьдчилан сэргийлэхэд чиглэсэн үндэсний, хоёр талт болон олон талт шаардлагатай бүх арга хэмжээг авна”*, 36 дугаар зүйлд *“Оролцогч улсууд хүүхдийн аж байдлыг аливаа байдлаар хохироох аливаа бусад хэлбэрийн мөлжлөгөөс хүүхдийг хамгаална”*³⁶ гэж тус тус заасан.

Оролцогч улсууд хүүхдийг бэлгийн мөлжлөгт ашиглах бүхий л хэлбэрээс хамгаалах үүрэг хүлээсэн байна. Монгол Улс дээрх конвенцод нэгдэн орсноороо хүүхдийн эсрэг бэлгийн мөлжлөгийн болон бусад төрлийн гэмт хэрэгт өртөхөөс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, гэмт хэрэгт өртсөн хүүхдийг хамгаалах үүргийг олон улсын хамтын нийгэмлэгийн өмнө хүлээсэн байна.

³³ Хүний эрхийн Олон улсын биллд Хүний Эрхийн Түгээмэл тунхаглал, Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн тухай олон улсын пакт, Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пакт, Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пактын I нэмэлт “Хувь хүний мэдээллийг хүлээн авч шийдвэрлэх тухай” протокол, II нэмэлт “Цаазаар авах ялыг халах тухай” протокол хамаардаг.

³⁴ Д.Баярсайхан, Т.Золбоо. Олон Улсын гэрээ, хэлэлцээрийн эмхэтгэл. УБ., 2012. 14 дэх тал

³⁵ Хүүхдийн эрхийн олон улсын конвенцийн 19, 34 дүгээр зүйл

³⁶ Д.Баярсайхан, Т.Золбоо. Олон Улсын гэрээ, хэлэлцээрийн эмхэтгэл. УБ., 2012. 55 дахь тал

Хүүхдийг худалдах, хүүхдийн биеийг үнэлэх, хүүхдийг садар самуунд сурталчлахын эсрэг хүүхдийн эрхийн тухай конвенцод оруулах нэмэлт протокол³⁷-ын 8 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт *“Оролцогч улсууд энэхүү протоколоор хориглосон гэмт хэрэгт өртөж хохирогч болсон хүүхдийн эрх ашиг, сонирхлыг эрүүгийн шүүн таслах бүх ажиллагааны үед дор дурдсан арга замаар хамгаалах талаар зохих арга хэмжээ авна:*

(а) гэмт хэрэгт өртөж хохирогч болсон хүүхдийн эмзэг байдлыг хүлээн зөвшөөрч, тэдний онцгой шаардлага, ялангуяа гэрч болохынх нь хувьд тэдгээрийн онцгой шаардлагыг хүлээн зөвшөөрсөн журам батлах;

(b) хохирогч болсон хүүхдэд тэдний эрх, үүрэг болон шүүн таслах ажиллагааны агуулга, хугацаа болон явц, уг хэргийн талаарх шийдвэрийн тухай мэдээлэх;

(с) шүүн таслах ажиллагааны явцад үндэсний хууль тогтоомжийн байцаан шийтгэх хэм хэмжээний дагуу хохирогч хүүхдийн санаа бодол, шаардлага болон асуудлыг тэдгээрийн хувийн ашиг сонирхол хөндөгдсөн үед танилцуулж, хэлэлцүүлэх боломж олгох;

(d) шүүн таслах ажиллагааны явцад хохирогч хүүхдэд зохих дэмжлэг болох үйлчилгээ үзүүлэх;

(е) шаардлагатай үед хохирогч хүүхдийн амь нас, нэр төрийг хамгаалах болон үндэсний хууль тогтоомжийн дагуу хохирогч хүүхдийн нэрийг мэдэгдүүлсэн мэдээллийг зүй бусаар тараах явдлаас зайлсхийх арга хэмжээ авах;

(f) хохирогч хүүхэд, түүнчлэн түүний гэр бүлийнхний болон тэдний өмнөөс гэрчлэгчдийг аливаа сүрдүүлэг, өшөө хонзонгоос зохих үед хамгаалах арга хэмжээ авах;

(g) хохирогч хүүхдэд нөхөн төлбөр олгох тухай шүүхийн тогтоол болон шийдвэр гүйцэтгэлийг онцын шаардлагагүйгээр хойшлуулахаас зайлсхийнэ гэж заасан.

Үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэргийн эсрэг НҮБ-ын конвенцод хүн, ялангуяа эмэгтэйчүүд, хүүхэд худалдаалахаас урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, шийтгэх тухай протоколын 5 дугаар зүйлд тодорхойлсон гэмт хэргүүдийг үндэстэн дамнасан шинж чанартай, зохион байгуулалттай гэмт бүлэглэл үйлдсэн бол Үндэстэн зохион байгуулалттай гэмт хэргийн эсрэг НҮБ-ын конвенц үйлчлэхээр тодорхойлсон.

Энэхүү шинжүүд нь олон улсын гэрээ, конвенц, 2 ба түүнээс дээш улсын хамтын ажиллагаа болон үндэсний хууль тогтоомжийн зохицуулалт, шүүх эрх мэдлийн болон мөрдөн шалгах, хууль сахиулах байгууллагуудын хамтын ажиллагаанаас үр дүнгээс хамаарч хүн худалдаалах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, илрүүлэх, таслан зогсоох болон нотлох үйл ажиллагааны үр дүн цаашилбал хэргийн шийдвэрлэлтэд нөлөөлдөг байна.³⁸

НҮБ-ын Эдийн засаг, нийгмийн зөвлөл нь олон улсын хэмжээнд хүлээн зөвшөөрөгдсөн хэм хэмжээний хүрээнд 2005 оны 7 дугаар сарын 22-ны өдрийн 2005/20 дугаар тогтоолоор баталсан “Гэмт хэргийн хохирогч, гэрч болсон хүүхдэд холбогдох эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны талаар баримтлах удирдамж” нь НҮБ-аас баталсан хэм хэмжээ стандартуудын дараах зорилтыг хангахад чиглэсэн байна. Үүнд:

-Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны гэмт хэргийн хохирогч, гэрч хүүхдийн эрхийг дээдлэн хамгаалахдаа /түүнчлэн, хүүхдийг асрамжид авах,

³⁷ <https://www.legalinfo.mn/law/details/1274>

³⁸ Гантулга.С. Лхагварачаа.Б. Арвинтариа.Н. Энхчимэг.П. Золжаргал.Г. “Бэлгийн хүчирхийллийн хохирогч хүүхдэд туслалцаа үзүүлэх нь” цагдаагийн алба хаагчийн гарын авлага. УБ., 2022. 9 дэх тал

гэр бүл салалт, хүүхэд үрчлэлт, цагаачлал зэрэг хүүхэд хамгаалалт шаардсан бусад асуудлаар мөн хамаарна/ дотоодын хууль журам, практик үйл ажиллагааг бий болгох, нэгэнт бий болсныг нь боловсронгуй болгох,

-Гэмт хэргийн хохирогч, гэрч хүүхдийн эрхийн хамгаалалтай холбоотой хууль тогтоомж, журам, бодлого, хөтөлбөр боловсруулах, тэдгээрийн хэрэгжилтийг хангахад төрийн болон бус байгууллага ялангуяа хүүхдийн эрхийг хамгаалах байгууллагын зарчмыг тодорхойлох, албан тушаалтан, мэргэжлийн хүний үйл ажиллагаанд чиглэл өгөх,

-Гэмт хэргийн хохирогч, гэрч хүүхэд /түүнчлэн, гэрчийн мэдүүлэг өгөх, мэдээлэл өгөх хүсэлгүй, боломжгүй хүүхэд, гэмт хэрэгт сэжиглэгдсэн хүүхэд, бусдын золиос болсон сүрдүүлэгт өртсөн, хууль бус үйлдэл хийхээс өөр аргагүй байдалд орсон, эсвэл дээрх үйлдлийг хүчинд автаж хийсэн хүүхдийг хамгаалах асуудал тусгагдана/-тэй харьцахтай тэдний сэтгэл санаа, зовлон бэрхшээлийг ойлгох талаар хүүхдийн хууль ёсны эрх ашиг сонирхлыг хамгаалагчид дэмжлэг үзүүлэх зэрэг зорилтыг хангахад чиглэсэн.

Хүүхдийн эрхийн тухай конвенц, Гэмт хэргийн хохирогч, гэрч хүүхдэд холбогдох эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны талаар баримтлах удирдамжид дараах хүний эрхүүдэд онцгой анхаарал хандуулах зөвлөсөн байна.

Олон улсын хамтын нийгэмлэг шударга шүүх ажиллагаа, тэр дундаа эрүүгийн эрх зүйн процесс дахь стандарт болох олон баримт бичгийг боловсруулан баталсан байдаг. Монгол Улс эрх зүйн тогтолцоогоо өөрөө тодорхойлж, төлөвшүүлэх бүрэн эрхтэй ч хүний эрхийг дээдэлсэн ардчилсан зарчмыг нэгэнтээ сонгосон нь дээр дурдсан олон улсын стандартад үндэсний хууль тогтоомжийг нийцүүлэх нь нэг талаасаа зүй ёсны, нөгөө талаасаа зайлшгүй шаардлага юм.

Монгол Улс 1990 онд НҮБ-ын Хүүхдийн эрхийн конвенцод, 2002 онд Хүүхдийг бэлгийн мөлжлөгөөс хамгаалах тухай конвенцод тус тус нэгдэн орсон. Улмаар Монгол Улсын Их Хурлаас баталсан Хүүхдийн эрхийн тухай хууль, Хүүхэд хамгааллын тухай хууль, Гэр бүлийн тухай хууль, Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль, Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хууль, Эрүүгийн хууль болон Зөрчлийн тухай хуульд хүүхэд хамгааллын тогтолцоог бэхжүүлэх эрх зүйн орчинг бүрдүүлэх нөхцөлийг бий болгосон. Тус хуулиудын хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд манай улс бэлгийн хүчирхийллийн хохирогч болсон хүүхдийг хамгаалах, аюулгүй байдлыг хангах, эрүүл мэнд, сэтгэл зүй, нийгмийн халамжийн тусламж үйлчилгээ үзүүлэх, гэр бүлийн нөхцөл байдлын үнэлгээ хийх зэрэг хамгааллын үйлчилгээний харилцааг зохицуулсан 50 гаруй журам, стандарт, эрх зүйн баримт бичгийг батлан хэрэгжүүлж байна.

Монгол Улс Хүүхдийн эрхийн конвенцод нэгдэн орсноор үндэсний хууль тогтоомжид бага насны хүүхдийг хүчиндэх гэмт хэрэгтэй тэмцэхтэй холбоотой эрх зүйн зохицуулалтыг хуульчилсан. Тухайлбал, Монгол Улсын Үндсэн хуулийн Арван есдүгээр зүйлийн 1 дэх хэсэгт "...Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц эдийн засаг, нийгэм, хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх, хүний эрх, эрх чөлөөг зөрчихтэй тэмцэх, хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх үүргийг иргэнийхээ өмнө хариуцна.", Гучин наймдугаар зүйлийн 2.7-д "Засгийн газар ... дараах үндсэн бүрэн эрхийг хэрэгжүүлнэ: хүний эрх, эрх чөлөөг хамгаалах, нийгмийн хэв журмыг бэхжүүлэх, гэмт хэрэгтэй тэмцэх арга хэмжээ авч хэрэгжүүлэх"³⁹ гэж тус тус заасан байна.

Доктор, профессор Б.Чимид "...Үндсэн хуульд томъёологдоогүй боловч Монгол Улсын олон улсын гэрээнд тодорхойлсон хүний эрх, эрх чөлөөг манай

³⁹ Монгол Улсын Үндсэн хууль// Төрийн мэдээлэл. УБ., 1992. №1

оронд байгаа бүх хүн нэгэн адил эдлэх, хамгаалуулах боломжтой"⁴⁰ хэмээн тодорхойлсны дагуу хүний халдашгүй чөлөөтэй байх эрхийг хангах, бэлгийн хүчирхийлээс хамгаалах боломжийг улам бүр нэмэгдүүлэх, зарим талаараа урьдчилан сэргийлэх ач холбогдолтой гэж үзсэний учир дээрх олон улсын гэрээ, конвенц, түүний агуулга хэм хэмжээг нарийвчлан авч үзсэн болно.

Хүүхдийн эсрэг бэлгийн хүчирхийллийн гэмт хэрэгтэй тэмцэх олон улсын эрх зүйн зохицуулалтыг судалж үзэхэд, Монгол Улс НҮБ-аас энэ төрлийн гэмт хэрэгтэй тэмцэх чиглэлээр баталсан цөөнгүй олон улсын гэрээ, конвенцид нэгдэн орж, соёрхон баталсан бөгөөд тэдгээрийн хэм хэмжээ, үзэл баримтлал, зарчмыг үндэслэн хууль тогтоомжид тусган хэрэгжүүлэх шаардлагатай байдал тогтоогдов.

Ашигласан материал

Нэг. Монгол Улсын хууль тогтоомж

- Монгол Улсын Үндсэн хууль. //Төрийн мэдээлэл. УБ., 1992. №1
- Монгол Улсын эрүүгийн хууль. //Төрийн мэдээлэл. УБ., 2002. №5
- Эрүүгийн хууль.//Төрийн мэдээлэл. УБ., 2016. №7
- Монгол Улсын эрүүгийн байцаан шийтгэх хууль. //Төрийн мэдээлэл. УБ., 2002. №6
- Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль. //Төрийн мэдээлэл. УБ., 2017. №23
- Үндэсний аюулгүй байдлын тухай хууль. //Төрийн мэдээлэл. 2002. №3
- Хүн худалдаалахтай тэмцэх тухай хууль. //Төрийн мэдээлэл. УБ., 2012. №8
- Садар самуун явдалтай тэмцэх тухай хууль. //Төрийн мэдээлэл. УБ., 1998. №3

Хоёр. Олон улсын эрх зүйн баримт бичиг

- 1949 оны НҮБ-ын Хүнийг дамжуулан худалдах болон бусдын биеийг үнэлүүлэн ашиглахыг хориглох тухай олон улсын конвенц
- 1956 оны НҮБ-ын Боолчлол, боолын худалдаа болон боолчлолтой адилтгах ёс, заншлыг устгах тухай нэмэлт конвенц
- 1966 оны Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пакт
- 1966 оны Эмэгтэйчүүдийг алагчлах бүх хэлбэрийг устгах тухай конвенц
- 1989 оны Хүүхдийн эрхийн тухай конвенц
- 1999 оны Хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэрийг устгах тухай Олон Улсын Хөдөлмөрийн байгууллагын 182 дугаар конвенц
- 2000 оны НҮБ-ын Үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэргийн эсрэг конвенц, конвенцийн нэмэлт Хүн, ялангуяа эмэгтэйчүүд, хүүхдийг худалдаалахаас урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, шийтгэх тухай протокол

Гурав. Нэг сэдэвт бүтээл, сурах бичиг, гарын авлага

- Баярсайхан Б., Золбоо Т. Олон Улсын гэрээ, хэлэлцээрийн эмхэтгэл. УБ., 2012
- Болдбаатар Ж., Төрмандах З. Монгол Улсын эрүүгийн эрх зүй ерөнхий, тусгай анги. УБ., 2008
- Гантулга С, Энхболд Б. Эрүүгийн эрх зүй: Тусгай анги (Сурах бичиг). /нэмж засварласан 2 дахь хэвлэл/. УБ., 2020
- Гантулга С., Оюунболд Г., Тамир Д. нар. Хүүхдийн хөдөлмөрийн болон бэлгийн мөлжлөгийн гэмт хэрэг. УБ., 2010
- Гантулга С, Арвинтариа Н нар. Бэлгийн хүчирхийллийн хохирогч хүүхдэд туслалцаа үзүүлэх нь /Цагдаагийн алба хаагчдын гарын авлага/. Хүний

⁴⁰ Б.Чимид. Үндсэн хуулийн үзэл баримтлал. УБ., 2002. 92 дахь тал

эрхийн Үндэсний Комисс, Цагдаагийн ерөнхий газар, Дотоод хэргийн их сургууль, НҮБ-ын Хүүхдийн сан. УБ., 2022

- Чимид Б. Үндсэн хуулийн үзэл баримтлал. УБ., 2002

Дөрөв. Судалгааны тайлан

- "Гадаадын зарим орны хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх хууль тогтоомжид хийсэн харьцуулсан судалгаа. Улсын Дээд Шүүхийн судалгааны төв, Хүний аюулгүй байдлын судалгааны төв. УБ., 2010
- Хүн худалдаалахтай тэмцэх нөхцөл байдлын тайлан (2019-2021). Хууль зүй, дотоод хэргийн яам, АНУ-ын Төрийн Департамент, Дэлхийн зөн, Азийн сан, IRIM байгууллага. УБ., 2022
- Бэлгийн хүчирхийллийн хохирогч хүүхдийн эрх зүйн байдлын талаарх олон улсын болон үндэсний хууль тогтоомжид хийсэн дүн шинжилгээ. Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комисс, НҮБ-ын Хүүхдийн сан. УБ., 2022

КРИМИНОЛОГИЙН ОНОЛ, ПРАКТИКИЙН ТУЛГАМДСАН АСУУДАЛ

АМИА ХОРЛОХ ҮЗЭГДЛИЙН ШАЛТГААН, НӨХЦӨЛ, ТҮҮНД НӨЛӨӨЛӨХ ХҮЧИН ЗҮЙЛИЙГ СУДАЛСАН НЬ

STUDYING THE CAUSES AND INFLUENCING FACTORS OF SUICIDE

В.Номинчулуун

*ДХИС-ийн Эрдэм шинжилгээний хүрээлэнгийн
Гэмт явдал, цагдаа, дотоодын цэрэг судлалын төвийн
Эрдэм шинжилгээний ажилтан-багш, цагдаагийн хошууч*

Товч агуулга: Амиа хорлох үзэгдлийн ойлголт, шалтгаан, нөхцөл, урьдчилан сэргийлэх ажлын талаар гадаадын зарим улсын туршлага, түүнийг өөрийн улсад нэвтрүүлэх боломжийг судалж, дүгнэлт, санал боловсруулахыг зорьсон.

Abstract: This study was conducted in order to make conclusions and suggestions based on the experience of foreign countries and their research on the understanding, causes, and prevention of suicide.

Түлхүүр үгс: Амиа хорлох, шалтгаан нөхцөл, хүчин зүйл, урьдчилан сэргийлэх.

Keywords: Suicide, causes, factors, prevention.

Амиа хорлох үзэгдэл нь зуун зууны олон сэтгэгчдийн хувьд анхаарлаа хандуулж, оюун санаагаа чиглүүлэх асуудлуудын нэг нь байсаар ирсэн. Францын социологич Э.Дюркгейм (1897) нь хүн амын дундах амиа хорлох үзэгдлийг анх удаа шинжлэх ухааны үүднээс судалснаар энэ үзэгдэлтэй холбоотой асуудлууд нь судлаачдын анхаарлыг татах болсон билээ.

Амиа хорлох гэдэг нь хүн санаатайгаар өөрийн амьдралаас татгалзан амиа таслах төрх үйлийг хэлэх⁴¹ бөгөөд ёс зүй, хууль эрх зүй, нийгэм ба сэтгэл судлалын аль алинд нь хамаарагдах, олон талаас нь судлах шаардлагатай, анхаарал татсан, ёс зүйн хувьд нээлттэй асуудлын нэг юм.

Оксфордын Англи хэлний толь бичигт 1662 онд Эдвард Филипп “Дэлхийн дахинаа хэрэглэгдэж эхэлсэн шинэ үгс” хэсэгт “Suicidium” хэмээх үгийг “хүн өөрийгөө хөнөөх төрх үйл” гэж тайлбарлан оруулжээ.

Гэвч 1971 онд Их Британийн утга зохиолын шүүмжлэгч Алфред Алварез-ын мэдэгдсэнээр анх Францын эмч, гүн ухаантан Sir Thomas Browne 1642 онд хэвлүүлсэн “Religio Medici” хэмээх бүтээлдээ латин гаралтай “sui”- өөрийгөө; “caedere”-хөнөөх гэсэн утгатай үгийг хэрэглэсэн нь “suicide” хэмээх үгийг албан ёсоор шинжлэх ухаанд оруулж “амиа хорлох буюу өгүүтгэх” гэсэн утгаар хэрэглэх болсон.

Амиа хорлох гэдэг үгийг хэрэглэхээс илүү энэ төрх үйлийг ёгт эсвэл цээрлэсэн агуулгатай шууд бус утга бүхий үгээр илэрхийлж байсан. Тухайлбал өөрийгөө устгах, өөрийгөө хөнөөх, өөрийгөө хядах, өөрийгөө үхүүлэх (sibi mortem consciencere), өөрийгөө хүчирхийлэх (vim sibi inferre) эсвэл өөрийн гараар өөрийгөө хөнөөх (sui manu cadere) гэх зэрэг үгийг голчлон хэрэглэдэг байжээ.⁴²

Амиа хорлох үзэгдлийн шалтгаан, нөхцөл, түүнд нөлөөлөх хүчин зүйл

Орчин үеийн онолын үзэл баримтлалуудад амиа хорлох үзэгдлийн учир шалтгаан, түүнд нөлөөлөх хүчин зүйлсийн талаар ихэвчлэн нийгэм сэтгэл зүйн талаас нь тайлбарлахад чиглэгдсэн байдаг.

⁴¹https://www.researchgate.net/publication/259891512_Methods_of_Suicide_A_Medicolegal_Perspective

⁴² https://www.krugosvet.ru/enc/gumanitarnye_nauki/sociologiya/SAMOUBISTVO_SUITSID.html

Нийгмийн эв нэгдэлгүй байдал нь хэн нэгний амьдралаа дуусгавар болгох хүслийн гол эх үүсвэр болох бөгөөд дарамтгүй байхыг мэдрэхэд тэмүүлэх нь амиа хорлоход хүргэх ноцтой эрсдэлт хүчин зүйл болно гэж үзсэн. Өөрөөр хэлбэл хүн өөрийн чадварыг хэт үнэлж, нийгмийн хамаарал үйл ажиллагаанаас хэт тусгаар гэдгээ ойлгосноос өөрт тулгарсан стрессээ давж чадахгүй зөвхөн өөрийгөө бодож амиа хорлох (эгоист); эсвэл нийгмийн хэвийн бүтэц нуран унаснаар эрхэмлэх зүйлгүй болж, нийгмийн хэм хэмжээ утгаа алдан, хүний хэвийн амьдралыг хангах нийгмийн хяналт, зохицуулга алдагдсанаар хүмүүс зовж шаналан улмаар амиа хорлоход хүрэх; нөгөө талаар хүмүүс өөрийгөө нийгмийн шаардлагад бүрэн захируулахаас өөр аргагүй болсон үед энэ байдлаас гарахын тулд амиа хорлох болдог гэжээ.

Сэтгэцийн өвчин эмгэгийн цочмог үе нь амиа хорлох эрсдэлийг өдөөдөг нийтлэг стрессор байдаг бол үе үе үүсдэг нийгэм сэтгэлзүйн хямрал ч амиа хорлоход хүргэдэг “ойрын” стрессор болдог байна.

Профессор Ш.Доржжадамба 1997 онд нүүдэлчин Монголын амьдрал зан үйл улс төр, эдийн засаг, сэтгэл зүйн өөр нөхцөлд шилжин орох үед өсвөр насны болон ахмад хүмүүсийн дунд амьдралын бэрхшээл, сэтгэлийн бухимдал, амьдралдаа хүлээж байгаа таатай биш нөхцөлд итгэл сүжиг алдагдан амь эрсдэхийн хүсэл, хорлохын үзэл санаа төрөх, үйлдэх болсон учрыг өгүүлсэн байдаг.

Судлаач З.Оюундэлгэр 1999 онд амиа хорлосноор бүртгэгдсэн нийт 684 тохиолдолд дүн шинжилгээ хийж, хүйсийн хувьд эрэгтэйчүүдийн дунд амиа хорлолт 3 дахин их бүртгэгдсэн ба өөрийгөө дүүжлэн амиа хорлох нь бусад аргаар амиа хорлосноос илүү байжээ.

Улаанбаатар хотын хүн амын дунд амиа хорлох явдлын тархвар зүйг судалсан судалгааны дүнгээр амиа хорлогчдын олонхыг (54,9%) 10-39 насны хүмүүс эзэлж байсан ба эрчүүд эмэгтэйчүүдээс 4 дахин илүү амиа хорлосон. Түүнчлэн 2-4 саруудад буюу хаврын улиралд амиа хорлох нь арай илүү байсан бөгөөд өөрийгөө дүүжлэх аргыг бусад аргаас илүү ашигласан байжээ.⁴³

Манай оронд төдийгүй олон оронд хийгдсэн судалгаагаар эрэгтэйчүүд, ялангуяа залуу, дунд насны эрчүүдийн дунд амиа хорлолт илүү тохиолдож байгаа нь анхаарал татахуйц асуудал юм.

Олон улсын байгууллагаас амиа хорлох үзэгдлээс урьдчилан сэргийлэх ажлын талаар

НҮБ-аас 1996 онд дэлхийн улс орнуудад амиа хорлох үзэгдэл, түүний үр дагаврыг бууруулах, түүнээс урьдчилан сэргийлэх Үндэсний хөтөлбөр, бодлого боловсруулах чиглэлээр удирдамж гаргасан. Энэхүү удирдамжид салбар хоорондын олон талд хамтын ажиллагааг өрнүүлэн өргөжүүлэх аргачлалаар амиа хорлох үзэгдлийг үнэлэх, судлан шинжлэх, үр дүнг нэгтгэн тоймлох нь уг үзэгдлийн тархалтын түвшнийг бууруулах, улмаар урьдчилан сэргийлэх боломжтой болохыг онцлон тэмдэглэсэн.

Цаашилбал, амиа хорлох үзэгдлээс урьдчилан сэргийлэх үр дүнтэй бодлого арга хэмжээг тодорхойлоход чухал ач холбогдолтой хэмээн дараах асуудлыг санал болгосон. Үүнд:

- Амиа хорлох эрсдэл бүхий этгээдийг эрт мэдэж, үнэлэх, эмчлэх буюу шаардлагатай үед илгээх мэргэжлийн тусламжийг дэмжих;
- Амиа хорлох үзэгдэлтэй холбоотой мэдээ баримтыг бүртгэн цуглуулах, нэгтгэх, бүртгэлийн нэгдсэн тогтолцоог бий болгох;
- Хүн амын сэтгэцийн эрүүл мэндийн байдлыг хамгаалах, дэмжих, стресс тайлах ур чадварыг дээшлүүлэх, хямралыг үр дүнтэй зохицуулах арга хэмжээг тодорхойлох;

⁴³ Туяа Б, Бямбасүрэн С, Хишигсүрэн З, Жаргал Б. Монголын нөхцөлд амиа хорлох болон амиа хорлох оролдлогын учир шалтгаан. УБ., 2010. 47 дахь тал.


- Зохих мэргэжлийн хүмүүс, тухайлбал цагдаа, боловсрол, эрүүл мэндийн мэргэжилтнүүдийг мэргэшүүлэн сургах сургалтын хөтөлбөрийг боловсруулан хэрэгжүүлэх;
- Амиа хорлосон тохиолдлыг олон нийтэд мэдээлэхдээ тухайн үндэстэн ястны ёс заншил, соёлын хэм хэмжээнд тохируулах;
- Амиа хорлох үзэгдлийг судлах, уг үзэгдлээс урьдчилан сэргийлэх тусламж, сургалтын үйл ажиллагааг хариуцах байгууллагыг бий болгох, үйл ажиллагааг нь дэмжих гэх мэт.⁴⁴

Финлянд улс “Амиа хорлохоос урьдчилан сэргийлэх Үндэсний хөтөлбөр”-ийг батлан 4 үед шаттайгаар хэрэгжүүлснээс хойш Австрали, Канад, Англи, Норвег, Шинэ Зеланд, Шотланд, Швед, АНУ, Япон зэрэг олон орон өөрийн гэсэн үндэсний хөтөлбөр, амиа хорлолтоос урьдчилан сэргийлэх бодлого, стратегийг боловсруулан батлан хэрэгжүүлж байна.⁴⁵

Австралид хүүхэд залуус болон ажлын байранд чиглэсэн амиа хорлолтоос сэргийлэх арга хэмжээг авч хэрэгжүүлсэн бөгөөд ажлын байрны өвөрмөц онцлогт тохируулсан арга хэмжээ нь илүү үр өгөөжтэй байгааг судлаачид цохон тэмдэглэсэн байна.

Монгол Улс дахь амиа хорлолтын нөхцөл байдал, шалтгаан, нөхцөл

Амиа хорлолт нь эрүүгийн эрх зүйн хувьд гэмт хэрэг биш бөгөөд өнөөгийн практикаар Цагдаагийн байгууллагаас амь хохирогчийн үхлийн шалтгаан, нөлөөллийг тогтоох зорилгоор “Хүнийг амиа хорлох нөхцөл байдалд хүргэх” гэмт хэргийн эрх зүйн зохицуулалтаар шалган шийдвэрлэж ирсэн. Иймээс Монгол Улсын Эрүүгийн хуулийн Тусгай ангийн 10 дугаар бүлгийн 10.4 дүгээр зүйлд заасан “Хүнийг амиа хорлох нөхцөл байдалд хүргэх” гэмт хэрэг сүүлийн 5 жилийн байдлаар улсын хэмжээнд нийт 1878 хүн амиа хорлож нас барсан нь жилд дунджаар 375, сард 31 хүн нас барсан статистик үзүүлэлттэй байна.





Улсын хэмжээнд сүүлийн 5 жилд амиа хорлогсдын 82.8 хувь нь эрэгтэй, 17.2 хувь нь эмэгтэй хүн байгаа бол нас барсан хүмүүсийг насны байдлаар нь авч үзвэл 1268 буюу 67.5 хувийг 18-44 насны иргэд эзэлж байна.⁴⁶ Үүнд:

Амиа хорлож нас барсан хэрэг учралыг нутаг дэвсгэрийн байдлаар нь үзвэл:


⁴⁴ Lehtinen V, Taipale V. Integrating mental health services: the Finnish experience. <https://ijic.org/articles/10.5334/ijic.30>

⁴⁵ The Scotland Government. Suicide Prevention Strategy 2013-2016. The Scotland Government 2013. <https://www.gov.scot/statistics-and-research/>

⁴⁶ Мэдээлэл, дүн шинжилгээ, шуурхай удирдлагын алба, Статистик мэдээллийн хэлтэс.



Амиа хорлоход хүргэсэн нийгэм-сэтгэлзүйн шалтгаан сэдлийн дотор архидалт 38%, гэр бүлийн зөрчил, хүчирхийлэл 19%, ганцаардал 8%, ажилгүйдэл 7%, хайр сэтгэл бүтэлгүйдэх 4%, ойр дотнын хүн нас барах 5%, санхүүгийн асуудал 3%, гэр бүлээс гадуурх бэлгийн харилцаа 3%, биеийн эдгэшгүй өвчтэй байх 3% болон бусад хүчин зүйлс тус бүр 1-2%-ийг эзэлж байна.



Амиа хорлолт нь эрүүгийн эрх зүйн хувьд гэмт хэрэг биш бөгөөд өнөөгийн практикаар Цагдаагийн байгууллагаас амь хохирогчийн үхлийн шалтгаан, нөлөөллийг тогтоох зорилгоор шалган шийдвэрлэж ирсэн. Эрх зүйн зохицуулалтын хувьд 2002, 2015 оны Эрүүгийн хуульд хэрхэн зүйлчилсэн болон тэдгээрийн харьцуулалтыг судалж үзлээ.

Эрүүгийн хууль 2015 он	Эрүүгийн хууль 2002 он	Харьцуулалт
10.4 дүгээр зүйл. Хүнийг амиа хорлох нөхцөл байдал хүргэх 1.Эд хөрөнгө, албан тушаал, гэр бүлийн хамаарал бүхий харилцаа, бусад нөхцөл байдлын улмаас эрхшээлдээ байгаа хүнийг байнга хүчирхийлсэн, доромжилсон, зодсон, тамлан зовоосон, айлган сүрдүүлсний улмаас амиа хорлоход гарцаагүй хүргэсэн бол хоёр жилээс найман жил	95 дугаар зүйл. Бусдыг амиа хорлоход хүргэх 95.1. Эд хөрөнгө, албан тушаалын болон өөр байдлаар эрхшээлдээ байгаа болон өөр бусад хүмүүстэй харгис хэрцгий харьцсан буюу нэр төр, алдар хүндийг нь байнга гутаан доромжилсны улмаас хохирогч амиа хорлосон бол хоёроос таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.	Шинэ хуулиар хохирогч нь гэр бүлийн хамаарал бүхий харилцаатай хүн байх тухай тодорхой бүлэг хүмүүсийг нэмж тусгасан боловч “өөр бусад хүмүүс” гэснийг хассан нь урьд өмнө ямар нэгэн байдлаар эрхшээлдээ байгаа эсэхээс үл хамааран энэ гэмт хэргийн хохирогч нь хэн ч байж болох байсныг өөрчилсөн. Ингэснээр энэ гэмт хэргийн хохирогч нь “эд хөрөнгө, албан тушаал, гэр бүлийн хамаарал бүхий харилцаа, эсхүл бусад нөхцөл байдлын улмаас гэмт

хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ. Тайлбар: -Энэ хуульд заасан "гэр бүлийн хамаарал бүхий харилцаа" гэж гэр бүлийн гишүүд, бусад шалтгаанаар хамт амьдарч байгаа, гэрлэлт нь цуцлагдсан, бусад шалтгаанаар хамт амьдарч байгаад больсон хүн, асран хамгаалагч, харгалзан дэмжигч, асрамжийн үйлчилгээ үзүүлж байгаа хүн, тэдгээрийн асрамжид байгаа хүмүүсийн хоорондын харилцааг ойлгоно.		хэрэгтний эрхшээлд байгаа" хүн хохирогч байхаар заажээ. • Хуулийн тайлбар хэсэгт гэр бүлийн хамаарал бүхий харилцаа гэдэгт хамаарах хүмүүсийг тус бүр нэрлэн зааж өгсөн байна. • Энэ гэмт хэргийн объектив талын шинжийг байнга хүчирхийлсэн, доромжилсон, зодсон, тамлан зовоосон, айлган сүрдүүлсэн гэж дэлгэрэнгүй байдлаар зааж өгсөн. Энэ нь практикт үйлдэгдэж буй гэр бүлийн хамаарал бүхий харилцаатай хүнийг хүчирхийлсэн, доромжилсон, зодсон, тамласан, айлган сүрдүүлсний улмаас амиа хорлоход хүргэсэн үйлдэлд эрүүгийн хариуцлага хүлээлгэх боломж бүрдсэн байна.
---	--	---

Дүгнэлт

Амиа хорлох үзэгдлээс урьдчилан сэргийлэх, уг үзэгдлийг бууруулахын тулд нэгдмэл удирдамжтай, салбар хоорондын уялдаа холбоог хангасан, нэгдсэн мэдээллийн санг бүрдүүлэхүйц, олон улсын хэмжээнд хэрэглэгддэг бүртгэл мэдээллийн боловсронгуй тогтолцоог бий болгох шаардлагатай гэж үзэж байна.

Залуучуудын дунд амиа хорлолт их байгаа нь ажилгүйдэл, эрэгтэй эмэгтэй хүмүүсийн хоорондын хувийн болон гэр бүлийн таарамжгүй харилцаа, архидалт, бусдын дарамт шахалт зэрэг шалтгаан нөлөөлж байна.

Өсвөр насныхны дундах амиа хорлолтын шалтгаан нь гэр бүлийн болон эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн таарамжгүй харилцаа, шилжилтийн насны онцлог, зан төлөвийн тогтворгүй байдал, эцэг, эхийн анхаарал халамж дутмаг, хэнэггүй хайхрамжгүй хандлага, өөрт тулгамдаж буй асуудлынхаа талаар эцэг, эхтэйгээ ярьдаггүй, ойлголцдоггүй зэрэг нь нөлөөлсөн байна. Зарим тохиолдлоос харахад сурган хүмүүжүүлэгч, багш, дотнын найз нөхдөдөө өөрт тулгамдсан асуудал болон амиа хорлох шалтгаанаа ярьсан боловч тэдгээр нь анхаарч ойлгоогүй, ач холбогдол өгч, зөвлөж туслаагүйн улмаас сэтгэл зүйн тогтворгүй байдал, гутралд орж өсвөр насны хүүхэд амиа хорлоход хүрч байна.

ЦБҮАЖ-ын "Монгол Улсад бүртгэгдсэн гэмт хэргийн тоо бүртгэл хөтлөх /код701/ журам"-ын 701.11.4-д "...бүртгэгдсэн гэмт хэрэг нь Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 1.5 дугаар зүйлд зааснаар хэрэг бүртгэлтийн хэрэг хаах, 32.5 дугаар зүйлд зааснаар хэрэгсэхгүй болсон бол тухайн хэргийг гэмт хэргийн тоо бүртгэлээс хасна..." гэж заасны дагуу гэмт хэргийн тоо бүртгэлээс хасагдаж байдаг.

Хүүхдийн эрхийг хамгаалах, аливаа эрсдэлээс урьдчилан сэргийлэх, эерэг аргаар хүмүүжүүлэх, ёс суртахууныг гэр бүлд нь төлөвшүүлэх, гэр бүлийн боловсрол олгох чиглэлээр олон нийтийг соён гэгээрүүлэх, эцэг эхийн үүрэг оролцоог нэмэгдүүлэх, хүүхдийн хүмүүжил төлөвшилд сөргөөр нөлөөлж байгаа шалтгаан нөхцөлийг арилгахад оршино.

Нийгэмд эерэг зөв хандлага төлөвшүүлэхэд хамгийн чухал үүрэг гүйцэтгэдэг хэвлэл мэдээллийн байгууллагуудыг ирээдүй хойч үеэ хамгаалсан, аюулгүй нийгэмд амьдрах боломж бүрдүүлэх үйлсэд цагдаагийн байгууллагатай нягт хамтран ажиллах шаардлагатай байна.

Санал

- Амиа хорлох үзэгдлээс урьдчилан сэргийлэх ажлыг сайжруулах, эрчимжүүлэх чиглэлээр бодлогын түвшинд Үндэсний хөтөлбөрийг боловсруулах;
- Амиа хорлосон тохиолдлыг бүртгэдэг байгууллагууд (цагдаа, прокурор, шүүх эмнэлэг гэх мэт) хоорондын үйл ажиллагааны уялдаа холбоог сайжруулан бүртгэлийн нэгдсэн тогтолцоог бий болгож, байнга шинэчлэгдэж байх мэдээллийн сантай болох;
- Суицидолог /амиа хорлолт/-ийн чиглэлээр мэргэжилтэн бэлтгэх, мэргэшүүлэх, сэтгэл зүйчийн мэдлэгийг дээшлүүлэх, амиа хорлох үйлдэл хийсэн үед үзүүлэх яаралтай тусламж үйлчилгээний чиглэлээр сургалт зохион байгуулан чадавхжуулах;
- Хэвлэл мэдээллийн байгууллага, тэдгээрийн ажилтны нийгмийн хариуцлагыг дээшлүүлж, амиа хорлох үзэгдэл, түүнээс урьдчилан сэргийлэх чиглэлээр олон нийтэд боловсрол олгохдоо худал цуу яриа, хэвшмэл буруу ойлголтыг ашиглахаас зайлсхийх, амиа хорлолтын талаар мэдээлэхдээ сэрэмжлүүлэх зорилгыг агуулах;
- Амиа хорлолт болсон газрын талаар дурдах, дуулиан шуугиан дэгдээх агуулга бүхий гарчиг, үг хэллэг ашиглах, амиа хорлохдоо ашигласан арга, болсон үйл явдлын талаар нарийвчлан дэлгэрэнгүй мэдээлэх, гэрэл зураг, видео бичлэг, олон нийтийн мэдээллийн сүлжээг ашиглахаас зайлсхийх зэрэг саналуудыг дэвшүүлж байна.

Ашигласан материал

- Б.Туяа, С.Бямбасүрэн, З.Хишигсүрэн, Б.Жаргал. Монголын нөхцөлд амиа хорлох болон амиа хорлох оролдлогын учир шалтгаан. УБ., 2010. 47 дахь тал.
- Монгол Улс дахь гэмт хэргийн цагаан ном. УБ., 2022.
- Амиа хорлох оролдлогод хийсэн хүүхэд өсвөр үеийнхэнд эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэх заавар. 2022.
- Гадны шалтгаант нас баралтын өнөөгийн байдал. Үндэсний статистикийн хорооноос хийсэн судалгааны тайлан. УБ., 2018.
- “Шинэ төрлийн гэмт хэргийн шийдвэрлэлтийн байдал” судалгааны ажлын тайлан. 2021.
- Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журам. 2023.
- Мэдээлэл, дүн шинжилгээ, шуурхай удирдлагын алба, Статистик мэдээллийн хэлтэс.
- https://www.researchgate.net/publication/259891512_Methods_of_Suicide_A_Medicolegal_Perspective
- https://www.krugosvet.ru/enc/gumanitarnye_nauki/sociologiya/SAMOUBISTVO_S_UITSID.html
- Lehtinen V, Taipale V. Integrating mental health services: the Finnish experience. <https://ijic.org/articles/10.5334/ijic.30>
- The Scotland Government. Suicide Prevention Strategy 2013-2016. The Scotland Government 2013. <https://www.gov.scot/statistics-and-research/>

ХҮҮХДИЙГ ГЭМТ ХЭРЭГТ ӨРТӨХӨӨС ХҮМҮҮЖЛИЙН АРГААР УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ НЬ

WAYS TO PREVENT CHILDREN FROM BEING EXPOSED TO CRIME THROUGH PARENTING METHODS

О.Одонбаатар
ДХИС-ийн докторант

Товч агуулга: Хүүхэд бол нийгмийн толь юм. Тэд ямар ч зүйлийг байгаагаар нь шууд тусгаж хэнээс ч үл хамааран өөрийн гэсэн үнэлэлт дүгнэлтийг өгч байдаг. Ирээдүй болсон бяцхан үрсээ гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, тэднийг гэмт хэргийн хохирогч, үйлдэгч болохоос нь өмнө хайрлан хамгаалах, анхаарлаа хандуулах нь эцэг эхчүүд бидний өмнө тулгамдсан асуудал болоод байна.

Дэлхий ертөнц даяарчлагдан өөрчлөгдөж техник технологи, шинжлэх ухааны ололт амжилт бидний төсөөллөөс ч хурдтай хөгжин дэвшиж буй энэ үед Та бидний өсөж хүмүүжсэн нийгэм, бяцхан үрсийн минь өсөж хүмүүжиж буй нийгмийн хооронд ихээхэн зааг ялгаа харагдаж байгааг анзаарсан биз. Иймд энэ илтгэлээр хүүхдийг гэмт хэрэгт өртөхөөс хүмүүжлийн аргаар урьдчилан сэргийлж болох арга замуудыг судлан шинжлэхийг зорьсон юм.

Асуудал бүхэнд гарц бий. Харин түүнийг эрж хайж, олж тогтоох нь мэргэн ухаантны шинж.

Түлхүүр үг: Гэр бүл, хүүхэд, гэмт хэрэг, урьдчилан сэргийлэх арга зам, гэр бүлийн хүмүүжил, үлгэр дуурайлал, хайр халамж, аюулгүй байдал.

Abstract: Children are the mirror of society. They directly reflect anything as it is and give their own evaluation regardless of anyone. Preventing future children from committing crimes, protecting them before they become victims or perpetrators of crime, and paying attention to them has become a challenge for us as parents.

At a time when the world is becoming globalized and technological and scientific achievements are developing faster than we can imagine, you have noticed that there is a big difference between the society in which we were raised and the society in which my little children are being raised. Therefore, this report aims to analyze ways to prevent children from becoming victims of crime through educational methods.

Every problem has a solution. But searching for it and finding it is a sign of wisdom.

Key words: Family, children, crime, preventive measures, family education, role models, love and care, safety.

Хүүхдийн эрхийн тухай конвенцод “18 нас хүрээгүй хүн бүрийг хүүхэд гэнэ”, Хүүхдийн эрхийг хамгаалах тухай хуульд “Хүүхдийн эрхийг төрсөн цагаас нь эхлэн 18 насанд хүртэл хамгаалахад энэ хууль үйлчилнэ” гэж тодорхойлсон байдаг.

Монгол Улсын хүн амын 40 гаруй хувийг 18 нас хүрээгүй өсвөр үеийнхэн эзэлж байна. Сүүлийн жилүүдэд нийгмийн хөгжлийн сөрөг үр дагаврыг даган гэмт хэргийн төрөл шинж чанар, хөдөлгөөнд ихээхэн өөрчлөлт гарч, гэмт хэрэг үйлдэж буй насанд хүрээгүй хүний тоо жилээс жилд өсөж, хүүхэд гэмт хэргийн золиос болох явдал нэмэгдсээр байна.

Монгол Улсад сүүлийн 10 жилд буюу 2013-2023 онд бүртгэгдсэн Хүүхдийн эсрэг үйлдсэн нийт 17129 гэмт хэргийн улмаас 17637 хүүхэд хохирч, 3108 хүүхэд амь насаа алдсан байна.

Энэ асуудлын объектив хүчин зүйлд: ядуурал ажилгүйдэл, сургууль завсардалт, эцэг эхийн хайр халамж дутах, гэр бүлийн хүчирхийлэл, эцэг эх, сурган хүмүүжүүлэгчийн таагүй харьцаа, найз нөхдийн сөрөг нөлөө зэрэг хамаардаг юм.

Эдгээр асуудлыг нийгмийн хамгийн бага институт болох гэр бүлийн дотор шийдвэрлэх боломжтой байна. Тухайлбал эцэг, эхийн анхаарал халамжийг нэмэгдүүлэх, найз нөхдийн болзошгүй сөрөг нөлөөллөөс хүүхдээ ангид байлгах зэрэг нь эцэг эх та бидний үүрэг юм.

Субъектив хүчин зүйлд: сэтгэл зүйн ерөнхий шинж, төлөвшлийн үе, сониуч, гэнэн зан, өөрийгөө хэт үнэлэх хандлага, бусдын нөлөөнд амархан автдаг байдал, сахилга хүмүүжилгүй байдал гэх мэт хамаардаг байна.

Хүүхдийн гэмт хэргийн шалтгаан нөхцөлийн субъектив хүчин зүйл гэдэг нь тухайн хүүхдийн өөрийн сэтгэл зүйн байдал, зан төлөв, оюун ухааны гүйцэт хөгжөөгүй байдал зэрэг өөрийн хөгжилтэй холбоотой хүчин зүйлүүд ордог.

Иймээс тэдний сэтгэл зүйн онцлог зан чанарыг судлан тогтоож, хүүхэдтэйгээ ярилцах тэдний өмнө тулгамдсан асуудлыг хамтдаа шийдвэрлэх үүрэг мөн л эцэг эхчүүд бидэнд оногдож байна.

Хүүхдийн сэтгэл зүйн байдал буюу ялангуяа түүний темперамент нь тэдгээрийн үйлдэж буй гэмт хэргийн шалтгаан нөхцөлийн анхдагч алхам мөн. Темперамент бол хүний зан төлөвийн төрөлхийн үндэс бөгөөд хүний амьдрал ахуй нөхцөл, хүмүүжлийн эрчимтэй хамаатай байдаг байна.

Иймд дараах саналыг дэвшүүлж байна.

Монгол эцэг эхчүүд, хүүхдийн хоорондын харилцаа, түүний онцлог

“Эхийн санаа үрд, үрийн санаа ууланд”, “Үхтэл үр харам” гэдэг бол Монгол аав, ээжийн үр хүүхдэдээ хандах үндсэн философи юм. Монголчуудын хүүхдээ хүмүүжүүлэх арга ухаан, хүүхэдтэйгээ харилцах харилцаа, тухайн гэр бүлийн амьдралын хэв маяг нь бусад үндэстэн угсаатнаас ялгагдах өвөрмөц онцлогтой. Эцэг эхчүүдийн ихэнх нь бид хүүхдээ зөв хүмүүжүүлж байна уу? гэсэн асуултыг өөрсдөдөө байнга тавьдаг.

Хүүхдээ яаж хүмүүжүүлэх, тэр дундаа хүүхэдтэйгээ хэрхэн харилцах, тэдний бие махбодын хөгжил, сэтгэл зүйн онцлог нэг наснаас нөгөөд шилжихэд ямар ямар өөрчлөлт гардгийг тэр бүр мэддэггүй. Үүнээс болж эцэг эх хүүхдийн хооронд үл ойлголцол, харилцааны зөрчлүүд бий болдог байна.

Хүүхдийнхээ ирээдүйд санаа тавьж, тэднийг сайн сайхан амьдраасай гэж бүхий л ээж, аав нар хүсдэг. Гэтэл хүүхэд ирээдүйд амжилт гаргаж, өөртөө итгэлтэй, бусадтай зөв харилцах чадвартай бие хүн болон төлөвшихөд эцэг эхийн үүрэг оролцоо их байх төдийгүй үр хүүхдээ сайхан амьдралд хүргэх “гүүр” нь болох ёстой юм.

МОНГОЛ ЭЭЖ ААВЫН ХҮҮХДЭЭ ХАЙРЛАХ УХААН

“Эхийн санаа үрд, үрийн санаа ууланд”

Хүмүүжлийн аргаар хүүхдийг гэмт хэрэгт өртөхөөс урьдчилан сэргийлэх арга зам

Гэр бүл түүний мөн, чанар нийгэмд эзлэх байр суурь, хувьсал хөгжлийг хүн судлаач, социологчид задлан шинжилж судлахдаа функционализм болон мөргөлдөөний онолын хүрээнд авч үзэж байна.

Гэр бүлийн нийгмийн үүрэг: Гэр бүл нийгмийн анхдагч нэгж, нийгмийн үзэгдлийн хувьд нийгмийн өмнө тодорхой үүрэгтэй. Үүнд:

- Удам угсаагаа залгамжлах

- Үр хүүхдээ өсгөж хүмүүжүүлэх, сургах
- Нийгмийн үнэт чанар, уламжлалыг хадгалан хөгжүүлэх, дараагийн үедээ өвлүүлэх
- Нэг нэгнийгээ болон гэр бүлийн гишүүд бие биеэ асарч тэтгэх эрүүл мэндийг хамгаалах

Хүн гэр бүлийн дотор төрж, ихэнх цагаа гэр бүлийн дотор өнгөрөөдөг болохоор гэр бүл бол бие хүн төлөвшиж, нийгэмшихэд шийдвэрлэх үүрэг гүйцэтгэдэг. /Д.Буян 2006:28,29 /

Судлаачийн зүгээс эцэг, эхчүүд хүүхдээ зөв хүмүүжүүлэх замаар гэмт хэрэгт өртөхөөс урьдчилан сэргийлж чадах 4 үндсэн арга замыг боловсруулахыг зорьсон.

1. Сайн хүмүүжил:

Хүүхэд хүмүүжүүлнэ гэдэг, хүнээр хүн бүтээх ухаан гэдэг амаргүй ажил. Хайр халамжийг нь ихдүүлбэл улцгар, өөртөө итгэлгүй, бие даасан биш, багадуулбал хатуу ширүүн, хүний сэтгэлийг ойлгодоггүй, муу хүн болчхож ч магадгүй. Тиймээс жорыг нь тааруулж хүүхдээ хүмүүжүүлэх нь эцэг эхээс их ур ухаан, хичээл зүтгэл шаардаж байдаг.


“Хүүхдэд өөрийн гэсэн харах, бодох, мэдрэх чадвар бий. Түүнийг нь өөрсдийнхөө чадвараар солих гэж оролдох шиг мулгуу явдал үгүй.”

/Жан Жак Руссо/

“Мөн чанарыг өөрчилж болохгүй, харин зан араншингийн янз бүрийн онцлогийг сайн тийш нь залж чиглүүлж болно. Үүнд л сурган хүмүүжүүлэх ухааны аугаа их нууц, аугаа их зорилт оршдог юм”.

/Жорж Санд/

САЙН ХҮМҮҮЖИЛ




2. Сайн үлгэр дуурайлал

Хэдийгээр хүүхдийн оюун ухааны цар хүрээг сургалт хүмүүжлийн ажлаар тэлж өгдөг боловч хүний мөс чанар, сайхан сэтгэл, гаргаж буй зан авир, бие хүний шинжүүд эцэг эхээс хуулбарлагдан бий болдог. Хүүхдийн хөгжил төлөвшил хүмүүжил тодорхой үе шаттайгаар явагддаг. Тэр ч байтугай дөнгөж төрсөн нялх үрээ хэрхэн асарч байгаагаас тухайн хүүхдийн хүмүүжил шалтгаалдаг гэнэ. Эцэг эхчүүд нялх хүүхдээ юм ойлгодоггүй гэж бодвол эндүүрэл. Өөрөөр хэлбэл үглэж биш үлгэрлэж хүүхдээ өсгөж хүмүүжүүлэх нь таны хүүхдийн гэрэлт ирээдүйд юугаар ч зүйрлэшгүй үнэт зүйл болно.

Хүүхэд залуусыг зөвхөн муу занд сургахгүй байхад хүмүүжил хэрэгтэй төдийгүй бас тэднийг сайн талаар өөрчлөхөд хүмүүжил зайлшгүй шаардлагатай. Хүмүүсийг өөрчлөхийн тулд тэднийг хайрлах хэрэгтэй. Түүнд үзүүлэх нөлөө нь тэдэнд зориулсан хайр халамжаас шууд хамааралтай байдаг.

“Хэрвээ таны зүрх сэтгэл, хэв зуршил, ажил амьдрал үр хүүхдэд тань үлгэр дуурайл болж чадахгүй бол, бусад бүх оролдлого тань дэмий зүтгэл, хоосон ажил болон өнгөрнө”. Тиймээс хүүхдэдээ зөв үлгэр дуурайлал үзүүлж, тэднийг эерэг хандлагатай төлөвшүүлэх нь тэднийг гэмт хэрэгт өртөхөөс сэргийлж чадах зөв арга зам юм.

САЙН ҮЛГЭР ДУУРАЙЛАЛ



Ирээдүйд хүүхэдтэй болж, тэдэнтэйгээ аз жаргал баяр баясгалантай амьдрах тухай мөрөөдөх хүн цөөнгүй. Гэвч бодит байдал дээр бидний амьдралд шийдвэрлэхэд төвөгтэй асуудал цаг үргэлж тулгарч байдаг.

Хүүхдүүд бидний тэвчээрийг барж, зөрүүдлэн, зогсоо зайгүй уйлж орилох нь энүүхэнд. Тэгвэл эцэг эхчүүд хүүхдүүдийн хооронд яагаад үргэлж үл ойлголцол бий болдог вэ? Сэтгэл зүйчид энэ асуултад дуу нэгтэйгээр “Хүүхдэд тань эцэг эхийн хайр энхрийлэл, халамж дутагдаж байна” гэж хариулдаг.

Хүн бүрийн сэтгэлд (тухайн хүн хэдэн настайгаас үл хамааран) “үнэ цэнийн орон зай” хэмээх ойлголт байдаг гэж сэтгэл зүйчид үздэг байна. Тэрхүү орон зайг дүүргэх хэрэгцээ хоол хүнс шиг чухал. Гэхдээ материаллаг зүйлсээр бус харин өөрийгөө бусдад хэчнээн үнэ цэнтэй, хэрэгтэйгээ ойлгох мэдрэмж, хайраар дүүргэх ёстой юм. Хүүхдээ хэнтэй найзалж нөхөрлөдөг, чөлөөт цагаа хаана өнгөрүүлдэг, юу сонирхдог зэргийг анхаарч түүнтэй ярилцаж байх хэрэгтэй. Тиймээс хүүхдэдээ анхаарал халамжаа бүрэн хандуулж тэдэнтэй ярилцаж хамт байх нь тэднийг гэмт хэрэгт өртөхөөс сэргийлж чадах зөв арга зам юм.


“Үнэ цэнийн орон зай” дүүрэн үед хүн өөртөө итгэлтэй, бусадтай эвтэй найртай байж, эргэн тойрныхонтойгоо зөрчил үүсгэхгүй.

Биеэ ёс зүйгүй авч явах нь тухайн орон зай хоосон эсвэл хангалттай дүүргээгүй байгаатай холбоотой юм. Тиймээс цаг алдалгүй хайраар бялхуулах хэрэгтэй.

“Урамшуулж хүлээн зөвшөөрөгдсөн орчинд өссөн хүүхэд байнга шүүмжлэгдэн өссөн хүүхдээс илүү их амжилтад хүрч аз жаргалтай амьдардаг”.

/Жозер Жубер/

АНХААРАЛ ХАЛАМЖ



4. Аюулгүй байдал

Энэ дэлхийн хамгийн чухал боловч хүмүүсийн анзаардаггүй нэг зүйл бол аюулгүй байдал. Аюулгүй байдал гэдэг нь хамгаалагдсан эрх чөлөө юм. Хүүхдийг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх хамгийн чухал арга зам бол тэдний аюулгүй байдлыг хангах явдал юм.


Хүүхдийн аюулгүй байдал, хамгаалал, хүмүүжлийн асуудал нэн чухал гэдгийг сүүлийн жилүүдэд бүртгэгдэж буй гэмт хэрэг, зөрчлийн статистик мэдээлэл харуулж байна. Тухайлбал, Цагдаагийн байгууллагын сүүлийн 10 жилд хүүхэд холбогдож, хохирсон гэмт хэргийн статистик мэдээнээс харахад 13462 хүүхэд гэмт хэрэгт холбогдсон байх ба үүний 67 хувь нь Өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэгт холбогдсон байна. Мөн 3108 хүүхэд нас барсны 1873 буюу 60 хувь нь золгүй байдлаар амь насаа алдсан байна.

Хүүхдийн хөгжилд эцэг эхийн оролцоо хэдий чинээ их байх тусам тэдний бие бялдар, оюун ухаан, нийгэмшихүйн хөгжлийн үзүүлэлт нь төдий чинээ сайн байдаг байна.


Нийгэм эцэг эхчүүдэд хүүхдийнхээ төрөлхийн болон хууль ёсны асрамжлагч байх эрхийг олгодог. Хүүхэд хүртэх эрхтэй хайр халамж, хамгаалал, хоол тэжээл, эрүүл мэндийн асаргаа, сурч боловсрох боломжийг нэн тэргүүнд бүрдүүлэх хамгийн анхдагч орон зай нь гэр бүл гарцаагүй мөн. Мэдээллийн технологи хурдацтай хөгжиж буй даяаршсан өнөөгийн нийгэмд хүүхэд цагийг өнгөрөөх өөр ертөнцтэй болсон нь нууц биш ээ.

Гар утас, интернэт, фэйсбүүк, твиттер, компьютер, телевизийн олон суваг гээд энэ олон сонирхолтой зүйлээс давсан сонирхолтой зүйлээр хүүхдийн анхаарлыг яаж татаж, хөгжүүлэх вэ? гэдэг том сорилт боловсролын байгууллага болон эцэг эх, олон

нийтийн дунд хэлэлцүүлэг өрнүүлэхэд хүргэж байна. Тиймээс хүүхдийнхээ хүрээлэн буй орчны, хүрээлэн буй хүмүүсийг судалж хүүхдийнхээ аюулгүй байдлыг хангах нь хүүхдээ гэмт хэрэгт өртөхөөс хамгаалж чадах зөв арга зам мөн юм.



ХҮҮХДИЙГ ГЭМТ ХЭРЭГТ ӨРТӨХӨӨС ХҮМҮҮЖЛИЙН АРГААР УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ



Дүгнэлт

Эцэг эх, гэр бүл нь хүүхдэд эрүүл мэнд, нийгмийн халамж, боловсролын үйлчилгээ үзүүлэгчидтэй хамтран ажиллах, аливаа үйл ажиллагаанд оролцох эрх, үүрэгтэй. Энэхүү эрхээ эдэлж, үүргээ биелүүлэхэд эцэг эх, гэр бүлд үзүүлэх тусламж, дэмжлэг хангалтгүй байгаагаас бага насны хүүхдийг хөгжүүлж, боловсрол эзэмшүүлэх байгууллагын үйл ажиллагаа гэр бүл, олон нийтээс салангид явагдаж үр дүн нь нийгмийн хөгжлийн шаардлагыг төдийлөн хангаж чадахгүй байна.

Иймд сургуулийн өмнөх боловсролын байгууллагаас эцэг эх, гэр бүлийн өргөн хүрээтэй оролцоо, идэвхтэй хамтын ажиллагааг бий болгох нь бага насны хүүхдийн хөгжлийг хангах чухал хөшүүрэг болох юм. Ийм учраас сургуулийн өмнөх боловсролын байгууллага ба багш, ажиллагчид бага насны хүүхдийг хөгжүүлэх чиглэлээр явуулж буй аливаа үйл ажиллагаандаа эцэг эх, гэр бүлийн оролцох эрхийг хангах, үүргээ ухамсарлан биелүүлэх боломжийг бүрдүүлэх талаар хамтран ажиллах шаардлагатай байна.

Санал

Хүүхдийнхээ хүмүүжил төлөвшилд илүү их цаг зав гаргаж, тэднийг муу хүмүүстэй нөхөрлөх, уруу татагдах, гэмт хэрэгт өртөхөөс урьдчилан сэргийлэхийн тулд анхаарал халамжаа сайжруулах хэрэгтэй байна. Өөрөөр хэлбэл таны хүүхдийн ирээдүй таны гарт байна хэмээн ойлгох.

Ирээдүйд сэтгэл зовнин шаналахгүй тулд өнөөдөр хүүхдийнхээ төлөө сайн хүмүүжил, сайн үлгэр дуурайлал, анхаарал халамж, аюулгүй байдал гэсэн 4 үндсэн арга замыг хэвшил болгон хэрэгжүүлээд үзэхийг санал болгож байна.

Цаашид энэ төрлийн судалгааны ажлыг шинжлэх ухааны үндэстэй хийж гүйцэтгэх, хүүхдийг гэмт хэрэгт өртөхөөс, гэмт хэрэг үйлдэхээс урьдчилан сэргийлэх цогц арга хэмжээний саналыг боловсруулахыг эрэлхийлэн ажиллах болно.

Ашигласан материал

- Монгол Улсын шүүхийн шийдвэрийн эмхэтгэл, (2006). “Насанд хүрээгүй этгээдэд холбогдох эрүүгийн хэрэг”
- Хууль зүй, дотоод хэргийн яам, Хууль зүйн үндэсний төв, Нэгдсэн Үндэсний Байгууллага, (2008). “Хүүхэд ба хууль ёс”.
- Буян.Д, (2006). Нийгмийн тухай мэдлэг.
- Багабанди.Н, (2010). “Титэм үг” I,II боть.
- “Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх хууль сахиулах болон шүүх эрх мэдлийн байгууллагын ажилтны гарын авлага”, (2017).

КИБЕР ОРЧИНД ТЕЛЕГРАМ ПЛАТФОРМ АШИГЛАН ҮЙЛДЭЖ БУЙ ЗАЛИЛАХ ГЭМТ ХЭРГИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛД ХИЙСЭН ДҮН ШИНЖИЛГЭЭ

ANALYSIS OF THE SITUATION OF FRAUD CRIMES USING THE TELEGRAM PLATFORM IN THE CYBER ENVIRONMENT

Б.Хатанзориг

*Эрүүгийн цагдаагийн албаны Кибер гэмт хэрэгтэй тэмцэх газрын
Цахим мэдээлэл, дүн шинжилгээний хэлтсийн эрүүгийн мөрдөгч,
цагдаагийн ахлах дэслэгч*

Товч агуулга: Монгол Улсын интернэт хэрэглэгчдийн тоо ихсэх тусам кибер орчныг ашиглаж үйлдэж буй гэмт хэргийн гаралт ихсэх хандлагатай байх бөгөөд сүүлийн үед “Телеграм” платформыг ашиглаж үйлдсэн залилах гэмт хэргийн гаралт нэмэгдэх хандлагатай байна. Иймд телеграм платформ ашиглан үйлдсэн залилах гэмт хэргийн нөхцөл байдалд дүн шинжилгээ хийж, урьдчилан сэргийлэх арга замын талаар санал-зөвлөмж боловсруулахыг зорьсон.

Abstract: As the number of Internet users in Mongolia increases, the number of crimes committed in the cyber environment will tend to increase, and recently fraud crimes committed using the "Telegram" platform have increased dramatically.

Therefore, the purpose of this article is to compile and analyze the research of fraud crimes committed using the Telegram platform from the central and local police stations and departments in order to clarify the occurrence and causes of fraud crimes committed using the cyber environment.

Түлхүүр үгс: Телеграм платформ, кибер орчин, залилах гэмт хэрэг, гэмт хэрэг, дүн шинжилгээ.

Keywords: Telegram platform, cyber environment, fraud crimes, crime, analysis.

Манай улсын хувьд 2024 оны эхний 9 сарын байдлаар цагдаагийн байгууллагад нийт 24,811 гэмт хэрэг бүртгэгдэн шалгагдаж байна. Залилах гэмт хэрэг 7063 буюу нийт гэмт хэргийн 28.5% хувийг эзэлж байгаа бол үүнээс 4095 буюу 58% хувь нь кибер орчныг ашиглаж үйлдэгдэж байна.⁴⁷

Эндээс үзэхэд, кибер орчныг ашиглаж үйлдсэн залилах гэмт хэргийн үйлдлийн арга хурдацтай өөрчлөгдөж, тасралтгүй нэмэгдэж байгаа бөгөөд 2030 он гэхэд энэ төрлийн гэмт хэрэг 30,000 бүртгэгдэж оргил үедээ хүрэх прогностой байна.

Иймд сүүлийн үед кибер орчныг ашиглан ихээр үйлдэгдэж байгаа залилах гэмт хэргийн нэгэн төрөл болох телеграм платформ ашиглан үйлдсэн залилах гэмт хэргийн шалтгаан, нөхцөлийг судалж, урьдчилан сэргийлэх шаардлага үүссэн.

Цагдаагийн байгууллагад телеграм платформд үйлдэгдсэн залилах гэмт хэрэг 277 бүртгэгдэн, шалгагдаж байгаа бөгөөд нийт 277 хохирогчид 3,991,894,493 төгрөгийн хохирол учруулсан байна. Нутаг дэвсгэрээр задлан харуулбал:

⁴⁷ ЦЕГ-ын МДШШУА. Гэмт хэргийн статистик. УБ., 2024

Орон нутгийн хэмжээнд:


Телеграм платформд үйлдэгдсэн нийт залилах гэмт хэргийн 77 буюу 27.8% нь орон нутагт үйлдэгдсэн байх бөгөөд 1,435,009,822 төгрөгийн хохирол учруулсан байна.



Зураг 1. Орон нутгийн хэмжээнд үйлдэгдсэн гэмт хэрэг

Нийслэлийн хэмжээнд:

Нийслэлийн хэмжээнд 200 буюу 72.2% нь үйлдэгдсэн байх бөгөөд 2,556,881,671 төгрөгийн хохирол учруулсан байна.




Зураг 2. Нийслэлийн хэмжээнд үйлдэгдсэн гэмт хэрэг

Телеграм платформ ашиглаж үйлдсэн залилах гэмт хэргийн хохирогчдын талаар

Цагдаагийн байгууллагад шалгагдаж байгаа нийт телеграм платформд үйлдэгдсэн залилангийн 65% буюу 3 хохирогч тутмын 2 нь эмэгтэй хүн байна. Мөн нийт хохирогчдын 69%-ийг 25-44 насны залуучууд эзэлж байна.

Зураг 3.Хохирогчдын нас, хүйс



Хохирогчдыг нийгмийн оролцоогоор нь ангилан авч үзвэл хохирогчдын 45% хувь нь хувийн хэвшилд буюу /ченж, уурхайн оператор, мужаан, хүргэлтийн ажилтан, үсчин, менежер, засварчин, тогооч г.м/ ажил, хөдөлмөр эрхэлдэг хүмүүс эзэлж байна.

Зураг 4. Хохирогчдын нийгмийн байдал



Хохирогчдыг боловсролын түвшнээр нь ангилан авч үзвэл 14 буюу 5%-ийг бага дунд, 92 буюу 33%-ийг бүрэн дунд, 172 буюу 62%-ийг дээд боловсролтой хүмүүс эзэлж байна.



Telegram платформ ашиглан үйлдэгдсэн хэргүүдийн үйлдлийн аргуудад дүн шинжилгээ хийхэд дараах 6 төрлийн аргаар гэмт хэрэг үйлдэж байгаа нь тогтоогдсон. Үүнд:

1. Бараа худалдан авч, борлуулалт нэмэгдүүлэх даалгавар 158 (57%/)
2. Тик ток хаяг дагах, өгөгдсөн постод лайк дарж хандалт өсгөх даалгавар 44 (15.8%)
3. Байгууллагын үйл ажиллагаа, бүтээгдэхүүн, зар сурталчилгаанд үнэлгээ өгөх даалгавар 39 (14%)
4. Өгөгдсөн дансанд мөнгө байршуулаад өсгөж авах даалгавар 31 (11.1%)
5. Зээл олгоход шаардлагатай материал бүрдүүлэх даалгавар 3 (1.08%)
6. Өгөгдсөн интернэт банкаар нэвтэрч гүйлгээ хийх даалгавар 2 (1.02%) тус тус байна.

Дүгнэлт

Цагдаагийн байгууллагад telegram платформ ашиглан үйлдэгдсэн залилах гэмт хэрэг 2024 оны 7 дугаар сараас хойш 277 бүртгэгдэж, шалгагдаж байгаа бөгөөд 3,991,894,493 төгрөгийн хохирол учруулсан байгаагаас дүгнэхэд, 2024 оны эцэст энэ төрлийн гэмт хэрэг 1000 гаруй бүртгэгдэж, 12 тэрбум төгрөгийн хохирол учруулж болзошгүй прогноз гарч байна.

Иймд энэ төрлийн гэмт хэргийн гаралтыг бууруулах, иргэдэд аюулгүй байдлын боловсрол олгох нөлөөллийн арга хэмжээг зөв, оновчтой хэрэгжүүлэх шаардлагатай гэж үзэж байна.

Энэ төрлийн гэмт хэргийн хохирогчид нь 25-44 насны залуучууд байх бөгөөд 3 хохирогч тутмын 2 нь эмэгтэй хүн байна. Гэмт этгээдүүдийн чиглэсэн сегмент нь амар хялбар аргаар санхүүгийн эх үүсвэр бүрдүүлэх гэсэн тогтвортой орлогогүй эмэгтэйчүүд, тэр дундаа хүүхдээ гэртээ асардаг залуу ээжүүд байж болзошгүй нөхцөл байдал ажиглагдаж байна.

Санал

1. Иргэд-олон нийтэд энэ төрлийн гэмт хэргийн ойлголт, хор уршгийн талаар мэдлэг олгох урьдчилан сэргийлэх нөлөөллийн аяныг зохион байгуулах;
2. Telegram платформ ашиглан үйлдэгдэж байгаа залилах гэмт хэргээс урдчилан сэргийлэх, мөрдөн шалгах ажиллагаа явуулж буй гадаадын улсын туршлагыг судалж, нэвтрүүлэх;

3. Телеграм платформ ашиглан үйлдэгдсэн залилах гэмт хэрэгтэй тэмцэх чиг үүрэг бүхий нэгжийг байгуулах, алба хаагчдыг мэргэшүүлэх;

4. Гэмт этгээд залилах гэмт хэрэг үйлдэж олсон хөрөнгө, орлогыг гадаад улс руу гаргасан бол эрх зүйн харилцан туслалцаа үзүүлэх гэрээний дагуу хамтран ажиллах, эд хөрөнгийг хураах, царцаах.

Ашигласан материал

Хууль тогтоомж:

- Монгол Улсын Эрүүгийн хууль (2015.12.3)

Ном, сурах бичиг, гарын авлага:

- Ганболд, Б. Эрүүгийн эрх зүйн мэдлэг. Уб., 2009 он.
- Гантулга, С. Энхболд, Б. Эрүүгийн эрх зүй тусгай анги сурах бичиг. Уб., 2018 он.
- Нарангэрэл, С. Эрх зүйн эх толь бичиг. Уб., 2008 он.

Нэг сэдэвт бүтээл:

- Адъяабазар, Д. Монгол Улсад залилан мэхлэх гэмт хэрэгтэй хийх эрүүгийн эрх зүйн тэмцлийн тулгамдсан асуудал сэдэвт докторын зэрэг горилсон бүтээл. Уб., 2004 он.

Судалгааны ажил, сэтгүүл, эмхэтгэл:

- Өмгөөллийн “Фиделитас Партнерс” ХХН, Кибер гэмт хэргийн зохицуулалтын талаарх харьцуулсан судалгаа. Уб., 2002 он.
- ЦЕГ-ын МДШШУА. Гэмт хэргийн статистик. Уб., 2024 он.

Цахим эх сурвалж

- Simon, K. Digital 2024: Mongolia. www.datareportal.com. Татаж үзсэн: 01.10.2024.

ӨСВӨР НАСНЫ ХҮНИЙГ АМИА ХОРЛОХ НӨХЦӨЛ БАЙДАЛД ХҮРГЭЖ БУЙ ШАЛТГААН, НӨХЦӨЛ

IN THE SITUATION OF SUICIDAL HARM TO ADOLESCENT CHILDREN CAUSES
AND CONDITIONS FOR DELIVERY

*Б.Нямгэрэл
ДХИС-ийн магистрант,
цагдаагийн ахлах дэслэгч*

Товч агуулга: Амиа хорлох гэдэг нь хэн нэгэн санаатайгаар өөрийн амийг таслах төрх үйл юм. Олон улсын эмнэлгийн нэр томъёогоор зориуд амиа хорлох үйлдлийг суицид, амиа хорлох оролдлого хийх тохиолдлыг парасуицид хэмээн нэрлэдэг. Монгол Улсад бүртгэгдсэн өсвөр насны хүнийг амиа хорлоход хүргэх гэмт явдлын нөхцөл байдлыг судалж, шалтгаан, нөхцөлийг тодорхойлохыг зорьсон.

Abstract: Suicide or suicidal behavior is the intentional act of taking one's own life. According to the international medical terminology, the act of intentionally killing oneself is called suicide, and the case of attempted suicide is called parasuicide. We aim to study the situation of "Crimes that lead to suicide among teenage children" recorded in Mongolia, draw conclusions, and make suggestions.

Түлхүүр үгс: Өсвөр үеийн хүүхэд, амиа хорлолт, шалтгаан нөхцөл.

Keywords: Adolescents, suicide, causes and conditions.

Амиа хорлох үндсэн хоёр шалтгаан байдаг. Нэгдүгээрт, сэтгэл гутрал. Сэтгэл гутралын дунд болон гүнзгий шатанд амиа хорлох үйлдэл хийдэг. Хоёрдугаарт, зан төлвийн өөрчлөлт. Энэ нь тухайн хүүхэд бие хүн болж төлөвших явцдаа бусдаас илүү мэдрэг, жижиг асуудлыг хүндрүүлэх хандлагатай хүүхдүүд байдаг. Судалгаанаас үзэхэд, томчуудаас илүүтэй өсвөр насны хүүхдүүд амиа хорлох оролдлого их хийдэг. Учир нь сэтгэл хөдлөлөө удирдах, сэтгэлийн хөдөлгөөнөө зохицуулах чадвар бага байгаагаас үүддэг. Мөн өсвөр насны хүүхдүүд бусдаас сэтгэлзүйн зөвлөгөө авах нь бага байдаг. Гэтэл томчуудын хувьд сэтгэлзүйчид хандах, сэтгэл заслын эмчтэй уулзах зэргээр асуудлаа шийддэг. Харамсалтай нь, өсвөр насны хүүхдүүдийн хувьд ээж, аавдаа асуудлаа ярихад ойлгохгүй, буруутгах хандлагатай байдаг. Мөн найз нөхөддөө ярихад намайг буруугаар ойлгох вий, буруу бодох вий гэж айгаад бүрэн ярьж чаддаггүй. Улмаар өсвөр насны хүүхдүүд асуудлаа ярьж, зөвлөгөө авч чадахгүй удсанаар амиа хорлох оролдлого хийдэг байна.

ДЭМБ-ийн 2022 оны мэдээнээс үзэхэд, Монгол Улс 2018 онд амиа хорлох тохиолдлын тоо 100.000 хүн амд 18.67 гэж мэдээлсэн байна. Өөрийн орны судлаачдын судалгаанаас үзэхэд, ДЭМБ-ийн санхүүжилтээр 2013 онд ЕБС-ийг түшиглэж хийсэн судалгаанд Монгол Улсын 13-17 насны өсвөр насныхан сүүлийн 1 жилийн дотор 23 хувь нь амиа хорлох талаар бодож үзсэн бол 9.3 хувь нь амиа хорлох оролдлого хийсэн. Өөрөөр хэлбэл, 4 хүүхэд тутмын 1 нь амиа хорлох бодолтой байгаа бол ойролцоогоор 10 хүүхэд тутмын 1 нь амиа хорлох оролдлого хийж үзсэн байна⁴⁸. Эндээс харахад, хүүхэд өсвөр насныхны дунд амиа хорлох эрсдэл өндөр байгааг харуулж байна.

Амиа хорлолтын тархалтыг олон улсын түвшинд авч үзвэл, 100.000 хүн амд ногдох амиа өгүүтгэгчдийн тоо 25-аас дээш байхыг хамгийн өндөр, 10-аас

⁴⁸ <https://ubn.mn/p/39986>

доош байхыг хамгийн доод түвшин гэж тооцдог. Амиа егүүтгэгчдийн энэ интенсив үзүүлэлт буюу амиа хорлогчдын тоо Скандинави, Швейцар, Герман, Австри, Дорнод Европын орнууд ба Японд хамгийн өндөр түвшинд, Испани, Ирланд, Египет ба Нидерландад хамгийн нам түвшинд, харин АНУ-д хөгжилтэй орнуудын дундаж түвшинд байна⁴⁹.

Амиа егүүтгэл болон амиа егүүтгэх оролдлогын байдлыг хүйсийн хувьд авч үзэхэд эрэгтэйчүүд 3 дахин олонтоо амиа егүүтгэдэг байхад эмэгтэйчүүд 3 дахин олонтоо амиа егүүтгэх оролдлого хийдэг. Судалгаанаас үзэхэд амиа егүүтгэгчдийн 80.9% нь эрэгтэйчүүд байсан бол амиа егүүтгэх оролдлого хийгчдийн 56%-ийг эмэгтэйчүүд эзэлж байна.

Биологи, нийгэм, сэтгэл зүйн олон сөрөг хүчин зүйлсийн харилцан үйлдлээс болж зарим хүмүүс амиа егүүтгэдэг буюу амиа егүүтгэх оролдлого хийдэг. Эдгээр сөрөг хүчин зүйлсийг байгаль биологийн хүчин зүйлс, нийгмийн хүчин зүйлс, сэтгэл зүйн хүчин зүйлс гэж 3 бүлэгт хуваан авч үздэг. Үүнд:

-Байгаль биологийн хүчин зүйлсэд удамшлын, насны, хүйсийн, биохимийн, улирлын болон бусад биологийн хүчин зүйлс ихээр нөлөөлдөг.

-Нийгмийн хүчин зүйлсэд нийгэм-эдийн засгийн, соёлын, шашны, ажилгүйдлийн болон бусад нийгмийн хүчин зүйлс

-Сэтгэл зүйн хүчин зүйлсэд сэтгэлийн дарамтад орох, сэтгэл зүйн хямралд орох, сэтгэцийн зарим өвчнөөр өвчлөх болон бусад сэтгэл зүйн хүчин зүйл нөлөөлдөг.⁵⁰

Амиа егүүтгэх болон амиа хорлох оролдлогын шалтгааныг нь судалж үзвэл, залуучууд, өсвөр үеийнхэнд илүү тохиолдож байна гэсэн тооцоо гарчээ. Цаашилбал, амиа хорлох оролдлого хийх нь амиа бүр мөсөн хөнөөхөөс 10-20 дахин илүү тохиолддог. Хувь хүний түвшинд амиа хорлолтын шалтгааныг судалж үзэхэд: гэмтэл ослоос, сэтгэлийн маш хүнд цохилтод орсноос, сэтгэцийн өвчин буюу аз жаргалгүй байдлаас болоод амиа егүүтгэдэг байна гэсэн дүн гарсан.

Монгол Улсын Эрүүл мэндийн сайдын 2022 оны 3 дугаар сарын 18-ны өдрийн А/149 дүгээр тушаалаар амиа хорлох оролдлого хийсэн хүүхэд, өсвөр насны хүүхдүүдэд эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлэх зааврыг баталсан. Энэ зааврын зорилго нь өсвөр үеийнхнийг амиа хорлохоос урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх, амиа хорлох төрх үйлд өртөх эрсдэл, эрсдэлийн түвшнийг бууруулахад чиглэсэн байдаг.

Хүүхэд өсвөр үеийнхэн амиа хорлох, амиа хорлох оролдлого хийх шалтгаан, түүнд нөлөөлөх хүчин зүйл:

- Гэр бүлийн зөрчил, маргаан, эцэг эх нь салсан, санхүүгийн асуудал
- Гэр оронгүй болсон, ганцаардсан
- Гэр бүлийн буруу хүмүүжил
- Биеийн болон бэлгийн хүчирхийлэлд өртсөн
- Ойр дотны хүмүүс нь хүндээр өвдсөн буюу нас барсан
- Сургууль, багш үе тэнгийн хүүхдүүдийн дарамт шахалт,
- Үерхэл нөхөрлөл, бүтэлгүйтэл
- Гэмт хэрэгт холбогдсон
- Өсвөр насны охидын хүсээгүй жирэмслэлт
- Архи, тамхи бусад мансууруулах бодис хэрэглэх, интернэт тоглоомд донтох,
- Биеийн хүнд өвчнөөр өвдөх

⁴⁹ <https://ubn.mn/p/39986>

⁵⁰ <https://ikon.mn/n/135j>

- Удамд нь амиа хорлосон, амиа хорлох оролдлого хийж байсан, сэтгэцийн эмгэгтэй хүн байдаг,
 - Урьд нь амиа хорлох оролдлого хийж байсан,
 - Даган дуурайх сэдэлтэй зэрэг олон шалтгаанууд нөлөөлдөг.
- Хүүхэд өсвөр үеийнхнийг амиа хорлох, амиа хорлох оролдлого хийхээс хамгаалах хүчин зүйл:
- Амьдрах ур чадвар [асуудлыг шийдвэрлэх, стрессийг даван туулах чадвар]
 - Гэр бүл, найз нөхөд, бусад хүмүүсийн дэмжлэг,
 - Сургуулийн эерэг таатай орчин зэрэг ихээр нөлөөлдөг.⁵¹

Өсвөр үеийн хүүхдүүдийн амиа хорлох оролдлого хийж болзошгүй шинж тэмдгийн 75 % нь үг яриа, төрх үйлээр илэрдэг бөгөөд эдгээр шинж тэмдгүүдийг ерөнхий мэргэжлийн эмч, өсвөрийн эмч, сэтгэцийн эмч, сэтгэл засалч эмч, сэтгэл зүйч нар мэдсэнээр амиа хорлох үйлдлээс хүүхдийг сэргийлэх боломжтой байдаг. Шинж тэмдгээс дурдвал:

- Үхлийн тухай болон амиа хорлох тухай байнга ярих буюу асуух,
- Амиа хорлох, өөрийгөө гэмтээх аргын тухай сонирхох, судлах,
- Зүсэх багаж хэрэгсэл цуглуулах,
- Хувийн дуртай зүйлээ хаях, хүнд өгөх, оршуулга зохион байгуулах,
- Сэтгэл түгших, санаа зовних,
- Сэтгэлээр унаж гутрах, өөрийгөө буруутгах
- Ганцаараа үлдэхийг илүүд үзэх, зожиг болох,
- Уурлаж бухимдах,
- Зарим үед шалтгаангүй чанга инээх,
- Амьдралын тодорхой зорилгогүй
- Нойрны өөрчлөлт⁵²

Өсвөр насны хүүхдүүдийн сэтгэл гутрал ихэвчлэн үерхэл, хайр дурлал, найз нөхөд, гэр бүлийн харилцаанаас үүдэлтэй бөгөөд гэр бүлийн хүчирхийлэлд байгаа болон орж байсан бол сэтгэл гутралд орох нь элбэг байдаг. Сэтгэл гутралд орсон хүүхэд нь эцэг эхдээ дотоод сэтгэлээ уудалж нээлттэй харилцаа үүсгэж чаддаггүй, найз нөхөд багатай байдаг бөгөөд энгийн нүдээр харахад хэвийн нээлттэй хүүхэд шиг байвч яг үнэндээ хэнд ч дотоод сэтгэлээ нээдэггүй энэ нь өсвөр наснаас нас биед хүртэл үргэлжилж байдаг. Сэтгэл гутрал нь дангаараа амиа хорлох шалтгаан болдоггүй ба сэтгэл цочирдол, айдас түгшүүр зэрэгтэй хавсарсан тохиолдолд амиа хорлох шалтгаан болдог. Өсвөр насны хүүхдүүдийн сэтгэл зүй тогтвортой биш байдаг учраас амиа хорлох магадлал их байдаг. Өсвөрийнхний хэт олон зүйлд анхаарлаа хандуулж, бүгдийг таньж мэдэх гээд байдаг зан чанар нь тухайн зүйлүүдийн сөрөг тал, давуу талуудыг хурдан олж харах шалтгаан болдог. Өрөөнийхөө буланд шигдэж олон цагаар өөрт нь тохиолдсон зүйлсийн талаар эргэцүүлэн бодож суудаг. Тэдгээр бодлууд нь гэр бүлийнхэнтэй нь байтугай өөртэйгөө хүртэл зөрчилдөж байдаг.⁵³

Нийгмийн Эрүүл мэндийн үндэсний төвийн хийсэн судалгаагаар сүүлийн 4 жилд өсвөр насны 92 хүүхэд сэтгэл гутрал, гадуурхал, хүчирхийлэл, дарамт шахалтаас болж амиа хорлосон судалгаа хийгдсэн байдаг. Ерөнхий боловсролын сургуулийн сурагчдын дунд хийсэн судалгаагаар 1/4 амиа хорлох талаар боддог, 1/7 амиа хорлохыг төлөвлөж байсан, 1/10 олон удаа оролдлого хийж байсан гэж

⁵¹ <https://moh.gov.mn/uploads/files/89e0eee48d8e8b9a85f697a37a83f8fb3f2b1713.pdf>

⁵² <https://moh.gov.mn/uploads/files/89e0eee48d8e8b9a85f697a37a83f8fb3f2b1713.pdf>

⁵³ <https://ikon.mn/n/135j>

хариулсан байдаг. Амиа хорлогчдын ихэнх нь сэтгэл санаагаа бусадтай хуваалцаж чаддаггүй, хэтэрхий дотогшоо хүүхдүүд байдаг. Сэтгэлээ хэн нэгэнд нээж, ярьж зөвлөлдөж чаддаггүй бүрэг хүүхэд, эсвэл бүр эсрэгээрээ тийм алхам хийнэ гэж хэн ч төсөөлөхөөргүй нээлттэй хүүхэд байдаг. Гол нь тэд дотоод сэтгэлээ бусдад нээдэггүйд байгаа юм.⁵⁴

Амиа хорлож нас барсан хүмүүсийн 33 буюу 8.1 хувь нь 18 хүртэлх насны хүмүүс байгаагийн нийтлэг ажиглагдаж буй шалтгаанууд нь гар утас, компьютер болон дэлгэцийн донтолтод хэт автах явдлаас үүдэлтэй гэр бүлийн маргаан, таагүй харилцаа, суурь хүмүүжил, ёс суртахууны доголдол, хайр сэтгэлийн асуудалтай холбоотой байна.

Нийслэл болон орон нутагт бүртгэгдсэн амиа хорлосон тохиолдлуудыг насны бүлгээр ангилан, хэдэн насанд ямар шалтгааны улмаас зонхилон үйлдэгдсэн байгааг дараах хүснэгтээс харуулъя.

Хүснэгт 1. Амиа хорлох тохиолдлуудыг насны ангиллаар нь харуулбал

Нийслэлд	Нас	Орон нутагт
Гэр бүлийн таагүй харилцаа, гэмт хэрэгт холбогдсон, сэтгэл гутрал	10-15	Гэр бүлийн таагүй харилцаа
Хайр сэтгэлийн асуудалтай, хувь хүний ёс суртахуун, суурь хүмүүжил	16-20	Архидалт, гэр бүлийн таагүй харилцаа
Сэтгэл гутрал, мөрийтэй тоглоомд донтсон, хувь хүний ёс суртахуун, суурь хүмүүжил	21-25	
Гэр бүлийн таагүй харилцаа, архидалт, сэтгэл гутрал	26-30	Архидалт, гэр бүлийн таагүй харилцаа
Гэр бүлийн таагүй харилцаа, архидалт, сэтгэл гутрал, өр зээл	31-35	Архидалт, гэр бүлийн таагүй харилцаа, гэмт хэрэгт холбогдсон
Архидалт, сэтгэл гутрал, сэтгэцийн өөрчлөлт	36-40	Архидалт, сэтгэл гутрал, хувь хүний ёс суртахуун, суурь хүмүүжил
Архидалт, сэтгэцийн эмгэг, гэр бүлийн таагүй харилцаа	41-45	Архидалт, сэтгэцийн эмгэг
Сэтгэл гутрал, архидалт, гэр бүлийн таагүй харилцаа	46-50	Архидалт, сэтгэл гутрал
Архидалт, сэтгэл гутралд орсон	51-55	Архидалт, ажилгүйдэл, сэтгэл гутрал
Насны доройтол, сэтгэл гутрал, архидалт	56-аас дээш	Архидалт, сэтгэл гутрал, хүнд өвчин туссан

ДЭМБ-ын судалгаагаар амиа хорлолт нь 15-34 насны хүмүүсийн нас баралтын тэргүүлэх шалтгаан бөгөөд нийт нас баралтын шалтгаануудаас 12 дугаарт эрэмбэлэгдэж байгаа бол манай улсын хувьд 6 дугаарт эрэмбэлэгдэж байна. Мөн амиа хорлолтын 79 хувь нь бага болон дунд орлоготой улс оронд үйлдэгддэг бөгөөд амиа хорлолт нь 15-29 насны хүмүүсийн үхлийн шалтгааны 2

⁵⁴ <https://ikon.mn/n/135j>

дахь том хүчин зүйл болж байгааг онцолсон.

Дэлхийн 4 хүн тутмын 1 нь амьдралынхаа хугацаанд сэтгэцийн ямар нэг эмгэгт нэрвэгдэж байгаагаас гадна хөдөлмөрийн чадвар алдалтад хүргэдэг 10 өвчний 5 нь (сэтгэл гутрал, архаг солиорол, сэтгэл цочирдлын хоёр туйлт эмгэг, архины хэрэглээтэй холбоотой эмгэгүүд, ялимгүй зовлонт байдлын эмгэг г.м) сэтгэцийн эмгэгтэй байна.

Дэлхийн хүн ам зүй судалгааны байгууллагаас 2018 онд гаргасан судалгаагаар улсорнуудад бүртгэгдэж буй амиа хорлолтын нийтлэг шалтгаан нь хүн амын сэтгэл гутрал, ядуурал, шашин соёл, хувь хүмүүсийн суурь хүмүүжил зэрэг олон төрлийн хүчин зүйлээс хамааралтай үйлдэгдэж байгааг дурдсан байдаг.

Монгол Улсын сүүлийн 10 жилийн статистик мэдээгээр хүн амын төрөлт, нас баралтын үзүүлэлтийг харьцуулан үзвэл хүн амын төрөлт жилд 45326-82839 байсан бол, үүнээс 19.9-36.7 хувийг нь нас баралт эзэлж байна.

Манай улсад 2020 онд бүртгэгдсэн амиа хорлох тохиолдлыг ДЭМБ-ын 100 мянган хүнд ногдох аргачлалаар тооцоход 12.2 болж, энэ үзүүлэлтээрээ 184 орноос Чех Улстайнэг төвшинд 140 дүгээрт эрэмбэлэгджээ.

Энэхүү жагсаалтыг Үндэстнүүдийн хамтын нөхөрлөлийн бүрэлдэхүүнд багтах Антигуа, Барбуда Улс 0.39 үзүүлэлтээр тэргүүлдэг бол Лесото улс 72.4 үзүүлэлтээр хамгийн сүүлд эрэмбэлэгдэж, хөрш ОХУ 25.1 буюу 175, БНХАУ 8.07 буюу 102 дугаарт бичигджээ.

Эрүүгийн эрх зүйн зохицуулалт

Эрүүгийн хууль 2002 он	Эрүүгийн хууль 2015 он
95 дугаар зүйл. Бусдыг амиа хорлоход хүргэх 95.1.Эд хөрөнгө, албан тушаалын болон өөрбайдлаар эрхшээлдээ байгаа болон өөр бусад хүмүүстэй харгис хэрцгий харьцсан буюу нэр төр, алдар хүндийг нь байнга гутаан доромжилсны улмаас хохирогч амиа хорлосон бол хоёроос таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.	10.4 дүгээр зүйл. Хүнийг амиа хорлох нөхцөл байдалд хүргэх 1.Эд хөрөнгө, албан тушаал, гэр бүлийн хамаарал бүхий харилцаа, бусад нөхцөл байдлын улмаас эрхшээлдээ байгаа хүнийг байнга хүчирхийлсэн, доромжилсон, зодсон, тамлан зовоосон, айлган сүрдүүлсний улмаас амиа хорлоход гарцаагүй хүргэсэн бол хоёр жилээс найман жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.
Тайлбар: -Энэ хуульд заасан “гэр бүлийн хамаарал бүхий харилцаа” гэж гэр бүлийн гишүүд, бусад шалтгаанаар хамт амьдарч байгаа, гэрлэлт нь цуцлагдсан, бусад шалтгаанаар хамт амьдарч байгаад больсон хүн, асран хамгаалагч, харгалзан дэмжигч, асрамжийн үйлчилгээ үзүүлж байгаа хүн, тэдгээрийн асрамжид байгаа хүмүүсийн хоорондын харилцааг ойлгоно.⁵⁵	

Дүгнэлт

Амиа хорлолт нь орон нутагт нийслэлээс илүү олон бүртгэгдэж байгаа нь төрийн үйлчилгээний чанар, хүртээмж хангалтгүй байгаагаар холбоотой бөгөөд гэр бүлийн дулаан уур амьсгалыг бүрдүүлж, аливаа асуудалд хандах хандлагыг өөрчлөх, архи дан согтуурахтай тэмцэх чиглэлээр холбогдох төрийн болон төрийн бус байгууллагуудын хамтын ажиллагаа, уялдаа холбоог сайжруулах,

⁵⁵ Цагдаагийн ерөнхий газрын Мэдээлэл дүн шинжилгээ, шуурхай удирдлагын албанаас гаргасан танилцуулга.

шат дараалсан оновчтой зохион байгуулалтын арга хэмжээг авч хэрэгжүүлэх нь амиа хорлох явдлыг бууруулахад эерэг нөлөө үзүүлэхээр байна.

1. Амиа хорлогчдын 33 буюу 8.1 хувь нь 18 хүртэлх насны хүүхдүүд байгаа ба гэмт хэрэг үйлдэгдэх болсон гол шалтгаанууд нь гар утас, компьютер болон дэлгэцийн хэт автах явдлаас үүдэлтэй гэр бүлийн таарамжгүй харилцаа, хэрүүл маргаан, тухайн хүүхдийн суурь хүмүүжил, ёс суртахууны доголдолтой шууд холбоотой байна.

2. Арван найм хүртэлх насны хүмүүс гар утас, дэлгэцийн донтолттой холбоотой гэр бүлийн тааламжгүй уур амьсгалын улмаас амиа хорлох тохиолдол нийтлэг ажиглагдлаа. Энэ нь хүүхдүүдийн насанд хүрэгчидтэй харилцах харилцаанд асуудал байгаагаас гадна тэдний хүмүүжил, ёс суртахууны доголдолтойг илэрхийлж байна. Үүнийг шийдвэрлэх арга зам нь “Хүүхэд, залуучуудад эх оронч үзэл төлөвшүүлэх үндэсний хөтөлбөр”-т заагдсан холбогдох заалтуудыг үр дүнтэй хэгжүүлэх шаардлагатай байна.

3. Хүүхдийн амиа хорлох сэдэл нь үе тэнгийнхний дээрэлхэлт, гэр бүлийн шалтгаан голчлон байдаг бол мэргэжил сонголт нь ч амиа хорлоход хүргэж байна. Өсвөр үеийн хүүхэд амиа хорлох тухай бодох, завдах хүртэл маш удаан хугацаанд сэтгэл зовниосон асуудалтай байх бөгөөд түүнийг гадагшлуулахгүй, хэн нэгэнтэй хуваалцахгүй байх, анхаарлаа өөр зүйл төлөвлүүлэхгүйгээр зөвхөн сэтгэл шаналалдаа туйлширснаас үүддэг хэмээн сэтгэл зүйчид үздэг. Хүүхдэд амиа хорлох сэдэл төрүүлэхгүйн тулд гэр бүлийн зүгээс хүүхэдтэйгээ үргэлж ярилцах, сэтгэл хөдлөлийг нь хуваалцах, найз нь байх, зөв чиглэл дэмжлэг үзүүлэх нэн шаардлагатай бөгөөд 2800-3500 орчим хүүхэдтэй сургуулийн орчинд хүүхэдтэй ярилцаж зөвлөгөө өгөх ганцхан сэтгэл зүйч ажиллаж байгаа нь дутагдалтай байгаа тул нэмэгдүүлж ажиллуулах шаардлагатай.

Ашигласан материал

- Монгол Улсын Үндсэн хууль .Төрийн мэдээлэл. 1992
- Эрүүгийн хууль. Төрийн мэдээлэл. 2015
- Ш.Батболд Сэтгэл судлалын сонгодгууд. УБ.2010
- Д.Мөнхцэцэг. Донтолт ба сэтгэл зүйн зөвлөгөө. УБ., 2020
- Хүний эрхийн олон улсын гэрээ ба монгол улс хоёрдугаар боть,
- Эрүүл мэндийн сайдын 2022 оны 03 дугаар сарын 18-ны өдрийн А/149 дүгээр тушаалаар баталсан “Амиа хорлох оролдлого хийсэн хүүхэд, өсвөр үеийнхэнд эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлэх заавар”
- www.legalinfo.mn
- www.moh.gov.mn
- www.ikon.mn

ЭРҮҮГИЙН ПРОЦЕССЫН ЭРХ ЗҮЙН ОНОЛ, ПРАКТИКИЙН ТУЛГАМДСАН АСУУДАЛ

МОНГОЛ УЛСАД АВЛИГЫН ГЭМТ ХЭРГИЙГ МӨРДӨН ШАЛГАХ АРГА ЗҮЙН АСУУДАЛ

METHODOLOGICAL PROBLEMS OF INVESTIGATING CORRUPTION CRIMES IN MONGOLIA

Р.Баярмагнай

*Авлигатай тэмцэх газрын хэлтсийн дарга,
доктор, (Ph.D), профессор, эрхэлсэн комиссар*

Товч агуулга: Авлигатай тэмцэх, авлигыг таслан зогсоох, авлигын гэмт хэргийг илрүүлэх, мөрдөн шалгах эрх зүйн зохицуулалтыг улс орон болон олон улсын түвшин тэдгээрийн хамтын ажиллагааны мэргэжлийн байгууллагуудын хувьд нэн тэргүүлэх зэргийн ач холбогдолтой асуудал юм. Учир нь авлигын гэмт хэргийн субъект нь /цагаан захтан/ гэгдэх төрийн удирдах албан тушаалтан, улс төрд нөлөө бүхий тушаал шийдвэр гаргах этгээдүүд холбогдох бөгөөд энэ гэмт хэрэг нь хахууль өгсөн, авсан, түүнчлэн давуу байдал олгож байгаа болон давуу байдал олж авч байгаа хоёр этгээдийн хооронд үйлдэгдэж байгаа мэт боловч эрх бүхий албан тушаалтны өөрийн ашиг сонирхлын үндсэн дээр гаргаж буй хууль бус тушаал, шийдвэрийн улмаас улс орны эрх ашиг, эдийн засагт ихээхэн хохирол учруулдаг, гэмт хэргийн хор уршиг нь нийгмийн давхарга ялгахгүйгээр гишүүн бүрт учирдгаараа бусад төрлийн гэмт хэргээс эрс ялгаатай, гэмт хэргийн ангиллын хувьд хүнд төрлийн гэмт хэрэгт тооцогддог байна.

Abstract: The legal regulation of combating corruption, stopping corruption, detecting and investigating corruption crimes is a matter of high priority for professional organizations at the national and international levels. Because the subject of the crime of corruption is the so-called /white-collar government officials and influential political decision-makers. Although it seems to be committed, due to the illegal orders and decisions issued by the authorized officials based on their own interests, it causes significant damage to the interests and economy of the country, and the harm of the crime is different from other types of crimes in that it affects every member regardless of social class. in terms of crime category, it is considered a serious crime.

Түлхүүр үгс: Авлига, албан тушаалтан, мөрдөн шалгах үйл ажиллагаа, арга зүй, хахууль

Key words: Corruption, officials, investigation, methodology, bribery

НҮБ-ын Конвенцод хээл хахуулийн гэмт хэргийн “албан тушаалтан” гэдэг нэр томъёог бус “нийтийн албан тушаалтан” (Public Official) ашиглаж улмаар түүнийг тодорхойлохдоо:

1. Хууль тогтоох, гүйцэтгэх, шүүх эрх мэдлийн томилогдсон, сонгогдсон, түр, байнгын, цалинтай, цалингүй бүх төрлийн албан тушаалтан,
2. Дотоодын хуулиар тодорхойлсноор нийтийн чиг үүргийг гүйцэтгэж байгаа, эсвэл нийтэд аливаа үйлчилгээ үзүүлдэг хуулийн этгээдийн ажилтан, эсвэл аливаа хувь этгээд,
3. Дотоодын хууль тогтоомжоор “нийтийн албан тушаалтан” гэж тодорхойлсон бүх албан тушаалтныг бүгдийг нь хамруулна гэж заажээ.

Эндээс харахад НҮБ-ийн Конвенц нь авлигын гэмт хэрэгт “нийтийн албан тушаалтан” (Public Official) гэсэн нэршлийг ашиглаж, түүнийг маш өргөн хүрээгээр тодорхойлж өгсөн байна.

Тодорхойлолтын амин сүнс, гол санаа нь нэгдүгээрт, төрийн нэрийн өмнөөс “нийтийн чиг үүргийг хэрэгжүүлдэг” эсвэл “нийтэд аливаа үйлчилгээ үзүүлдэг” л бол аль ч өмчийн хэлбэрийн ямар ч албан тушаалтан, эсвэл хувь хүн хээл хахууль буюу авлигад өртөх магадлалтай, эрсдэлтэй болдог учир эдгээр бүх этгээд хээл хээл хахууль буюу авлигын гэмт хэргийн субъект болно гэсэн санаа агуулга юм.

Харин энд гол шалгуур болох “нийтийн чиг үүрэг”, “нийтийн үйлчилгээ” гэдгээр юуг ойлгохыг гишүүн орон өөрөө дотоодын хуулиараа тодорхойлох учиртай гэж Конвенц онцолжээ.

Хоёрдугаарт, албан тушаалтан нь томилогдсон, сонгогдсон, байнгын эсвэл түр, цалинтай эсвэл цалингүй (сайн дурын ажилтан ч юм уу), ахлах түвшний эсвэл туслах түвшний албан тушаалтан байхаас үл хамааран бүх төрлийн албан тушаалтан, ажилтан субъект болохыг Конвенц мөн онцолсон.⁵⁶

Нийтийн албан тушаалтан гэдэг нь “Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай” хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.4 Нийтийн албан тушаалтан гэж энэ хуулийн 4.1-д заасан этгээдийг хэлнэ⁵⁷ гэсэн бөгөөд уг хуулийн 4.1-д Энэ хуулийн үйлчлэлд Авлигын эсрэг хуулийн 4 дүгээр зүйлд заасан албан тушаалтан хамаарна⁵⁸ гэж заажээ.

Авлигын эсрэг хуулийн 4 дүгээр зүйл:

4 дүгээр зүйл. Хуулийн үйлчлэлд хамаарах этгээд

4.1. Доор дурдсан этгээд энэ хуулийн үйлчлэлд хамаарна:

4.1.1. төрийн улс төрийн, захиргааны, тусгай албаны удирдах болон гүйцэтгэх албан тушаалтан;

4.1.2. төрийн үйлчилгээний албаны удирдах албан тушаалтан болон ерөнхий нягтлан бодогч, ахлах нягтлан бодогч;

4.1.3. төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн удирдах болон компанийн эрх бүхий албан тушаалтан;

4.1.4. олон нийтийн радио, телевизийн Үндэсний зөвлөлийн дарга, гишүүн, ерөнхий захирал;

4.1.5. улсын болон орон нутгийн төсвөөс санхүүжилт авч төрийн тодорхой чиг үүргийг хууль тогтоомжийн дагуу гүйцэтгэж байгаа төрийн бус байгууллагын удирдах албан тушаалтан;

4.1.6. Монгол Улсын Ерөнхийлөгч, Улсын Их Хурал, бүх шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд нэр дэвшигч;

4.1.7. бүх шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга, төлөөлөгч;

4.1.8. эрх бүхий байгууллагаас баталсан жагсаалтад заасан албан тушаалтан;

⁵⁶ Гэрэлтуяа.Г нар. Авлига, албан тушаалын гэмт хэргийг мөрдөн шалгах, хянан шийдвэрлэх ажиллагаанд анхаарах асуудлууд. УБ хот. 2022. Хуудасны дугаар 25-26 дахь тал.

⁵⁷ Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль // Төрийн мэдээлэл. УБ., 2012 №7.

⁵⁸ Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль // Төрийн мэдээлэл. УБ., 2012 №8

4.1.9. Ирээдүйн өв сангийн тухай хуулийн 4.1.7-д заасан Ирээдүйн өв сан корпорацын эрх бүхий албан тушаалтан, хяналтын зөвлөлийн гишүүн байна⁵⁹ гэж тус тус заажээ.

Мөн “Төрийн албаны тухай хуулийн хууль”-ийн 10 дугаар зүйлд Төрийн албан тушаалын ангилал, төрлийг зааж өгсөн бөгөөд төрийн албан тушаалыг төрийн улс төрийн албан тушаалтан, төрийн захиргааны албан тушаалтан, төрийн тусгай албан тушаалтан, төрийн үйлчилгээний албан тушаалтан гэж тус тус ангилжээ.

Монгол улсын төрийн албаны тухай хуулийн 3-р зүйлийн 3.1.1-д зааснаар “Төрийн алба” гэж төрийн зорилт, чиг үүргийг Монгол Улсын Үндсэн хууль, бусад хууль тогтоомжийн хүрээнд хэрэгжүүлэх, төрийн бодлого боловсруулах, төрөөс зайлшгүй үзүүлэх шаардлагатай бусад үйлчилгээг нийтэд хүргэх үйл ажиллагаа, бүтэц, зохион байгуулалтыг хэлнэ” гэж тодорхойлжээ.

Авлигын эсрэг НҮБ-ын конвенцод “Төрийн албан тушаалтан”-ыг тодорхойлохдоо:

Оролцогч улсын хууль тогтоох, гүйцэтгэх, захиргааны буюу шүүхийн байгууллагад байнга буюу түр хугацаагаар томилогдсон буюу сонгогдсон, цалинтай буюу цалингүй ажилладаг хүнийг албан тушаалын зэрэглэлээс нь үл хамааран;

Төрийн улс төрийн албан тушаал гэдэгт төрийн улс төрийн албан тушаалд Монгол Улсын Үндсэн хууль, бусад хуулиар тогтоосон болзол, журам, шалгуурын дагуу сонгогддог болон уг сонгуулийн үр дүнд томилолтын журмаар ажиллах, мөн тэдгээрийн бүрэн эрхийн хугацаанд өөрт нь үйлчлэх орон тооны дараах албан тушаал хамаарна⁶⁰ үүнд:

- Монгол Улсын Ерөнхийлөгч;
- Монгол Улсын Их Хурлын дарга;
- Монгол Улсын Ерөнхий сайд;
- Монгол Улсын Их Хурлын дэд дарга, гишүүн;
- Монгол Улсын Засгийн газрын гишүүн;
- Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газрын дарга;
- Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга, дэд сайд;
- Монгол Улсын Ерөнхийлөгчийн зөвлөх, Монгол Улсын Их Хурлын даргын зөвлөх, Ерөнхий сайдын зөвлөх;
- бүх шатны Засаг дарга болон аймаг, сум, нийслэл, дүүргийн Засаг даргын орлогч, Улаанбаатар хотын Ерөнхий менежер;
- улс төрийн албан тушаалтны бүрэн эрхийн хугацаанд зөвхөн өөрт нь үйлчлэх орон тооны зөвлөх, туслах, хэвлэл мэдээллийн ажилтны албан тушаал;
- Улсын Их Хурал дахь нам, эвслийн бүлгийн ажлын албаны албан тушаал;
- хуульд заасан бусад албан тушаал.
- Аймаг, сум, нийслэл, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга, хот, тосгоны захирагчийн албан тушаалыг төрийн улс төрийн албан тушаалтай адилтган үзэж болно.
- Улс төрийн албан хаагчийн бүрэн эрхийн хугацаанд зөвхөн өөрт нь үйлчлэх орон тооны зөвлөх, туслах, хэвлэл мэдээллийн ажилтан нь тухайн албан тушаалтанд шууд захирагдах боловч төрийн албан хаагчийн хувьд тухайн байгууллагад харьяалагдана.

⁵⁹ Авлигын эсрэг хууль. // Төрийн мэдээлэл. УБ., 2006. №35

⁶⁰ Төрийн албаны тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1

Төрийн захиргааны албан тушаал гэдэгт төрийн захиргааны албан тушаалд төрийн бодлого боловсруулахад мэргэшлийн зөвлөгөө өгөх, уг бодлогыг хэрэгжүүлэх үйл ажиллагааг төрийн захиргааны удирдлагаар хангах, зохион байгуулах чиг үүрэг бүхий дараах албан тушаал хамаарна⁶¹ үүнд:

- Төрийн албаны зөвлөлийн дарга, гишүүн, ажлын албаны удирдах, гүйцэтгэх албан тушаал;
- Улсын Их Хурал, Ерөнхийлөгч, Засгийн газар, Үндсэн хуулийн цэцийн ажлын алба, Шүүхийн ерөнхий зөвлөлийн болон Шүүхийн сахилгын хорооны ажлын алба, бүх шатны шүүхийн Тамгын газар, шүүхийн захиргааны бусад байгууллага, прокурорын ажлын албаны удирдах, гүйцэтгэх албан тушаал;
- Санхүүгийн зохицуулах хороо, Үндэсний статистикийн хороо, Сонгуулийн ерөнхий хороо, Хүний эрхийн Үндэсний Комиссын ажлын албаны удирдах, гүйцэтгэх албан тушаал;
- Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн ажлын албаны удирдах, гүйцэтгэх албан тушаал;
- яамны Төрийн нарийн бичгийн дарга, яамны удирдах, гүйцэтгэх албан тушаал;
- хуульд өөрөөр заагаагүй бол Засгийн газрын агентлагийн удирдах, гүйцэтгэх албан тушаал;
- аймаг, сум, нийслэл, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын нарийн бичгийн дарга, аймаг, сум, нийслэл, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын болон Засаг даргын ажлын албаны удирдах, гүйцэтгэх албан тушаал;
- хуульд өөрөөр заагаагүй бол аймаг, нийслэлийн Засаг даргын дэргэдэх улсын төсвөөс санхүүждэг нутгийн захиргааны байгууллагын удирдах, гүйцэтгэх албан тушаал;
- хот, тосгоны захирагчийн ажлын албаны удирдах, гүйцэтгэх албан тушаал;

Төрийн тусгай албан тушаал гэдэгт Монгол Улсын Үндсэн хууль, бусад хуульд заасан журмын дагуу үндэсний болон хүн амын аюулгүй байдлыг хангах, нийгмийн хэв журам болон хууль дээдлэх үндсэн зарчмыг сахиулахтай холбогдсон төрийн тусгай чиг үүргийг хэрэгжүүлэх албан тушаал юм⁶². Үүнд:

- Үндсэн хуулийн цэцийн гишүүн, бүх шатны шүүхийн шүүгч, прокурор;
- Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн нарийн бичгийн дарга;
- Монгол банкны Ерөнхийлөгч, Тэргүүн дэд, Дэд ерөнхийлөгч, Санхүүгийн зохицуулах хорооны дарга, орон тооны гишүүн, Үндэсний статистикийн хорооны дарга, дэд дарга, Сонгуулийн ерөнхий хорооны дарга, нарийн бичгийн дарга, Хүний эрхийн Үндэсний Комиссын дарга, гишүүн, Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн гишүүн, Шүүхийн ерөнхий зөвлөл болон Шүүхийн сахилгын хорооны дарга, гишүүн, Үндэсний болон орон нутгийн аудитын газар, Авлигатай тэмцэх газрын удирдах, гүйцэтгэх албан тушаал;
- зэвсэгт хүчин, хилийн ба дотоодын цэрэг, онцгой байдал, тагнуул, төрийн тусгай хамгаалалт, гадаадын иргэн, харьяат, цагдаа, шүүхийн шийдвэр гүйцэтгэх, шүүх шинжилгээний байгууллагын удирдлага;
- дипломат албан тушаал;

⁶¹ Төрийн албаны тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1

⁶² Төрийн албаны тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1

- зэвсэгт хүчин, хилийн ба дотоодын цэрэг, онцгой байдал, тагнуул, төрийн тусгай хамгаалалт, цагдаа, хэрэг бүртгэх, мөрдөн байцаах, шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын болон шүүх шинжилгээний байгууллагын офицер, ахлагч, шүүхийн шийдвэр гүйцэтгэгч, гаалийн байцаагч, шүүх шинжилгээний байгууллагын шинжээч, мэргэжилтэн, гадаадын иргэн, харьяатын байгууллагын ажилтан;

Төрийн үйлчилгээний албан тушаал гэдэг нь төрийн үйлчилгээг адил тэгш, чанартай, хүртээмжтэй хүргэх болон төрийн байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангахад туслах чиг үүрэг бүхий хөдөлмөрийн гэрээний үндсэн дээр ажиллах албан тушаал хамаарна⁶³:

- төрийн байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангахад туслах албан тушаал;
- боловсрол, шинжлэх ухаан, эрүүл мэнд, соёл, урлаг, спорт зэрэг төсвөөс санхүүждэг төрийн үйлчилгээний байгууллагын дарга, захирал, эрхлэгч, бусад удирдах, гүйцэтгэх, туслах албан тушаал;
- яам, агентлагийн харьяа болон түүний дэргэд ажилладаг, төсвөөс санхүүждэг төрийн үйлчилгээний байгууллагын удирдах, гүйцэтгэх, туслах албан тушаалууд тус, тус хамаарна хэмээн тус тус заажээ.

Дээр дурдсан төрийн улсын албан тушаалтан нь өөрт олгогдсон бүрэн эрхийнхээ хүрээнд зарлиг, тушаал, шийдвэр, тогтоол гаргадаг бөгөөд эрх нөлөө бүхий тусгай субъект байдаг. Уг тусгай субъектийн онцлогийн хувьд авч үзвэл өндөр боловсролтой, ажил мэргэжлийн дадлага туршлагатай, хуулийн болон эдийн засгийн өндөр мэдлэгтэй, тогтвортой харилцдаг, танил талын өргөн хүрээтэй, нийгэмд тодорхой байр суурь эзэлсэн, олон нийтэд болон тодорхой салбарт нэр хүндтэй, танигдсан, эдийн засгийн хувьд бэхэжсэн, улс төр, нам, олон нийтийн сонгуульт ажилтай тодорхой салбарт удаан жил ажилласан нөлөө ихтэй ялангуяа хууль хяналтын байгууллагад төлөөлөлтэй байдаг⁶⁴.

Албан үүрэг, бүрэн эрх гэж сонгуульт болон томилолтын албан тушаалтанд хууль тогтоомжоор олгосон бүрэн эрх, үндсэн чиг үүргийн нэгдлийг ойлгоно.

Албан тушаалын байдлаа урвуулан ашигласан гэж албан үүрэг, албан тушаал, албан тушаалын байдлын эрх мэдлээ албаны эрх ашгийн эсрэг, эсхүл хувийн ашиг сонирхлоо гүйцэлдүүлэх зорилгод ашиглаж хийх ёстой үйлдлийг хийхгүй байх, хийх ёсгүй үйлдэл хийх, эрх мэдлээ хэтрүүлэхийг ойлгоно.

Албан үүргээ, бүрэн эрхээ зориуд хэрэгжүүлэхгүй байх гэж тухайн албан тушаалтан хуулиар хүлээсэн албаны чиг үүрэг бүрэн эрхийнхээ хүрээнд зайлшгүй хийвэл зохих үүргээ мэдсээр байж, зохих ёсоор хийх бүрэн боломж байсаар байхад хувийн ашиг сонирхлоор зориудаар хэрэгжүүлээгүй эс үйлдэхүйг ойлгоно.

Хувийн ашиг сонирхол гэж нийтийн албан тушаалтан албаны бүрэн эрхээ хэрэгжүүлэхэд өөрөө болон түүнтэй хамаарал бүхий этгээдийн зүгээс нөлөөж болохуйц эдийн болон эдийн бус ашиг сонирхлыг хэлнэ⁶⁵. Ашиг сонирхлын зөрчил нь албан тушаалаа зүй бусаар ашиглан хувьдаа материаллаг ашиг олохгүй ч албан үүргээ танил тал, найз нөхөд, нутаг усных гэх мэт алагчилсан байдлаар гүйцэтгэхэд хүргэдгээрээ авлигыг нөхцөлдүүлдэг.

⁶³ Төрийн албаны тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1

⁶⁴ Ж. Бумнанжид, Ш.Мягмарцэрэн "Авлига, албан тушаалын гэмт хэрэг мөрдөх аргачлал" УБ. 2011он., 9 дэх тал.

⁶⁵ Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.2 дахь хэсэг.

Өөртөө, бусдад давуу байдал бий болгосон гэж Авилгийн эсрэг хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1-д заасан этгээд албан тушаалын эрх мэдлээ урвуулан ашигласнаар өөртөө болон хувь хүн, хуулийн этгээдэд буй болох эдийн болон эдийн бус ашигтай байдал бий болгохыг⁶⁶ ойлгоно.

Эдийн ба эдийн бус ашигтай байдал гэдэгт хууль бусаар олдсон бэлэн мөнгөнөөс эхлээд мөнгөөр үнэлэгдэх эд хөрөнгө, хөнгөлөлттэй зээл, тендерийн эрх авах, үнэ төлбөргүй аялал, зугаалгаар явах, сонгон шалгаруулалтгүйгээр ажил, сургуульд орох, хувьцаа эзэмших түүнчлэн Төрийн албаны тухай хууль (15 дугаар зүйлийн 15.1.6 дахь хэсэг) болон Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулиар хориглосон ажил, албан тушаал давхар эрхэлж олсон орлого, цалин хөлс, урамшуулал нэгэн адил хамаарна. Албан тушаалтан өөрийн албан үүргийн дагуу авах цалин хөлснөөс гадна энэ хууль, бусад хуулиар хориглоогүй бусад ажил, алба, гэрээний урамшуулал, мөн хуулиар хориглоогүй аж ахуйн үйл ажиллагааны орлого олсныг⁶⁷ өөртөө болон бусдад эдийн ба эдийн бус ашигтай байдал бий болгосон гэж үзэхгүй.

Эрх мэдлээ хэтрүүлэх гэж албан тушаалаа урвуулан ашиглаж байгаагийн нэг хэлбэр бөгөөд тухайн нийтийн албан тушаалтан өөртөө болон бусдад давуу байдал бий болгох хувийн ашиг сонирхлоор албан үүрэг, бүрэн эрхээсээ илтэд давсан болон огт хамааралгүй бүрэн эрхийг хэрэгжүүлсэн, тухайлбал, хамтын журмаар шийдвэрлэх асуудлыг дур мэдэн дангаар шийдвэрлэсэн, эрх мэдлээ хууль тогтоомжид заасан онцгой нөхцөл байдал бүрдээгүй байхад хэрэгжүүлсэн, хуулиар зөвшөөрөгдөөгүй, хийх ёсгүй үйл ажиллагаа хийснийг ойлгоно.

Албаны эрх нөлөө гэж тухай нийтийн албан хаагчийн хувьд хууль тогтоомж, дүрэм журмаар тогтоосон эрхлэх чиг үүрэг, бүрэн эрхэд шууд хамаарахгүй ч албан тушаалын дээгүүр эрх, нийтлэг давуу байдлаар бусад албан тушаалтанд нөлөөлөх боломжийг ойлгоно⁶⁸.

Нийтийн албан тушаалтан албан үүрэг, бүрэн эрх, албан тушаалын байдлаа урвуулан ашиглаж нийтийн эрх, ашиг сонирхолд их хэмжээний хохирол учруулсан бол ЭХ-ийн 22.1 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт зааснаар үйлчилж эрүүгийн хариуцлага хүлээлгэнэ.

Их хэмжээний хохирол гэж ЭХ-ийн 2.3 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасан тавин мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөг, түүнээс дээш хэмжээний хохирлыг ойлгоно.

ЭХ-ийн 22.1 дүгээр зүйлийн 1, 2 дахь хэсэгт заасан гэмт хэргийг улс төрд нөлөө бүхий этгээд үйлдсэн бол энэ зүйлийн 3 дахь хэсэгт зааснаар зүйлчилж, эрүүгийн хариуцлага хүлээлгэнэ гэж тус, тус тодорхойлсон байна.

Улс орны нийгэм, эдийн засаг хөгжихийн хэрээр авлигын гэмт хэрэг нь жил ирэх тусам нэмэгдэх төлөвтэй, тухайн гэмт хэргийг үйлдэх арга хэлбэр нь улам нарийсаж, илүү зохион байгуулалттай болж зөвхөн Монгол улсад биш хил дамнан хоёрдогч, гуравдагч улс руу дамжин үйлдэгдэж байгаа бөгөөд түүнийг мөрдөн шалгах, хянан шийдвэрлэхэд эрх зүйн болон санхүү, эдийн засгийн өндөр түвшний мэдлэг, ур чадвар, туршлага, өргөн хүрээний олон улсын албан болон албан бус хамтын ажиллагаа шаардагддаг. Үүгээрээ ч авлигын гэмт хэрэгт мөрдөн шалгах ажиллагаа явуулахад өргөн цар хүрээг хамарч, цаг хугацаа, хөрөнгө, хүч ихээр шаарддаг болох нь практик, жишээгээр харуулж байна.

⁶⁶ Авлигын эсрэг хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.4 дэх хэсэг

⁶⁷ Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.1 дэх хэсэг

⁶⁸ Б.Батцэрэн, Э.Амарбат нар. Эрүүгийн хууль /шинэчилсэн найруулга/ сурагч багшийн гарын авлага. УБ., 2017.227 дахь тал

Энэхүү гэмт хэргийн улмаас учруулсан хохирлын хэмжээ нь бусад төрлийн гэмт хэрэгтэй харьцуулахад их хэмжээний мөнгөн хохирлыг нийгэмд учруулж байдаг тул хууль бус мөнгөний шилжилт хөдөлгөөнийг тодорхойлох, эцсийн эзэмшигчийг нь тогтоон баримтжуулах нь гол зорилго юм. Хууль бус эх үүсвэртэй мөнгө хаанаас, хэзээ орж ирсэн, хэн хүлээн авсан, хаана хадгалсан, улмаар хэрхэн зарцуулж байгаа нь хэргийн нотлох үйл ажиллагааны гол үндэслэл суурь болдог.

Мөнгөн гүйлгээтэй холбоотой санхүүгийн ул мөрийг бэхжүүлэх ажиллагаа нь хэрэгт холбоотой баримт, үйл явдал, нөхцөл байдлыг логик болон үйл явдлыг дэс дараатайгаар бүрэн зураглалаар харуулах, нөгөөтэйгүүр гэмт хэргийн хамтран оролцогчдын үйл ажиллагааг тодорхойлох, тэдгээрийн санаа сэдэл, хэлбэрийг тогтооход ач холбогдолтой байдаг.

Авлигын гэмт хэрэг нь эдийн засгийн гэмт хэргийн ялангуяа мөнгө угаах гэмт хэргийн суурь гэмт хэрэг болдог тул мөрдөн шалгах ажиллагааг цаг алдалгүй явуулах нь гэмт хэргийн улмаас олсон хууль бус мөнгөн орлого, хөдлөх, үл хөдлөх эд хөрөнгийг олж тогтоох, улмаар чанар байдал, үнэ үнэлгээг алдагдуулахгүйгээр хураан авах ажиллагааг явуулах шаардлагатай байдаг. Ингэснээр гэмт хэргийн улмаас олсон хууль бус эх үүсвэртэй хөрөнгө, орлогыг эргэлтэд оруулах, хувиргах, угаах боломжийг бууруулж, хэргийг нотлоход өндөр ач холбогдолтой байдаг.

Авлигын гэмт хэрэгт мөрдөн шалгах ажиллагаа явуулж байгаа эрх бүхий мөрдөгч нь мэдүүлэг авах, нэгжлэг, үзлэг хийх, хураан авах зэрэг уламжлалт арга барилаас гадна орчин үеийн техник технологийн дэвшил, цахим хэрэгслээр дамжуулан интернэт эх сурвалж ашиглах, банк санхүү, нягтлан бодох бүртгэлийн баримтыг нягтлах, санхүүгийн тайлан мөрдөх, санхүүгийн мөрдөн шалгах ажиллагааг явуулж хууль бус эх үүсвэртэй мөнгөн гүйлгээ, түүний эцсийн эзэмшигчийг тогтоох зорилгоор хөөж шалгах, мөрдөгчийн магадлагааг түлхүү хэрэглэх, бусад улс орнуудын хамтын ажиллагаа, сайн туршлагыг судалж, суралцан арга барилаа сайжруулж байх зайлшгүй шаардлагатай юм.

Монгол Улсын Эрүүгийн хуулийн хууль тогтоомжоор /Эрүүгийн хууль 2015 он/ Авлигын гэмт хэрэгт дараах 12 бүрэлдэхүүн, шинжийг хамааруулан ойлгож байна. Үүнд:

1. Эрх мэдэл, албан тушаалын байдлаа урвуулан ашиглах /22.1/
2. Гадаад улсын төрийн болон олон улсын байгууллагын албан тушаалтан эрх мэдлээ урвуулан ашиглах /22.3/
3. Нийтийн албан тушаалтан хахууль авах /22.4./
4. Хахууль өгөх /22.5/
5. Гадаа улсын төрийн байгууллага, олон улсын байгууллагын албан тушаалтныг хахуульдах /22.6/
6. Улсын нөөцийг хууль бусаар зарцуулах, үрэгдүүлэх /22.7/
7. Төсвийн хөрөнгийг зориулалтын бусаар зарцуулах /22.8/
8. Төрийн өмчийн төсвийн бус хөрөнгийг зориулалтын бусаар зарцуулах /22.9/
9. Үндэслэлгүйгээр хөрөнгөжих /22.10/
10. Дураараа аашлах /22.11/
11. Хуулийн этгээдийн эрх мэдлийг урвуулан ашиглах /22.12/
12. Хахууль авах зэрэг гэмт хэргүүд хамаарна.

Авлигын гэмт хэргийг мөрдөх арга зүйн онолын хувьд тайлбарлан авч үзвэл Эрх мэдэл албан тушаалын байдлаа урвуулан ашиглах гэмт хэргийн мөрдөн шалгах ажиллагаанд анхаарах зүйлийн тухайд мөрдөн шалгах эрх бүхий байгууллагуудын хуулиар хүлээсэн чиг үүрэг, харьяаллын гэмт хэргийн онцлогоос

хамаарч мөрдөн шалгах ажиллагаа явуулах мөрдөгч нарыг мэргэшүүлэх, чадавхжуулах асуудлууд тулгарч байна. Өөрөөр хэлбэл мөрдөн шалгах байгууллагын мөрдөгч нарын мэргэжлийн туршлага, ажлын үр дүнгээс тухайн байгууллагын гэмт хэрэгтэй тэмцэх ажлын үр дүн шууд хамаарахаар байна.

2002 оны "Эрүүгийн байцаан шийтгэх хууль"-аар хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч байцаан шийтгэх ажиллагааг явуулахаар заасан байсныг 2017 оны "Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль"-аар өөрчилж мөрдөгч хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын хэрэгт мөрдөн шалгах ажиллагаа явуулахаар тусгасан.

Мөрдөн шалгах эрх бүхий байгууллагуудын онцлогоос шалтгаалан гүйцэтгэх ажил, мөрдөн шалгах нууц ажиллагаа явуулах эрх бүхий мөрдөгчдийг дагнан ажиллуулах, ил болон мөрдөн шалгах нууц ажиллагаа, гүйцэтгэх ажлыг хослуулан явуулах, эрх бүхий байгууллагууд хамтарсан ажлын хэсэг байгуулан ажиллах зэргээр ээдрээ төвөгтэй, нууц далд аргаар үйлдэгддэг авлига, албан тушаалын гэмт хэрэгтэй тэмцэж болох хууль, эрх зүйн зохицуулалттай.

Дэлхийн бусад орны нэгэн адил Монгол улсад жил ирэх тусам "авлига, албан тушаалын" гэмт хэрэг ихээр нэмэгдэн гарч, өмнө үйлдэгдэж байсан гэмт хэргийн үйлдлийн арга улам бүр нарийсаж, хил дамнан үйлдэгдэж байгаа билээ.

Эдгээр гэмт хэргүүдийн үйлдлийн арга улам нарийсаж, гэмт хэргийн тоон үзүүлэлт нэмэгдэж байгаа энэ цаг үетэй зэрэгцэн тухайн гэмт хэргийг илрүүлэх, таслан зогсоох, мөрдөн шалгах чиг үүрэг бүхий алба хаагч бүр энэ талын мэдлэг эзэмшсэн байх шаардлага зүй ёсоор тавигдаж байна.

Авлигын гэмт хэргийг мөрдөхөд мөрдөгч нь хуульд заасан үндсэн шалгуураас гадна дараах чадваруудыг эзэмшсэн байх зайлшгүй шаардлагатай. Үүнд:

1. Хууль хэрэглэх чадвар.
2. Санхүү, нягтлан бодох бүртгэлийн анхан шатны мэдлэг.
3. Гадаад хэлний мэдлэг.
4. Багаар ажиллах.
5. Мэдүүлэг авах тактик арга, зүй.
6. Үзлэг, нэгжлэг явуулах тактик, арга зүй.
7. Компьютер техник, технологийн мэдлэг.

8. Хуульд заасан мөрдөн шалгах бусад ажиллагаа буюу Мөрдөн шалгах нууц ажиллагааны талаарх мэдлэг, туршлага.

Авлига, албан тушаалын гэмт хэргийг мөрдөн шалгахад мөрдөгч нь санхүү, нягтлан бодох бүртгэлийн талаар зохих мэдлэгтэй, мөрдөн шалгах ажиллагааны туршлагатай байх ёстой. Учир нь дээрх төрлийн гэмт хэргийн хамрах хүрээ их, шалгах асуудал нь өргөн бөгөөд шалгагдаж байгаа этгээд нь зохих хэмжээний боловсролтой, гэмт хэргээ нуун далдлах талаар тодорхой мэдлэгтэй, уг гэмт хэргийг шууд санаатай үйлдсэн байдаг нь энэ хэргийн онцлог юм.

Мэдүүлэг авах тактик, арга зүй:

Мэдүүлэг авахын өмнө мэдүүлэг авах гэж буй хүний талаарх судалгааг зайлшгүй хийсэн байх шаардлагатай. Судалгааны хэсэгт цугларсан баримтуудыг судлан үнэлэлт дүгнэлт өгч эдгээр хүмүүсийн болон хэргийн нөхцөл байдлын талаар судалгаа шинжилгээ хийн цаашдын чиглэлийг тодорхойлно.

Зайлшгүй мэдүүлэг авах хүмүүсийн дарааллыг тогтоохдоо хэрэгт ач холбогдол бүхий мэдээлэл агуулж буй тухайн хэрэгт хувийн сонирхолгүй, хэргийн талаар мэдээлэл сайтай, мэдэж буй зүйлээ бүрэн бодитой мэдүүлж чадах хүнийг эхний ээлжид байцаах нь зүйтэй. Тухайн хэрэгт нотлогдвол зохих байдал,

мэдээлэл өгөх хир хэмжээ зэргээр байцаалтын гол асуудал, хэмжээ хязгаар тодорхойлогдоно.

Мэдүүлэг өгөгчид тавих асуултыг зөв томъёолон урьдчилан бэлтгэж тавих нь өөр хоорондоо шалтгаант холбоо бүхий үйл явдал, нөхцөл байдлыг сэргээн санах бололцоо, хэрэг нотолгооны гинжин хэлхээг мөрдөгчид олгодоогоороо давуу талтай өндөр ач холбогдолтой ажиллагаа юм.

Мэдүүлэг өгч буй этгээдийн судлах ажиллагаа нь бүхэлдээ мэдүүлэг авах хүний талаар мэдээлэл олж авах, түүнтэй сэтгэл зүйн холбоо тогтоож, хэрэгт ач холбогдолтой бүхий нөхцөл байдлын талаарх мэдээлэл авах аргыг боловсруулахад анхаарах нь зүйтэй.

Мэдүүлэг авах гэж буй этгээдийн талаарх мэдээллийг хойшлуулшгүй ажиллагааны үр дүнд олж авсан нотлох баримтуудад үндэслэх, бусад хүмүүсийг мэдүүлэг, нэгжлэг хийх явцад мөн мэдээлэл, баримт бичиг гаргуулах авах зэрэг ажиллагаагаар авч болно.

Гэрч, хохирогч, яллагдагчаас мэдүүлэг авахаар төлөвлөхдөө аюулгүй байдлаа хангаж, мэдүүлэг авах газраа тодорхойлж асуултуудаа боловсруулж урьдчилан бэлтгэсэн байх шаардлагатай.

Гэрч нь өөрийн сэтгэл зүйн онцлог, хувийн зан байдлаас шалтгаалж өөрийн үзэж харсан, сонссон, мэдэж байгаа зүйлээ өөр өөрөөр тайлбарлаж ярих тохиолдол байж болно.

Иймд тухайн гэрчээс байцаалт авахын өмнө өөрийнх нь мэдүүлэг хэрэгт ихээхэн ач холбогдолтой гэдгийг ойлгуулах, хэрэв худал мэдүүлсэн тохиолдолд эрүүгийн хариуцлага хүлээлгэх талаар урьдчилан сануулдаг. Үүнээс гадна тухайн гэрчид хөндлөнгийн ямар нэгэн нөлөөлөл байгаа эсэхийг сайтар ажиглаж мэдэх ёстой.

Хохирогч хэргийн нөхцөл байдлын талаар хэнээс ч илүү тодорхой, дэлгэрэнгүй мэдээлэлтэй байдаг ба ихэнх тохиолдолд гэмт хэрэг болохоос өмнө, түүнээс хойш болсон явдлыг мэддэг бөгөөд түүнээс гадна гэмт этгээд болох бусад хүмүүсийн хоорондын харилцааны талаарх хохирогчийн мэдүүлэг чухал ач холбогдолтой.

Хохирогч нь гэмт хэрэг болон яллагдагчийн үйлдэлд хэрхэн хандаж, ямар үнэлгээ өгч байгааг нь хэргийн шийдвэрлэлтэд нөлөөтэй байдаг.

Авлигын гэмт хэрэгт холбогдогчид ихэвчлэн мэдүүлэг өгөхдөө урьдчилан бэлтгэсэн байдаг ба мөрдөгчид ямар баримт байгааг мэдэхийг тандсан байр суурьтай байдаг учраас энэ байдлыг нь алдагдуулахын тулд тэднээс юу сонирхдог, ямар боловсрол, мэргэжил эзэмшсэн, ямар ажил хийж ирсэн зэргээр намтрыг нь яриулах, хэнтэй найзалж нөхөрлөдөг, юу хийх дуртай гэх мэт зүйлийг асууж, тодруулж байгаад гэмт хэрэг гарсан цаг үе рүү аажмаар шилжин орох нөхцөлийг бүрдүүлсэн асуулт тавьж мэдүүлэг авах ажиллагааг ерөнхий асуултаас тусгайлан бэлдсэн асуулт руу чиглэх байдлаар явуулна.

Мэдүүлгийг чанартай, үр дүнтэй болгох гол нөхцөл нь мөрдөгчөөс хавтас хэрэгт авагдсан нотлох баримтуудыг нарийн судалж үйлдэл болгоныг мэдэж байхын зэрэгцээ байгаа нотлох баримтыг хэрхэн ямар үед ашиглах, нотолбол зохих нэмэлт ажиллагааг хэрхэн, оновчтой гүйцэтгэх аргыг бодож төлөвлөх хэрэгтэй.

Мөрдөгч гэрч, хохирогч, яллагдагчаас мэдүүлэг авахдаа энгийн яриа өрнүүлж, бие, сэтгэхүйн саадыг арилгах, тайвшруулж мэдүүлэг өгч буй этгээдийг аль болох чөлөөтэйгөөр өөрийн мэдэж байгаа зүйлийг саадгүй ярих нөхцөл боломжоор хангаж өгөх, нууж хаах зүйл байхгүй болсныг ойлгуулах хэрэгтэй болно.

Үзлэг, нэгжлэг хийх тактик, арга зүй

Гэмт хэрэг гарсан байдал, хэрэгт ач холбогдол бүхий бусад байдлыг тогтоох, тодруулах зорилгоор хүний бие, эд зүйл, баримт бичиг, тээврийн хэрэгсэл, ачаа тээш, мал амьтан, хэрэг гарсан газарт үзлэг хийх ба хэргийн эд мөрийн баримт, бичмэл нотлох баримт, эсхүл эрэн сурвалжилж байгаа хүн, эд зүйл байна гэх хангалттай үндэслэл байвал тэдгээрийг илрүүлэхээр прокурорын зөвшөөрөлд заасан орон байр, бусад газар, хүний биед үзлэг, нэгжлэг хийнэ.

Үзлэг, нэгжлэгийн өмнө хийж гүйцэтгэх ажиллагааг сайтар төлөвлөж, үзлэг, нэгжлэг хийх гэж буй газрыг судалж учирч болох эрсдэлийг урьдчилан тооцох шаардлагатай.

Мөн орон байранд нэвтрэн орох үед нэгжүүлэгчийн зүгээс зэвсэгт эсэргүүцэл үзүүлэх, амиа хорлохоор сүрдүүлэх тохиолдолд гаргасан үед боломжит аюулгүй байдлыг хангах талаар арга хэмжээг авч түүний сэтгэхүйд нөлөөлж, тайвшруулах, эсэргүүцэл үзүүлэх боломжийг нь хаах, зэвсгийг нь хураан авах, ажиллагааг хэвийн явуулах арга хэмжээг нэн тэргүүнд авах хэрэгтэй.

Нэгжлэг хийх байранд ормогц мөрдөгч өөрийгөө танилцуулж, бичиг баримтаа үзүүлээд, нэгжлэг хийх тухайгаа тайлбарлан, нэгжлэг хийх тухай тогтоолыг уншиж сонсгоод нэгжүүлэгчээр гарын үсэг зуруулсны дараа нь гадна хаалганы дэргэд хамгаалалт гарган, нэгжлэг хийх байранд байгаа хүмүүсийг хэн болохыг нь шалгана.

Нэгжлэг хийж буй газрын эзэнд хандаж эрж хайж байгаа зүйлийг сайн дураараа гаргаж өгөхийг хүснэ. Эрж хайж байгаа зүйлийг гаргаж өгсөн тохиолдолд мөрдөгч тухайн зүйлийг бүрэн гүйцэт байна гэж үзвэл нэгжлэг хийлгүй, хураан авах ажиллагаа явуулна. Гэвч практикт гэмт этгээдүүд болон тэдний хань хамсаатан мөрдөгчийн мэдэж хайж байгаа зүйлийг сайн дураараа мэт гаргаж өгөөд цаанаа өөр бусад эд мөрийн баримт, хэрэглээнд хориглогдсон зүйлүүдийг нууж авч үлдэхийг санаархдаг. Ийм тохиолдолд мөрдөгч нь хэрэгт ач холбогдолтой гэж үзсэн эд зүйлс, мэдээлэл, баримт бичиг, бэлэн мөнгө гэх зайлшгүй тогтоон шалгах шаардлагатай нөхцөл байдлыг урьдчилан тооцоолж ажиллагааг дуусгах эсхүл үргэлжлүүлэн явуулах үнэлэлт дүгнэлтийг хийх шаардлагатай байдаг. Нэгжих ажиллагааны хэвийн нөхцөлийг хангах, эрж буй зүйлийг устгах боломжийг хаахын тулд тэнд байгаа хүмүүсийг нэг өрөөнд оруулж хоорондоо ярих, утсаар холбоо барих, нэгжлэг дуустал гадагшаа явахыг хориглож байгааг тайлбарлаж өгнө.

Нэгжлэгийн үеэр гаднаас ирж буй хүмүүсийн зорилгыг асууж, бичиг баримтыг шалгаад нэгжлэг дуустал тэнд түр байлгах арга хэмжээг авах нь зүйтэй бөгөөд харин ажил үүргийнхээ дагуу яваа хүмүүсийг саатуулахгүй боловч тэдний үйл хөдөлгөөнд хяналт тавьж, нэгжлэг хийж буй ажиллагааны нууцлалыг задруулахгүй байхыг урьдчилсан сануулна.

Нэгжлэгийн үеэр тактикийн дараах аргуудыг хэрэглэнэ. Үүнд:

1. Нэгжлэгийг нэг цэгээс нөгөө цэг руу гэсэн дэс дараалалтай хийх,
2. Ач холбогдол бүхий тодорхой хэсгийг сонгон авч нэгжих,
3. 2-3 мөрдөгчдийн баг нь том объектод нэгжлэг хийх болбол угталцан нэгжих, /2 талын цэгээс төв цэгт уулзах замаар/
4. Зэрэгцэн нэгжих,
5. Орон байр, жижиг талбай бүхий оффис байранд цагийн зүүний дагуу нэгжлэг хийх,
6. Хэд хэдэн мөрдөгчид нь зэрэгцэн нэгжлэг хийх зэрэг болно.

Мөрдөн шалгах явцад мөрдөгч нэгжлэг хийхдээ бичгийн нотлох баримтуудыг хураан авахын зэрэгцээ компьютер, хард, флаш, гар утас, таблет, компьютерыг хураан авч, нууц үгийг өөрөөр нь тайлуулах нь зүйтэй байдаг. Тухайн

цахим мэдээлэл хадгалдаг төхөөрөмжид агуулагдаж буй мэдээллүүд нь хэрэг хянан шийдвэрлэхэд ач холбогдолтой байдаг тул түүний анх ямар мэдээлэлтэй байхад нь хэрхэн хураан авсан зэргийг тэмдэглэлд сайтар тусгаж, онлайнаар хоёрдогч, гуравдагч этгээд интернэтээр дамжин мэдээллийг өөрчлөхөөс сэргийлж онгоцны горим дээр идэвхжүүлэн хураан авах нь зүйтэй. Холбогдогч этгээд нь өөрийн мэдээллийг цахим мэдээлэл хадгалдаг зөөврийн компьютер, хард диск, icloud, флаш диск-нд хадгалагдаж байгаа хар данс тооцоо, мөн хахууль авахдаа цахим крипто валютаар авсан, түүнийгээ хөдөлгөөнгүй болгож хадгалсан флаш дисктэй төстэй Cold wallet болох ledger, мөн идэвхтэй эргэлтэд орж захиран зарцуулалт хийж Hot wallet-ийн нэвтрэх нууц нэр, код бичсэн бичвэр зэргийг анхааралтай нэг бүрчлэн үзэж тэр даруй хураан авч үзлэг хийх шаардлагатай байна.

Авлига, албан тушаалын гэмт хэргийг мөрдөн шалгах ажиллагааны онцлог, нотлох баримт, нотолбол зохих байдлуудыг тогтооход мөрдөгчийн анхаарах асуудлууд:

Ядуурал, ажилгүйдэл газар авч, нийгмийн хүрээнд хүмүүсийн эд хөрөнгийн тэгш бус байдал үүсэж, амар хялбар аргаар ажил бүтээх, мөнгө олох хүсэл, хүний эрх, төрийн албаны ёс зүйг бүдүүлгээр зөрчих явдал, эдийн засгийн хямрал, өмч хувьчлал, аж ахуйн нэгжийн өмчлөл, банк санхүү, зээлийн хүрээн дэх хямрал, элдэв зөрчил гажуудлууд, зах зээл дээрх мөнгөний эргэлт удааширсан, дотоод аж ахуйн үйл ажиллагааны хүрээнд төлбөрийн чадвар доройтож, өр зээлийн гинжин холбоо үүссэн байдал зэрэг шалтгаануудаас болж манай улсад Авлига, албан тушаалын гэмт хэрэг үйлдэгдэж байна.

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль"-ийн 16.2 дугаар зүйлд зааснаар эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад нотолбол зохих байдлыг тусгаж өгсөн байна. Үүнд:

1. Гэмт хэрэг гарсан байдал /гэмт хэргийг хэзээ, хаана, яаж үйлдсэн болон Эрүүгийн хуульд заасан бусад байдал/;
 2. Гэмт хэргийг хэн үйлдсэн;
 3. Гэмт хэргийн сэдэлт, зорилго, гэм буруугийн хэлбэр;
 4. Эрүүгийн хуульд заасан яллагдагчид оногдуулах ялыг хүндрүүлэх, хөнгөрүүлэх нөхцөл байдал;
 5. Гэмт хэргийн улмаас учирсан хохирол, хор уршгийн шинж чанар, хэр хэмжээ;
 6. Гэмт хэрэг үйлдэхэд нөлөөлсөн шалтгаан, нөхцөл,
- Дээрх хуулийн заалтыг хангахын тулд мөрдөгч нь юуны түрүүнд мөрдөн шалгах ажиллагааг сайтар төлөвлөж зохион явуулах шаардлагатай юм.

Мөрдөн шалгах ажиллагааг зохион байгуулж явуулах гэдэг нь:

1. Мөрдөн шалгах ажиллагааны төлөвлөгөөг урьдчилан боловсруулах,
2. Мөрдөн шалгах ажиллагааны явцад мөрдөн шалгах ажиллагаанд оролцогчдын хоорондын харилцан ажиллагааны уялдаа холбоог хангах,
3. Мөрдөн шалгах ажиллагааг мэргэжлийн удирдлагаар хангах,
4. Ажлын хэсгийн гишүүдийн ажил үүргийг нарийн ялган зааглах,
5. Ажлын хэсгийн зөвлөгөөнийг тогтмол зохион байгуулж мөрдөн байцаалтын үр дүн болон дараагийн зорилтуудыг авч хэлэлцүүлж байх,
6. Мөрдөн шалгах ажиллагааг шуурхай хэсгийн оролцогчдын хооронд мэдээллийг байнга солилцох боломжийг бүрдүүлэх,
7. Мөрдөн шалгах ажиллагааг төлөвлөхдөө түүний мөрдөж байгаа бүх эрүүгийн хэргүүдийг тооцох өөрөөр хэлбэл ажлын ачааллыг тэнцүүлэх,

8. Мөрдөн шалгах ажиллагааны явцад шаардлагатай техник хангамжийг бүрдүүлэх,

9. Мөрдөн шалгах ажиллагааны мэдээ баримтыг задруулахгүй байх, үрэгдэж устахаас урьдчилан сэргийлэх арга хэмжээг авсан байх зэрэг асуудлууд багтана.

Мөрдөгч нь гэмт хэргийг шалгахдаа юуны түрүүнд шалгах гэж байгаа хүн, хуулийн этгээдийн талаар маш сайн судалгаа хийнэ.

Үүний дараа хэргийн цар хүрээ, нотлох баримтыг цуглуулж, бэхжүүлэх үе шат, хугацаа, хойшлуулшгүй ажиллагааны үед ажиллах хүн хүчний тооцоо зэргийг төсөөлж хэрэг шалгах төлөвлөгөөг тодорхой гаргана.

Хэрэг шалгах төлөвлөгөөг тодорхой гаргаснаар хэргийг шийдвэрлэхэд ач холбогдолтой нотлох баримт цуглуулж, бэхжүүлэн хэргийг богино хугацаанд нэг мөр шийдвэрлэхэд чухал ач холбогдолтой юм.

Авлига, албан тушаалын гэмт хэргийн нотлох баримт нь нуугдмал хэлбэртэй байдаг учраас цуглуулсан нотлох баримтыг үнэлэх ажил ихээхэн ур чадвар шаарддаг. Иймд хэргийн нотлох баримтыг цуглуулж, үнэлэхдээ мэргэжилтэн оролцуулж байх нь зүйтэй.

Мөн Авлига, албан тушаалын гэмт хэргийг шалгах явцад хураан авч цуглуулсан зарим бичгийн нотлох баримт нь тодорхой цаг хугацаанд хэрэгт ач холбогдолгүй мэт байдаг ч хэргийг шалгах явцад уг хэргийг шийдвэрлэхэд чухал нотлох баримт болох нь хожуу тогтоогддог учраас хэргийг нэг мөр эцэслэн шийдвэрлэтэл нотлох баримтыг бүрэн бүтэн байлгахад мөрдөгч анхаарах хэрэгтэй.

Нэгжлэг хийх, хураан авах ажиллагааны үед хэрэг шийдвэрлэхэд чухал ач холбогдолтой зарим нотлох баримтыг дутуу авах, үлдээх явдал гардаг учир мөрдөгч тухайн үеийн нөхцөл байдал, хуулийн этгээдийн хэвийн үйл ажиллагааг харгалзан тухайн объектыг тодорхой хугацаанд битүүмжлэн лацдаж байх шаардлагатай ба эдийн засгийн гэмт хэргийг шалгахад бусад хэргээс илүү цаг хугацаа шаарддаг учир нотлох баримтыг хадгалах, хэргийн нууцлалыг хангахад онцгой анхаарах шаардлагатай.

Мөрдөн шалгах ажиллагаа нь дараах төрөлтэй:

1/ Прокурорын зөвшөөрөлтэй хийгдэх мөрдөн шалгах ажиллагаа:

а/ Прокурорын зөвшөөрөлтэй хийгдэх мөрдөн шалгах ажиллагаа;

б/ хойшлуулшгүй тохиолдолд прокурорын зөвшөөрөлгүй хийгдэх мөрдөн шалгах ажиллагаа;


Прокурорын зөвшөөрөлтэй хийгдэх мөрдөн шалгах ажиллагаа

- үзлэгийг нууцаар хийх;
- нэгжлэг хийх;
- эд зүйл, баримт бичиг хураан авах;
- хөрөнгийн шилжилт хөдөлгөөнийг хянах, хязгаарлах, хяналт тогтоох;
- харилцаа холбооны сүлжээнд нэвтэрч хяналт тогтоох;
- харилцаа холбооны сүлжээгээр дамжсан мэдээллийн агуулгыг холбогдох байгууллагаас гаргуулан авах;
- харилцаа холбооны сүлжээний хэрэглэгч, эзэмшигч хэн болох, тэдгээрийн байршил, холбогдсон цаг хугацаа, техник хэрэгсэл, төхөөрөмж болон хандалт зэрэг мэдээллийг холбогдох байгууллагаас гаргуулан авах;
- харилцаа холбооны сүлжээгээр дамжсан мэдээллийн агуулгад хамаарахгүй бусад мэдээллийг холбогдох байгууллагаас гаргуулан авах;
- харилцаа холбооны сүлжээнд нэвтрэх боломжийг хязгаарлах талаар холбогдох байгууллагад даалгах;

- хүний биеэс шинжилгээнд зориулж биологийн дээж авах;
- оршуулсан цогцсыг гарган шинжлэх;
- мэдээлэл, баримт бичиг гаргуулан авах;
- хяналттай хүргэлт;
- хяналтын худалдан авалт;
- мэдээлэл, баримт бичиг гаргуулан авах;
- хяналттай хүргэлт;
- хяналтын худалдан авалт;
- мөрдөн шалгах нууц туршилт;
- нууц ажиглалт;
- таньж олуулах ажиллагааг нууцаар хийх.

2/ Мөрдөгч бие даан явуулах явуулах мөрдөн шалгах ажиллагаа:

- үзлэг хийх;
- хүний биед үзлэг хийх;
- хэргийн газрын үзлэг;
- цогцост үзлэг хийх;
- мөрдөн шалгах туршилт хийх;
- хуульд заасан үндэслэлээр прокурорын зөвшөөрөлгүйгээр хүний биед
- нэгжлэг хийх;
- мэдүүлэг авах;
- нүүрэлдүүлж мэдүүлэг авах;
- мэдүүлгийг газар дээр нь шалгах;
- таньж олуулах;
- ердийн ажиглалт явуулах;
- шинжилгээ хийлгэх журам;
- хэв загвар, дээж авах.



Мөрдөгч "Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль"-д заасны дагуу гэмт хэргийг нотлох дараах ажиллагаануудыг явуулдаг. Үүнд:

1. Мэдүүлэг авах,
2. Үзлэг, нэгжлэг хийх, хураан авах,
3. Шинжээч томилох,
4. Мөрдөн шалгах нууц ажиллагаа явуулах,
5. Прокурорын зөвшөөрлөөр мэдээлэл, баримт бичиг гаргуулан авах, Авлига, албан тушаалын гэмт хэргүүдийг олон хоног, сар, жил баримтжуулах, хөрөнгө мөнгө, цаг хугацаа их шаардах, алба хаагчдын уйгагүй бүтээлч ажлын үр

дүнд илрүүлдэг. Нэгэнт илэрсэн хэргийг мөрдөн шалгаж, хөдөлбөргүйгээр нотлох нь ихээхэн ур чадвар, туршлага шаарддаг байна.

Мөрдөгч прокуророос зөвшөөрөл авах саналд дараах зүйлийг тусгана:

1. санал гаргасан мөрдөгчийн нэр;
2. ажиллагааны төрөл;
3. ажиллагаа явуулах зорилго, үндэслэл;
4. ажиллагаанд хамрагдах хүн, хуулийн этгээд, байгууллага, объект;
5. ажиллагаа явуулах газар, нэвтрэх, дамжин орох орон байрны хаяг, эзэмшил газрын байршил;
6. ажиллагаа явуулах хугацаа;
7. ажиллагааг шөнийн цагаар явуулах бол энэ тухай үндэслэл бүхий тайлбар.

Дараах тохиолдолд мөрдөгч, прокурорын зөвшөөрөлтэй явагдах мөрдөн шалгах ажиллагааг прокурорын зөвшөөрөлгүй явуулж болно:

1/ тухайн ажиллагааг хийхгүй бол хүний амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгөд ноцтой хохирол учрахаар бол;

2/ тухайн ажиллагааг хийхгүй бол хэргийн ул мөр, эд мөрийн баримт устгах, зөөвөрлөх, нуун далдлах, үрэгдэх бодит аюул байгаа бол;

Прокурор дээр дурдсан нөхцөл байгаа эсэхийг тодруулахаар тухайн мөрдөн шалгах ажиллагаанд оролцсон хүнийг дуудаж мэдүүлэг авч, шаардлагатай нэмэлт материалыг мөрдөгчөөс гаргуулан авна.

Прокурор нөхцөл байдлыг хянаж үзсэний үндсэн дээр дараах шийдвэрийн аль нэгийг гаргана:

1. мөрдөн шалгах ажиллагааг хүчинтэйд тооцох;
2. мөрдөн шалгах ажиллагаа, нотлох баримтыг хүчингүй болгох.

Мөрдөн шалгах ажиллагаа, тухайн ажиллагааны явцад цугларсан нотлох баримтыг хүчингүй болгох шийдвэрт хураан авсан эд зүйл, баримт бичгийг эзэмшигчид нь эргүүлэн олгохыг даалгана.

Цаашид Авлига, албан тушаалын гэмт хэрэгт мөрдөн шалгах ажиллагаа явуулахад дараах хэдэн асуудлыг анхаарч, зайлшгүй мэдэж байх шаардлагатай.

А. Мөрдөн шалгах ажиллагааны төлөвлөлт:

Авлигын гэмт хэрэг нь ээдрээ төвөгтэй, өргөн цар хүрээнд шалгах шаардлагатай тул мөрдөн шалгах ажиллагаа нь төлөвлөлт, зохион байгуулалтад үндэслэгдэн явагдана.

Төлөвлөгөөний агуулга нь өргөн утгатай ойлголт бөгөөд мөрдөн шалгах ажиллагааны эхнээс нь аваад дуустал үргэлжлүүлэх бүтээлч, зохион байгуулалттай үйл ажиллагааны нийлбэр цогц юм.

Мөрдөн шалгах ажиллагааны төлөвлөгөө нь мөрдөн шалгах ажиллагаа болон эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны тодорхой үе шат бүрт тулгарах шийдвэрлэвэл зохих зорилт, түүнийг шийдвэрлэх ажиллагааны арга, тактикийг тодорхойлж, хэрэгжүүлэх арга замыг сонгон явуулах ажиллагаа юм.

Мөрдөн шалгах ажиллагааны төлөвлөгөө нь ажлын ачааллыг тэнцүүлж тухайн хэрэгт хяналт тавих боломжийг хангаж өгөх ба үйл ажиллагааг оновчтой болгох, хууль ёсыг зөрчихгүй байх үндсэн нөхцөл болдог байна.

Б. Мөрдөн шалгах ажиллагааны төлөвлөгөөнд тавигдах шаардлага:

Мөрдөн шалгах ажиллагааны явцад ямар ажиллагааг, юуг зайлшгүй хийх, бодит үнэнийг тогтоохын тулд тухайн ажиллагааг хэрхэн явуулах вэ гэсэн асуултын шаардлагыг бүрэн хангасан байхаас гадна "Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх хууль"-ийг удирдлага болгон тодорхой дараалалд оруулж мөрдөгчийн дотоод сэтгэхүйн дүгнэлтүүд дээр үндэслэгдсэн байх ёстой.

Төлөвлөгөө нь:

1. Гэмт хэрэгтэй холбогдсон анхны мэдээ, материалыг цуглуулан судлах.
/Цугларсан нотлох баримтад өөрийн итгэл үнэмшлээр үнэлэлт дүгнэлт хийх/

2. Мөрдөн шалгах ажиллагааны зорилтыг тодорхойлж, шийдвэрлэх асуудлын хүрээг тогтоох,

3. Асуудлыг хэрхэн шийдвэрлэх арга замыг тодорхойлж шалгах гэсэн 3 үе шаттай байна.

Нэг дэх үе шат: Гэмт хэргийн талаарх анхны мэдээ, материалыг цуглуулан судлах нь гэмт хэргийг ямар нөхцөлд хэн үйлдсэн байж болох, эд мөрийн баримт юу болох талаар сэжиг таамаг дэвшүүлж байгаа нэгдмэл үйл ажиллагаа боловч баримт, мэдээ цуглуулах, таамаглал дэвшүүлэх гэсэн өөр хоорондоо ялгаатай боловч цугларсан баримт мэдээлэлд түшиглэн сэжиг таамаглал дэвшүүлж байдаг уялдаа бүхий нэгдмэл үйл ажиллагаа болгон авч үзэж байх нь арга зүйн ач холбогдолтой юм.

Хэрэг шалгах төлөвлөлт хийх зорилгоор баримт, мэдээллийг цуглуулахдаа:

1. Илэрч буй баримт мэдээллийн аль нь тухайн хэрэгт нотлох баримт болж болох,

2. Эд мөрийн баримтаар гэмт үйл явдлын чухам аль хэсэг нотлогдож болох,

3. Үүнтэй уялдуулан гэмт хэргийн аль хэсгийг эцэслэн шалгах боломжтой болох,

4. Нэгэнт мэдэгдэж буй нотлох баримтыг ашиглах замаар шинээр ямар нотлох

баримт гаргаж нотлуулах бололцоотой болох.

5. Маргаантай байгаа баримтыг хэдийд яаж хэрхэн шийдвэрлэж болохыг шийдвэрлэсэн байх ёстой.

Хоёр дахь үе шат: нь мөрдөн шалгах ажиллагааны зорилтыг тодорхойлж шийдвэрлэх асуудлын хүрээг тогтоох эрүүгийн хэргийг тал бүрээс нь бүрэн дүүрэн илрүүлэхэд чухал ач холбогдолтой байдаг. Шалгах төлөвлөгөө нь эрүүгийн хэргийг бүрэн төгс шийдвэрлэхүйц тийм хүрээг хамаарах ёстой.

Хэрэв нотолгооны хүрээг хэт өргөн авч үзвэл үйл явдлын мөн чанар хүрэх зорилтыг алдагдуулж хугацааг уртасгахад хүргэдэг бол нотолгооны хүрээг хэт явцууруулбал хэргийг хөтөлбөргүй нотлон тогтоох зорилтыг хязгаарлагдмал байдалд хүргэж зарим нотлох баримтыг орхигдуулдаг муу талтай. Иймд шийдвэрлэх асуудлын хүрээг тогтоохдоо тухайн хэргийн онцлог, орон зай, цаг хугацааг нарийн тооцож төлөвлөх нь илүү үр дүнд хүрэх боломж олгодог.

Гурав дахь үе шатанд шийдвэрлэх арга замыг тодорхойлон шалгах нь чухал ач холбогдолтой. Энд мөрдөгч заавал хийж гүйцэтгэвэл зохих ажиллагаануудыг төлөвлөж, уг ажиллагааг хэрхэн гүйцэтгэвэл зохих арга, тактикаа томьёолж, уг ажиллагааг хэрхэн хэрэгжүүлэх арга замыг оновчтой сонгох явдал чухал юм.

Мөрдөн шалгах ажлын төлөвлөгөөг боловсруулах ажиллагааг үндсэнд нь авч үзвэл мөрдөн шалгах тодорхой ажиллагааны төлөвлөлт нь /нэгжлэг, үзлэг, туршилт, таньж олуулах гэх мэт/ эрүүгийн хэрэгт мөрдөн шалгах ажиллагаа явуулах төлөвлөгөө /түүвэр болон өдөр тутмын төлөвлөгөө гэх мэт/, хэд хэдэн эрүүгийн хэрэгт мөрдөн шалгах ажиллагаа явуулах төлөвлөгөө /өөр төрлийн гэмт хэрэг буюу ижил төрлийн гэмт хэргүүдийг мөрдөхөд хэргийн онцлог, үйлдлийн арга хэрэгслээр төлөвлөх/ зэргээр төлөвлөж болно. Тухайлбал:

1. Гэмт хэргийн шинжийг судалж, тогтооход чиглэсэн ажиллагаа,

2. Сэжиг таамаглалаар,

3. Үйл явдлаар нь,

4. Гэмт хэргийн шинж, бүрэлдэхүүнээр нь,

5. Гэм буруугийн байдлаар нь гэх мэтээр төлөвлөнө.

Сэжиг таамаглалаар төлөвлөх нь ихэнх тохиолдолд гэмт хэрэг гарсан боловч үйлдсэн хүн нь тогтоогдоогүй эсхүл үйл явдал болсон боловч гэмт хэрэг мөн эсэхийг тогтоох зорилгоор ашиглана.

Үйл явдлаар нь төлөвлөх нь гэмт үйл явдал нэлээд олон үйл явдлаас бүрдсэн бөгөөд үйл явдал тус бүр нь бие даасан гэмт хэргийн шинжтэй байх үед ашиглана.

Гэмт хэргийн шинжээр нь төлөвлөх нь нэг гэмт хэргийн хүрээнд хэд хэдэн гэмт хэргийн шинжтэй гэмт хэрэг мөрдөж байгаа үед ашиглана.

Гэмт буруугийн байдлаар төлөвлөх нь гэмт хэргийг бүлэглэн үйлдсэн хэд хэдэн хүн яллагдаж байгаа тохиолдолд хүн бүрийн үйлдлийг гэм буруугаар нь тогтоохоор төлөвлөнө.

Мөрдөн шалгах ажиллагааны төлөвлөгөө нь үйл ажиллагааг дэс дараалалд оруулан цэгцэлдэг төдийгүй үр дүнг нь нэмэгдүүлж, хэргийг богино хугацаанд шуурхай шийдвэрлэх нөхцөлийг бүрдүүлж өгдөг. Мөрдөгч шинжлэх ухааны танин мэдэхүйн арга зүйг эзэмшин, нотлох баримтыг үнэлэн, дүгнэж янз бүрийн нөхцөл байдалд хүмүүсийн үйлдлийг урьдчилан харж чаддаг өөрийн үйл ажиллагааг зөв төлөвлөж ашигтай хэлбэрийг сонгон авч чаддаг байх ёстой.

Мөрдөн шалгах ажиллагааны төлөвлөлтөд баримтлах зарчмууд:

Төлөвлөгөө нь тодорхой, хуульд нийцсэн, хэргийн үйлдлээс шалтгаалан тусгайлан анхаарах асуудлыг заавал тусгасан байх. Төлөвлөгөөнд гүйцэтгэх ажлын ерөнхий чиг зорилтыг тусгах нь хангалтгүй. Иймээс төлөвлөгөө нь тодорхой асуудлуудад товч, ойлгомжтой, хариулт авсан байхаар хийгдэхийн хамт хариуцах эзэн, биелүүлэх хугацааг нарийвчлан зааж өгөх шаардлагатай. Ээдрээ төвөгтэй олон үйлдэл, холбогдогчтой/ хэргийг ажлын хэсэг зохион байгуулж шалгах үед мөрдөгч бүрийн гүйцэтгэх үүргийг нарийвчлан зааж өгөх нь төлөвлөгөөний зарчмын нэг илрэл юм.

Төлөвлөгөө нь хэргийн оролцогч үйлдэл нэг бүрийн онцлогт тохирсон байх. Хэрэг нэг бүр өөрийн гэсэн өвөрмөц онцлогтой байдаг учир түүнд тохирсон төлөвлөгөөтэй байх хэрэгтэй. Өөрөөр хэлбэл хэвшмэл, загварчилсан шинжийг агуулаагүй мөрдөн шалгах ажиллагааны явцад олж авсан мэдээлэл, баримтад үндэслэсэн байх ёстой. Энэ нь хэрэг бүрийн дахин давтагдашгүй байдалд төлөвлөгөө зохиосон мөрдөгчийн мэдлэг, мэргэжлийн ур чадвар, дадлага зэргээс ихээхэн хамаарна.

Төлөвлөгөө хөдөлгөөнтэй амьд байх. Энэ нь нэг удаагийн төлөвлөлтийг бүрэн гүйцэт гэж үзэж болохгүй ба мөрдөн шалгах ажиллагааны явцад олж авсан нотлох баримт мэдээллийг үндэслэн тодотгох, нэмэлт ажиллагааг хийх шаардлагатай асуудлыг тусгах шаардлагатай байдаг тул төлөвлөгөөнд байнга өөрчлөлт орж байх ёстой.

Энэ өөрчлөлт нь төлөвлөсөн асуудлыг шийдвэрлэх арга замыг тодотгох үндэсгүй гэж үзэх эсвэл шинээр тодорхой асуудлыг төлөвлөх зэрэг аль ч хэлбэрээр байж болно. Мөрдөн шалгах ажиллагаа нь цаг хугацааг өрсөж тасралтгүй, давшингуй явагддаг тул ямар ч асуудал шинээр тавигдаж, үгүйсгэгдэж, батлагдаж байдаг тул тэр бүрд тухай бүр цаг алдалгүй төлөвлөгөөнд тусгагдсан байх ёстой.

Төлөвлөгөө бодитой байх. Энэ зарчим нь дараах 2 асуудлыг багтаадаг.

Үүнд: Төлөвлөгөө нь бодит таамаглал, баримт мэдээлэл дээр үндэслэгдсэн байх, төлөвлөсөн ажил, хэрэгжүүлэх арга зам нь ямар ч байдлаар хэрэгжин биелэх бодит боломжтой байх нь үр ашигтай. Өөрөөр хэлбэл тухайн нөхцөлд гүйцэтгэх боломжгүй ажиллагааг төлөвлөх ёсгүй гэсэн үг. Тухайлбал, хээл хахууль өгсөн,

авсан гэмт хэрэг дээр тухайн үйлдлийг сэргээх замаар мөрдөн шалгах туршилт явуулах тухай төлөвлөх нь боломжгүй ажиллагаа юм.

Мөрдөн байцаалтын төлөвлөлтийн төрөл. Мөрдөн шалгах ажиллагааны төлөвлөгөөг хийх арга, зорилго, агуулгаар нь хэд хэдэн хэлбэрээр хийж болно. Үүнд:

1. Мөрдөн шалгах ажиллагааны ерөнхий төлөвлөгөө,
2. Гүйцэтгэх албад болон бусад албадтай хамтарч хэрэг шалгах төлөвлөгөө,
3. Мөрдөн шалгах ажиллагааны хэсэгчилсэн төлөвлөгөө,
4. Мөрдөн шалгах ажиллагааны календарчилсан төлөвлөгөө,
5. Сэжиг, таамаглал шалгах төлөвлөгөө,
6. Түүвэр, төлөвлөгөө гэж ангилж болох юм.

Мөн Авлигын гэмт хэргийг мөрдөн шалгахдаа дараах байдлуудыг анхаарч шалгавал зохино. Үүнд:

Нэг. Болсон үйл баримтын талаар дүгнэлт хийх, /Болж өнгөрсөн үйл явцыг мэдээллийн эх сурвалжтай харьцуулах/,

Хоёр. Үйл баримтыг үндэслэн эрх зүйн ямар төрлийн харилцаа хөндөгдөж байгааг тогтоох /ямар салбарт хэрхэн үйлдэгдсэн болох Боловсрол, Татвар, Гааль, Тендер г.м/

Гурав. Тухайн харилцааг зохицуулсан холбогдох хууль тогтоомжийг тодорхойлох, /Салбарын хууль тогтоомжийг сайтар судлах/,

Дөрөв. Хууль тогтоомжийн ямар зүйл, заалтын гипотез нь уг харилцаанд нийцэж байгааг тогтоох, /эрх мэдлээ хэтрүүлсэн, урвуулсан, эс үйлдэхүй, албаны нэр нөлөөг ашигласан үйлдэл, Хяналтын шатны шүүхийн 2016-05-20 № 141, 2015-06-26 № 222/

Тав. Зүйлчлэхдээ зохих үе шат, алхмаар шалгах, /Таамаг /Версия/ дэвшүүлж, төсөөтэй гэмт хэргийг шалгаж, мухарлах/,

Зургаа. Зүйлчлэхдээ эрх зүйн үндсэн ойлголт, ухагдахуун, нэр томъёог тайлбарлах, тодорхойлох, /албан тушаалтан болох нь ямар хуулиар тодорхойлогдож байгаа Авлигын эсрэг хуулийн 4 дүгээр зүйлд хамаарах субъект мөн эсэх, эрх үүрэг нь салбар хуулийн ямар зүйл заалтаар зохицуулагдсан зэргийг яллагдагчаар татах тогтоолд бүрэн тусгах/,

Долоо. Эрх зүйн өрсөлдөх бусад хэм хэмжээ байгаа эсэх, тэдгээрийг хэрэглэх боломжтой эсэхийг шалгах,

Найм. Авлига болон мөнгө угаах гэмт хэргийг шалгахын зэрэгцээ хүндрүүлэх болон хөнгөрүүлэх шалтгаан нөхцөл, холбоо зэрэг Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн Хууль ёсны зарчим, Шударга ёсны зарчим, Гэм буруугийн зарчим, Эрүүгийн хууль Монгол Улсын нутаг дэвсгэрт үйлчлэх, Эрүүгийн хууль Монгол Улсын нутаг дэвсгэрийн гадна үйлчлэх зэргийг анхаарахаас гадна гэмт хэрэг үйлдэгдсэн бүхий л үе шатыг тогтоох, Тухайлбал: /Эрүүгийн хуулийн 2.7 дугаар зүйл. Гэмт хэрэгт бэлтгэх, гэмт хэрэг туйлдаа хүрээгүй шалтгаан нөхцөлийг тогтоох/, /Эрүүгийн хуулийн 2.8 дугаар зүйл. Гэмт хэрэг үйлдэхээр завдах, гэмт хэрэг үйлдэхээс татгалзах, гэмт хэрэгт оролцогчдын оролцоог тогтоох/, /Эрүүгийн хуулийн 3.1 дүгээр зүйл. Гэмт хэрэгт хамтран оролцох/, Эрүүгийн хуулийн 3.2 дугаар зүйл. Гэмт хэргийн гүйцэтгэгч/, / Эрүүгийн хуулийн 3.3 дугаар зүйл. Гэмт хэргийн зохион байгуулагч/, /Эрүүгийн хуулийн 3.4 дүгээр зүйл. Гэмт хэргийн хатгагч/, /Эрүүгийн хуулийн 3.5 дугаар зүйл. Гэмт хэргийн хамжигч/, /Эрүүгийн хуулийн 3.6 дугаар зүйл. Зөрж гүйцэтгэх/, /Эрүүгийн хуулийн 3.7 дугаар зүйл. Бүлэглэн гүйцэтгэх/, /Эрүүгийн хуулийн 3.8 дугаар зүйл. Зохион байгуулалттай гэмт бүлэг/ зэргийг анхаарч шалгаж, тогтоох нь зүйтэй байна.

ҮР АШИГТАЙ БАЙХ НЬ МӨРДӨН ШАЛГАХ АЖИЛЛАГААНЫ ҮНДСЭН ШИНЖ БОЛОХ НЬ

EFFECTIVENESS IS THE KEY CHARACTERISTICS OF INVESTIGATION

*Н.Сайнбаяр
ДХИС-ийн Цагдаагийн сургуулийн
Эрүүгийн процессын эрх зүйн
тэнхимийн ахлах багш, хууль зүйн
доктор, цагдаагийн хошууч*

Товч агуулга: Төрийн аливаа үйл ажиллагаа нь тодорхой зорилго өмнөө тавьдаг бөгөөд тэрхүү зорилгодоо хамгийн боломжит хувилбар, арга хэрэгслээр хүрэхийг эрмэлздэг. Боломжит гэдэг нь хамгийн бага зардлаар гэсэн агуулгыг илэрхийлнэ.

Гэмт хэрэг шалгах нь үйл явц нь төрийн өвөрмөц үйл ажиллагаа болохын хувьд нийтлэг шинжийг ч мөн өөртөө агуулах учиртай. Энэ хүрээнд эрүүгийн процессын үр ашигтай байдлыг эдийн засгийн талаас нь судлах хэрэгцээ шаардлагыг бий болгосон.

Гэмт хэрэг мөрдөх ажиллагаа нь үр ашигтай байх нь түүний мөн чанарыг илэрхийлнэ. Үр ашигтай гэдэгт төсөр зардлаар ЭХХША-ны зорилтыг хангахад чиглэгдэнэ.

Энэхүү өгүүллэгээр мөрдөн шалгах ажиллагааны үр ашигтай байх шинжийг судалж, тодорхой дүгнэлт санал дэвшүүлэхийг зорилоо. Үр ашигтай байх шинжийг анх удаа судалснаараа судалгааны ажлын ач холбогдлыг илэрхийлж буй юм.

Түлхүүр үгс: Мөрдөн шалгах ажиллагаа, үр ашигтай байх зарчим, ЭХХША-ны зардал.

Аливаа улс орны зүгээс иргэдийнхээ эрүүл аюулгүй байдлыг хангах нь нэн тэргүүний хэрэгжүүлэх үүрэг бөгөөд энэ талаар манай улсын Үндсэн хуульд: “Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц эдийн засаг, нийгэм, хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх, хүний эрх, эрх чөлөөг зөрчихтэй тэмцэх, хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх үүргийг иргэнийхээ өмнө хариуцна⁶⁹” гэж тунхаглан заажээ. Хүний эрх, эрх чөлөөг хангахуйц шинж нь төрийн үйлчилгээ, үйл ажиллагаа нь хүртээмжтэй, оновчтой, үр ашигтай байдлаар илэрхийлэгдэнэ.

Зөрчигдсөн эрхийг сэргээн эдлүүлэх чухал арга хэрэгслийн нэгийг эрүүгийн процессын эрх зүйн хэм хэмжээгээр зохицуулдаг.

Хүний эрх, эрх чөлөөг баталгаатай хангах зорилтын хүрээнд мөрдөн шалгах ажиллагаа нь дараах шинжийг хангасан байх шаардлагатай. Үүнд:

1. Эрүүгийн процесс хуульд үндэслэл, журмыг тодорхой зааж өгсөн байх. Мөрдөн шалгах ажиллагааны онцлог нь зарим тохиолдолд бусдын халдашгүй байдалд халдах шаардлага үүсдэг тул хүний эрх эрх чөлөөг хуульд заасны дагуу л хязгаарлах /Өмчлөгчийн эрхийг гагцхүү хуульд заасан үндэслэлээр хязгаарлаж болно⁷⁰, халдашгүй, чөлөөтэй байх эрхтэй. Хуульд заасан үндэслэл, журмаас гадуур дур мэдэн хэнийг ч нэгжих, баривчлах, хорих, мөрдөн мөшгөх, эрх чөлөөг нь хязгаарлахыг хориглоно⁷¹/ Үндсэн хуулийн заалттай уялдуулан гагцхүү хуульд

⁶⁹ Монгол Улсын Үндсэн хуулийн 19 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг.

⁷⁰ Монгол Улсын Үндсэн хууль. 1992 он. 5 дугаар зүйлийн 3 дахь хэсэг.

⁷¹ Мөн хуулийн 16 дугаар зүйлийн 13 дахь хэсэг.

заасан үндэслэл, журмын дагуу л хүний эрхийн хязгаарлалтыг хэрэгжүүлэх боломжтой юм.

2. Шуурхай хэрэгжих боломжтой байх. Гэмт хэрэг илрүүлэх боломж түүнийг илрүүлэх цаг хугацаатай эсрэг хамааралтай. Өөрөөр хэлбэл, гэмт хэрэг илрүүлэх ажиллагаа хэдий чинээ удаан байна төдий чинээ гэмт хэрэг илрэхгүй байх магадлал ихэсдэг.

Мөрдөн шалгах ажиллагааг түргэн, шуурхай явуулах нь эрүүгийн процессын зорилт хангагдах урьдач нөхцөл болох учиртай. Мөрдөн шалгах ажиллагааны шуурхай шинж нь үндсэн хоёр түвшинд хангагдах учиртай. Нэгд тухайн мөрдөн шалгах ажиллагаа явуулах зөвшөөрөл авах, оролцогчдын оролцуулах ажиллагаа шуурхай байх, хоёрт тухайн мөрдөн шалгах ажиллагааг шуурхай явуулах гэсэн агуулгаар илэрхийлэгдэнэ. Шуурхай хэрэгжих байдал нь ард иргэдийн төрийн үйл ажиллагаанд итгэх итгэлийг нэмэгдүүлдэг бөгөөд гэмт хэрэг үйлдсэн этгээд давтан гэмт хэрэг үйлдэхээс урьдчилан сэргийлэх зэрэг чухал ач холбогдолтой.

Эрүүгийн процессын хуульд прокурорын зөвшөөрлөөр явуулах мөрдөн шалгах ажиллагааны талаар зааж өгсөн бөгөөд хойшлуулшгүй тохиолдолд мөрдөгч тэдгээр мөрдөн шалгах ажиллагааг шуурхай авч 24 цагийн дотор прокурорт тайлбар гаргах зохицуулалт тусгаж өгсөн нь мөрдөн шалгах ажиллагааны шуурхай шинжийг хангаж буй юм. Гэсэн хэдий ч практикт хуулийн дээрх заалт хэрэгжихгүй, амьгүй байсаар байдаг. Тухайлбал, шөнийн цагаар андуурагдсан дансны гүйлгээг мөрдөгчийн зүгээс хязгаарлах боломж нь хууль зүйн талаасаа байдаг хэдий ч бодит байдал дээр хэрэгжих боломжгүй, мөн нөгөөтээгүүр ажлын өдөр байсан ч банк нь Банкны тухай хуулиа бариад заавал прокурорын зөвшөөрөл⁷² шаарддаг г.м хүндрэлүүдийг дурдаж болно.

3. Императив. Энэ нь мөрдөн шалгах ажиллагааны зайлшгүй нэгэн чухал шинж бөгөөд түүний хэрэгжилт нь заавал биелэгдэх шинжтэй байх ёстой. Мөрдөн шалгах ажиллагаа нь төрийн чиг үүргийн хэрэгжилт болохынхоо хувьд төрийн үйл ажиллагааны зарим шинжийг өөртөө агуулдаг нь түүний зөрчигдөх явдлаас төрийн албадлагаар хамгаалагдаж буйг хэлж болно.

Гэмт хэрэг шалгах явцад нотлох баримтыг илрүүлэхийн тулд тодорхой мөрдөн шалгах ажиллагааг заавал явуулах шаардлага үүссэн л бол түүнийг заавал хэрэгжүүлэх нь ЭХХША-ны зорилтыг хангаж буй чухал арга хэрэгсэл юм.

Императив шинж нь мөрдөн шалгах ажиллагааг гарцаагүй явуулах үндэслэл дээр тулгуурлаж бий болно. Тодорхой үндэслэл тогтоогдоогүй байхад мөрдөн шалгах ажиллагаа явуулах нь императив шинжийг үгүйсгэх бөгөөд үр ашигтай байх шинжийг үгүйсгэж буй юм.

4. Үр ашигтай байх. Мөрдөн шалгах ажиллагааны үр дүн нотлох баримт болох шинжээр илэрхийлэгдэнэ. Нотлох баримт гэдэг нь хуульд заасан үндэслэл журмын дагуу, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд ач холбогдолтой баримт мэдээллийг хэлдэг. Мөрдөн шалгах ажиллагааны үр дүн хэрэгт хамааралгүй, ач холбогдолгүй байвал энэ хэрээрээ мөрдөн шалгах ажиллагааны шинжээ алдаж, төрийн үргүй зардал гарсаар байх болно. Мөн үр ашигтай байх шинж нь гэмт хэргийн хохирлоос давсан зардал гаргахгүй гэсэн агуулгаар давхар илэрхийлэгдэнэ. Өөрөөр хэлбэл, 1000 төгрөгийн хохиролтой гэмт хэрэгт 1 сая

⁷² Банкны тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.2.3. "шүүх, прокурорын байгууллагын удирдлага хүсэлт гаргасан, эсхүл авлигатай тэмцэх байгууллага, цагдаагийн байгууллагын хэрэг бүртгэх, мөрдөн байцаах ажиллагааны шаардлагаар, түүнчлэн тагнуулын байгууллага мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй холбогдсон мэдээллийг шалгах шаардлагаар мөрдөгчийн саналыг прокурор зөвшөөрсөн" тохиолдолд бусдад гаргаж өгөх, задруулна.

гаруй төгрөгийн зардал гаргах нь гэмт хэрэгтэй тэмцэх төрийн бодлого оновчтой бус байгаагийн илрэл юм.

Үр ашигтай байх шинжид мөн ЭХХША-ны зорилтод чиглэсэн байхыг хамааруулан ойлгоно. Учир нь ашигтай үйлдэл хэдий ч ЭХХША-ны зорилтод хамаарахгүй аливаа үйлдлийг мөрдөн шалгах ажиллагаа гэж үзэх боломжгүй.

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны зорилт нь гэмт хэргийг шуурхай, бүрэн илрүүлэх, гэмт хэрэг үйлдсэн хүн, хуулийн этгээдийг олж тогтоон шударгаар ял оногдуулах, гэм буруугүй хэнийг ч гэмт хэрэг үйлдсэн гэм буруутайд тооцохгүй байх, хүний эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах, зөрчигдсөн эрхийг сэргээхэд оршино. Өөрөөр хэлбэл, мөрдөн шалгах ажиллагааны зорилт нь эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны зорилт байна⁷³.

ЭХХША нь төрийн үйл ажиллагааны нэгэн төрөл болохын хувьд мөн чанарыг нь илэрхийлэх зорилтыг хуульчлан өгсөн. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны зорилт нь гэмт хэргийг шуурхай, бүрэн илрүүлэх, гэмт хэрэг үйлдсэн хүн, хуулийн этгээдийг олж тогтоон шударгаар ял оногдуулах, гэм буруугүй хэнийг ч гэмт хэрэг үйлдсэн гэм буруутайд тооцохгүй байх, хүний эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах, зөрчигдсөн эрхийг сэргээхэд оршино⁷⁴. Үүнээс ЭХХША-ны мөн чанарыг илэрхийлэх, үнэт зүйлийн элементийг тодорхойлж болно. Үүнд:

1. Гэмт хэргийг шуурхай, бүрэн илрүүлэх;
2. Гэмт хэрэг үйлдсэн хүн, хуулийн этгээдийг олж тогтоон шударгаар ял оногдуулах;
3. Гэм буруугүй хэнийг ч гэмт хэрэг үйлдсэн гэм буруутайд тооцохгүй байх;
4. Хүний эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах;
5. Зөрчигдсөн эрхийг сэргээх зэрэг болно. Өөрөөр хэлбэл, ЭХХША-ны хүрээнд хийгдэж байгаа мөрдөн шалгах болон бусад бүхий л үйл ажиллагаанд дээрх 5 элементийг өөртөө агуулсан байх ёстой гэсэн үг.

ЭХХША-ны зорилт нь эрүүгийн процессын үндсэн чиглэмжийн нэгээхэн хэсгийг илэрхийлж буй боловч түүнд агуулагдаж буй үйл ажиллагаа ямар шинжтэй байх ёстой талаар судлагдаагүй орхигджээ. Дээрх 5 элемент нь ЭХХША-ны зорилт, эрмэлзлийг илэрхийлж байгаа бөгөөд аль нэгийг нь ханган буй үйл ажиллагаа бүр хамаарах боломжтой. Гэвч элемент тус бүрийн онцлогоос үл хамаарч нийтэд байх мөрдөн шалгах ажиллагааны шинжийг ямар байх ёстойг тодорхойлох нь зорилтыг хангахад чухал үүрэгтэй нь мэдээж. Судлаачийн зүгээс нийтлэг шинжид мөрдөн шалгах ажиллагааны үр ашигтай байх шинж зайлшгүй гэж үзсэн.

ЭХХША-ны үр ашигтай байх шинж нь эдийн засгийн талаасаа тайлбарлагдах боломжтой. Өөрөөр хэлбэл, төрийн гэмт хэрэг мөрдөх институтэд зарцуулагдаж буй зардал нь тухайн гэмт хэргийн нийгмийн аюулын шинжээс ямагт байх нь мөрдөн шалгах ажиллагааны үр ашигтай байх шинжийг илэрхийлнэ.

Мөрдөн шалгах ажиллагаа нь төрийн үйл ажиллагааны нэгэн хэлбэр болохын хувьд ямагт ашигтай, төрд өгөөжтэй байх ёстой.

Төрийн зүгээс хэрэгжүүлж буй гэмт хэрэгтэй тэмцэх бодлого, үйл ажиллагаа оновчтой байгаа эсэхийг Чингэлтэй, Сүхбаатар, Сонгинохайрхан дүүргийн цагдаагийн байгууллагад хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтад шалгагдаж байгаа Эрүүгийн хуулийн 17.1 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт заасан 100 хавтаст хэргийн хүрээнд судалгааг явуулав. Учир нь Эрүүгийн хуулийн 17.1 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг нь материаллаг бүрэлдэхүүнтэй 300,000 төгрөгөөс 50,000,000 төгрөг

⁷³ Сайнбаяр, Н. Мөрдөн шалгах ажиллагаа. Нэг сэдэвт бүтээл. УБ., 2024. 35 дах тал.

⁷⁴ Монгол Улсын Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 1.1 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг.

хүртэл хэмжээний хохиролтой хулгайлах гэмт хэрэг хамаарах бөгөөд эдгээр нь эдийн засгийн харьцуулалт хийхэд ач холбогдолтой гэж үзсэн.

Хавтаст хэргийн хүрээнд хийсэн судалгаагаар, дээрх зүйл заалт бүхий хэргийг хэрэг бүртгэлтийн шатанд 1 хоногоос 5 сар хүртэл хугацаанд, мөрдөн байцаалтын шатанд 14 хоногоос 3 сарын хугацаанд багтаан шийдвэрлэгдсэн нь дийлэнх байлаа. Мөн хавтаст хэргийн хуудасны тоо 36-192 хэлбэлзэж байв.

Эдгээр үзүүлэлтэд тулгуурлан, дараах зардлуудыг мөрдөн шалгах ажиллагааны үр ашигтай байх шинжид хамааралтай гэж үзэж тодорхойлсон. Үүнд:

1.Бичиг хэргийн /хавтас, бичгийн цаас, бал, дугтуй, принтерийн хор г.м/. Үүнийг зах зээлийн ханшаар тодорхойлсон бөгөөд хуудасны тоо бүрээр эдийн засгийн үзүүлэлт нэмэгдэнэ. Мөн хавтас бүхий бор цаасны үнэ, дугаарлалт хийж буй дугаарлагч төхөөрөмж, будагч черниль, принтерийн хорыг 500 нүүр хэвлэлтэд нэг гэж тооцох байдлаар тус тус үнэлгээг боловсруулсан.

2.Төрийн алба хаагчдын цалингийн зардал (мөрдөгч, прокурорын хүн цаг). Зөвхөн хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын хугацаанд шалгагдсан хугацааг мөрдөгчийн цалинтай харьцуулан авч үзсэн.

Засгийн газрын 2024.03.27-ны өдрийн тогтоолоор⁷⁵ төрийн тусгай алба хаагчдын цалингийн хэмжээг шинэчилсэн бөгөөд уг тогтоолоор мөрдөгчийн үндсэн цалин 1,541,000-1,618,000 төгрөг болон нэмэгдсэн.

Төрийн тусгай алба хаасны нэмэгдэл: хэрэв алба хаагч 5-10 жил ажилласан бол 10%, 11-17 жил ажилласан бол 15%, 18 ба түүнээс дээш жил ажилласан бол 20%-иар, албан ажлын онцгой нөхцөлийн нэмэгдэл: Гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах алба, Мөрдөн шалгах ажиллагаанд дэмжлэг үзүүлэх мэргэжлийн болон техникийн алба, Дотоод хяналт, шалгалт, аюулгүй байдлыг хангах албанд ажилладаг бол 25%, Цагдаагийн байгууллагын Дэмжлэг үзүүлэх алба, Сургалт дадлагын төв, Интерполын үндэсний товчоонд ажилладаг бол 20%, бусад алба, төрийн захиргааны албан тушаалтан бол 15%-р, цолны нэмэгдэл: офицер бүрэлдэхүүн 30%, ахлагч бүрэлдэхүүн 25%, мэргэшлийн зэргийн нэмэгдэл: 3 жилд 5%, 5 жилд 10%, 10 жилд 15%, 15 жилд 20%, 20 жилд 25%-ийн нэмэгдэл тус тус олгох зохицуулалттай байна⁷⁶.

Нэмэгдсэн хэмжээг дээрх үзүүлэлтэд шилжүүлэн тооцоход дүүргийн цагдаагийн нэгжийн мөрдөгч одоогоор 2,500,000-2,669,000 төгрөгийн цалин авч байна. Цалингийн хэмжээг тогтоосны үндсэн дээр Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2021 оны 12 дугаар сарын 06 -ны өдрийн А/192 дугаар тушаалын дагуу цагийн дундаж хөлсийг тодорхойлно.

3.Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны зардал. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 11.4 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт: хохирогч, түүний хууль ёсны төлөөлөгч, гэрч, хөндлөнгийн гэрч, шинжээч, мэргэжилтэн, орчуулагч, хэлмэрч, өмгөөлөгчид төлөх зардал; эд мөрийн баримтыг хадгалах, шилжүүлэх, шинжлүүлэхэд гарах зардал; хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт, прокурор, шүүхээс оргон зайлсан яллагдагч, шүүгдэгчийг эрэн сурвалжлахад гарах зардал; гэрч, хохирогч, шинжээч, яллагдагч, шүүгдэгчийг албадан ирүүлэх, шүүгдэгч хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр ирээгүйгээс шүүх хуралдааныг хойшлуулахтай холбогдон гарах зардал; тухайн эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх

⁷⁵ Засгийн газрын тогтоол. Дугаар 128. Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоох тухай

⁷⁶ Сайнбаяр, Н. Мөрдөгчийн эрх зүйн байдлын онол, практикийн асуудал. Докторын зэрэг горилсон бүтээл. УБ.,2023.39 дэх тал.

ажиллагаатай шууд холбогдон гарах бусад зардал нь ЭХХША-ны зардалд хамаарах талаар хуульчилжээ.

Тухайн эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаатай шууд холбогдон гарах бусад зардал гэдгийг тодорхойлоогүй бөгөөд тухайн зардал гарахгүйгээр ЭХХША нь зорилтдоо хүрч чадахгүй байгаагаар ойлгоно.

4.Мэдээлэл гаргуулан авахаар тогтоол үйлдэж, илгээж, түүнд нь тухайн байгууллагын ажилтан тодорхой цаг хугацаа зарцуулсан зардлыг цалингийн түвшинтэй нь харьцуулалт хийх замаар тодорхойлсон.

Эрүүгийн хавтаст хэргийн хүрээнд банк, улсын бүртгэлийн байгууллага, хорих ял эдлүүлэх байгууллагын архивын мэдээлэл, эрүүгийн хэргийн төв архив, хувийн аж ахуй нэгж, эмнэлгийн байгууллагаас сэжигтэн, яллагдагчид холбогдох мэдээллийг гаргуулаж авсан нь түгээмэл байна. Байгууллагын онцлогоос хамаарч зарцуулагдаж буй цагийн тооцоогоор зардлыг тодорхойлов.

5.Тухайн хавтаст хэрэгт мөрдөх ажиллагаа явуулах хүрээнд зарцуулсан тээврийн зардал. Цагдан хорих байранд очих, сэжигтнийг баривчлах байранд хүргэж өгөх, хавтас хэргийг шүүх, прокурорт хүргүүлэх, эрэн сурвалжлах ажиллагаа явуулахад зарцуулсан тээврийн хэрэгслийн зардал зэрэг хамаарна.

6. Цагдан хоригдсон тохиолдолд:

6.1. Шүүхийн байгууллагын ажилтнуудын хүн цагийн зардал;

6.2. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын ажилтнуудын хүн цагийн зардал /24 цагийн хяналтын үүрэг гүйцэтгэх тул шөнийн цагийн тариф өндрөөр тооцогдоно/;

6.3. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын нэг хүнд ногдох хоолны зардал;

7. Инженерийн үйлчилгээний зардал: цахилгаан, усны зардал. Мөрдөгч, прокурор нь тухайн хэргийг шалгахад зарцуулсан хугацаагаар тодорхойлогдоно.

8. Бусад зэрэг болно. Тухайн хэргийн онцлогоос хамаарч нэмэлт ажиллагаа хийгдэх боломжтой тул энэ хэсэгт хамааруулахаар тогтов.

Эдгээрт үндэслэн Эрүүгийн хуулийн 17.1 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт заасан хэрэгт төрийн зүгээс 85,000,000-115,000,000 төгрөгийн зардал гаргаж байгаа болохыг тодорхойлов. Өөрөөр хэлбэл, нийгмийн аюулын шинжээс их зардлыг түүнийг шалгаж, илрүүлэхэд зарцуулж байгаа нь мөрдөх институтийг тогтолцоогоор нь эргэж харах шаардлагатай болсныг харуулж байна.

Үр ашигтай байх шинжийг хангасан зохицуулалт, үйл ажиллагааг олон улсын түвшинд түгээмэл хэрэглэж байна. Нөгөөтээгүүр үр ашигтай гэдэг нь ЭХХША-ны зорилтыг хангахад чиглэсэн зардал багатай шийдлийг хамааруулан ойлгож болно. Тухайлбал, АНУ-д Маршалын алба аливаа гэмт хэргийн замаар олсон эд хөрөнгийг битүүмжилж, түүнийгээ борлуулж, өөрсдийн үйл ажиллагаандаа ашиглах, улсын төсөвт шилжүүлэх зэрэг боломжууд нь нээлттэй байдаг⁷⁷, Итали, ОХУ-ын Эрүүгийн процессын хуульд эчнээ шүүхийн үйл ажиллагааны талаар тусгасан байгааг дурдаж болох юм.

Манай улсын Эрүүгийн процессын хуульд эд хөрөнгө битүүмжлэх мөрдөн шалгах ажиллагаа зарим талаараа асар их эдийн засгийн алдагдлыг бий болгож байна.

Хууль бус эд хөрөнгийг хязгаарлах болоод хохирлыг нөхөн төлүүлэх механизмыг тодорхой мөрдөн шалгах ажиллагааны тусламжтайгаар хэрэгжүүлэх бөгөөд тэдний нэг нь эд хөрөнгө битүүмжлэх процесс юм.

⁷⁷ Цахим эх сурвалж: <https://star.worldbank.org/> хандсан 2024.10.11.

Хуульд “Хохирлыг нөхөн төлүүлэх, хор уршгийг арилгуулах болон хөрөнгө, орлого хураах албадлагын арга хэмжээг хангах зорилгоор яллагдагч, шүүгдэгчийн эд хөрөнгийг шүүх, прокурорын шийдвэрээр битүүмжилнэ”⁷⁸ гэж заасан байдаг.

Хуулийн зохицуулалт нь оновчтой боловсруулагдсан гэвэл бас үгүй юм. Учир нь эд хөрөнгө битүүмжлэх зорилгыг “Хохирлыг нөхөн төлүүлэх, хор уршгийг арилгуулах болон хөрөнгө, орлого хураах албадлагын арга хэмжээг хангах” гэж тодорхойлсон боловч хууль бусаар олсон орлого, эд хөрөнгийг битүүмжлэх боломжгүй юм. Мөн зөвхөн яллагдагч, шүүгдэгчийн эд хөрөнгийг битүүмжлэх боломжтой байгаа нь хэрэг бүртгэлтийн явцад багагүй хүндрэл бэрхшээлийг дагуулж байна. Нөгөө талаар тодорхой эд хөрөнгийг битүүмжлэх сонирхлыг эхэндээ тавьж, үүнийхээ тулд гэмт хэрэг үйлдсэн нь хангалттай тогтоогдоогүй байхад хүнийг яллагдагчаар татах хандлага бий болох эрсдэлтэй юм⁷⁹.

Эд хөрөнгө битүүмжлэхэд тулгамдаж буй өөр нэгэн асуудал нь тээврийн хэрэгслийг битүүмжлэх явдал байдаг. Учир нь тээврийн хэрэгсэл битүүмжлэх нь мөрдөх ажиллагаанд эдийн засгийн хувьд сөрөг нөлөө үзүүлдэг. Энэ нь мөрдөн шалгах ажиллагаа үр ашигтай байх ёстой гэсэн зарчимтай зөрчилддөг. Битүүмжилсэн эд хөрөнгийн битүүмжлэх үеийн үнэлгээг хийж, зориулалтын хашаанд хадгалах байдлаар явагддаг. Тээврийн хэрэгслийг 1 хоног битүүмжиллээ гэхэд тээврийн хэрэгслийн марк, үйлдвэрлэсэн хугацаанаас хамаарч хоног өнгөрөх тусам үнэлгээ нь буурч байдаг, хадгалалтын зардал өсөн нэмэгдсээр байдаг, тухайн тээврийн хэрэгслийг ашиглахгүй тодорхой хугацаа өнгөрөхөд техникийн элэгдэлд орж байдаг зэрэг нөхцөл байдлаас хамаарч хохирлыг нөхөн төлүүлэх, хор уршгийг арилгуулах болон хөрөнгө, орлого хураах албадлагын арга хэмжээг хангах зорилго бүрэн алдагддаг. Үүний тод жишээ нь 2000 оны эхээр үйлдэгдсэн хадгаламж зээлийн хоршоодтой холбоотой хэргийг дурдаж болох юм. Тухайн үед битүүмжлэгдсэн тодорхой нэг тээврийн хэрэгслийг 2,500,000 төгрөгөөр үнэлж байсан хэдий ч хэргийг шалгаж, шүүхээр шийдвэрлэгдсэний дараа шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны явцад тухайн тээврийн хэрэгсэл ямар ч ажиллагаагүй болсон байсан.

Иймээс тээврийн хэрэгслийг битүүмжлэх буюу хөдлөх эд хөрөнгийг битүүмжилсэн тохиолдолд тухайн үед нь зарж борлуулж олсон орлогыг тусгай дансанд байршуулж дээрх зорилгыг хангадаг олон улсын туршлагыг нэвтрүүлэх боломжтой юм⁸⁰.

Түүнчлэн, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулиар зөвхөн яллагдагч, шүүгдэгч “биеэр” байгаа тохиолдолд л ЭХХША хэвийн үргэлжлэхээр зохицуулалтууд нь дэлхийн нийтийн чиг хандлагаас хоцрогдох болов. Сэжигтэн, яллагдагч, шүүгдэгчийн хувьд эрүүгийн хариуцлагаас зайлсхийх хүсэл сонирхол ямагт байдаг тул ЭХХША-наас оргон зайлах, элдэв бусад шалтаг тооцон хүрэлцэн ирэхгүй байх тохиолдлууд цөөнгүй байдаг боловч тэдгээрийг эрэн сурвалжилж олж тогтоосны дараа ЭХХША-г үргэлжлүүлэн явуулдаг.

Энэ нь эрэн сурвалжлах ажиллагаанд тодорхой зардал гарах, мөн гэмт хэргийг шуурхай бүрэн дүүрэн илрүүлэх гэсэн ЭХХША-ны зорилтыг алдагдуулах зэрэг сөрөг үр дагаврыг бий болгодог. Мөн нөгөөтэйгүүр сэжигтнийг баривчлах байрнаас гаргасны дараа эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татсаны дараа тогтоолтой танилцуулахаар дуудсан тохиолдолд сэжигтэн оргон зайллаа гэхэд түүнд цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээ авах болон дахин баривчлах ямар ч боломжгүй байдаг.

⁷⁸ Монгол Улсын Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 21.2 дугаар зүйлийн 1 дэх хэсэг.

⁷⁹ Сайнбаяр Н. Мөрдөн шалгах ажиллагаа. Нэг сэдэвт бүтээл. УБ., 2024. 110 дах тал.

⁸⁰ Сайнбаяр, Н. Мөрдөн шалгах ажиллагаа. Нэг сэдэвт бүтээл. УБ., 2024. 120 дах тал.

Эдгээр нь ЭХХША-ны зорилтыг хангах төвөгтэй байдал үүсгэхээс гадна төрийн үр ашиггүй зардлыг нэмэгдүүлэх, мөрдөх ажиллагааны ач холбогдлыг бууруулах зэрэг тогтолцооны гажуудлыг үүсгэх эрсдэлтэй ажээ.

Дүгнэлт

Судалгааны ажлын явцад дараах дүгнэлтэд хүрэв. Үүнд:

1. Мөрдөх ажиллагааны мөн чанарыг илэрхийлж буй “үр ашигтай байх” шинжийг нарийвчлан судлах хэрэгцээ шаардлага байсаар байна.

2. Эрүүгийн хуулийн тусгай ангид заасан зарим төрлийн гэмт хэрэгт, тодруулбал, Эрүүгийн хуулийн 17.1 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт заасан гэмт хэргийн нийгмийн аюулын шинж, учирсан хохирлоос давсан зардал гаргаж байгааг судалгаагаар тодорхойлов.

3. Зарим төрлийн мөрдөн шалгах ажиллагаа тэр дундаа тээврийн хэрэгслийг битүүмжлэх ажиллагаа нь ямар ч үр ашиггүй ажиллагаа болохыг судалгаа харуулав.

4. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд яллагдагч, шүүгдэгч биеэр оролцсоноор л хэвийн үргэлжилдэг нь эдийн засгийн зардал өндөр, ЭХХША-ны зорилт хангагдахгүй зэрэг сөрөг үр дагавартай аж.

Судалгааны дүгнэлтэд үндэслэн дараах саналыг дэвшүүлж байна. Үүнд:

1. Мөрдөн шалгах ажиллагааны үр ашигтай байх шинжийг эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгохдоо удирдлага болгох.

2. Эд хөрөнгийг битүүмжлэх ажиллагааны эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох, ингэхдээ битүүмжилсэн эд хөрөнгийг мөрдөн байцаалтын шатанд захиран зарцуулах, борлуулах, улсын орлого болгох зэрэг хэм хэмжээг зайлшгүй оруулах. Энэ нь мөрдөх байгууллагын эд хөрөнгө битүүмжлэх эрмэлзлийг нэмэгдүүлж, улмаар төрийн үйл ажиллагааны үр өгөөжийг нэмэгдүүлэх ач холбогдолтой.

3. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд гадаадын зарим улс орнуудын эрүүгийн процесст хэрэглэж буй “эчнээ хянан шийдвэрлэх ажиллагаа”-г нутагшуулах зэрэг болно.

Ашигласан материал

1. Монгол Улсын Үндсэн хууль 1992 он;
2. Эрүүгийн хууль 2015 он;
3. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль 2017 он;
4. Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 3 дугаар сарын 27-ны өдрийн Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоох тухай 128 дугаар тогтоол.
5. Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2021 оны 12 дугаар сарын 06-ны өдрийн А/192 дугаар тушаал;
6. Сайнбаяр, Н. Мөрдөн шалгах ажиллагаа. Нэг сэдэвт бүтээл. УБ.,2024;
7. Конституция Российской Федерации /принята всенародным голосованием 12.12.1993 с изменениями, одобренными в ходе общероссийского голосования 01.07.2020/;
8. "Уголовно-процессуальный кодекс Российской Федерации" от 18.12.2001 N 174-ФЗ (ред. от 02.10.2024);
9. Цахим эх сурвалж: <https://legalinfo.mn/>;
10. Цахим эх сурвалж: <https://star.worldbank.org/>.

ӨСВӨР НАСНЫ ХҮНИЙ ҮЙЛДСЭН ГЭМТ ХЭРЭГТ МӨРДӨН ШАЛГАХ АЖИЛЛАГАА ЯВУУЛАХАД АНХААРАХ АСУУДАЛ

CRIMES COMMITTED BY JUVENILE PERSONS IN CONDUCT OF TRACKING SOME ISSUES TO CONSIDER

Д.Бат-Эрдэнэ

*ДХИС-ийн Цагдаагийн сургуулийн Эрүүгийн процессын эрх зүйн
тэнхимийн багш, цагдаагийн ахмад*

Товч агуулга: Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа явуулахад өсвөр насны хүний үйлдсэн хэргийг шийдвэрлэхэд тусгай журмаар зохицуулахаар хуульд бүлэг, зүйл, заалт тусгасан нь өсвөр насны сэжигтэн, яллагдагчийг эрх ашгийг хамгаалж өмгөөлөгч оролцуулан явуулах, мөрдөн шалгах ажиллагаа явуулахад тусгай журмаар зохицуулж өгсөн нь чухал ач холбогдолтойг илэрхийлж байна. Өсвөр насны сэжигтэн, үйлдсэн гэмт хэргийн шалтгаан нөхцөл, мөрдөн шалгах ажиллагаанд анхаарах асуудал, шүүхээр шийдвэрлэсэн хэргийн тоон мэдээнд дүн шинжилгээ хийж санал, дүгнэлт өгөхийг зорилгоо.

Abstract: The fact that groups, articles, and clauses are included in the law to regulate cases committed by juveniles by special procedures during criminal proceedings, indicates the importance of special procedures for investigating juvenile suspects and accused persons with the participation of a lawyer to protect their rights. It is intended to provide opinions and conclusions by analyzing data on teenage suspects, causes and conditions of crimes committed, issues to be considered in the investigation, and cases decided by the court.

Түлхүүр үгс: Өсвөр насны сэжигтэн, яллагдагч, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа, хүний эрх эрх чөлөө, эрүүгийн хариуцлага,

Keywords: Juvenile suspects and accused persons, proceedings, human rights and freedoms, criminal responsibility,

Гэмт хэрэг үйлдэх үедээ арван дөрвөн насанд хүрсэн ба арван найман насанд хүрээгүй байсан хүнийг өсвөр насны хүн⁸¹ гэнэ.

Өсвөр насны хүнд хүлээлгэх хариуцлага нь түүний нас, биед тохирсон, эрүүл мэнд, ёс суртахуун, сэтгэцийн онцлогийг харгалзсан, нийгэмд өөрийн байр суурийг олоход туслах, боловсрол эзэмшүүлэх, үйлдсэн гэмт хэргийнх нь хор уршгийг ухамсарлуулах, гэмт хэрэг үйлдэхэд хүргэсэн орчин, хүмүүсийн нөлөөнөөс тусгаарлах, шаардлагатай тохиолдолд гэмт хэрэг үйлдсэн хүнийг хорьж хүмүүжүүлэхэд чиглэсэн байна.

Өсвөр нас гэдэг нь хүүхэд насанд хүрэгчдийн эгнээнд шилжих хөгжлийн үе бөгөөд тэдний бие бялдар танин мэдэхүйн, нийгэмшихэд зөрчил, өөрчлөлт бий болдог үе юм. Өсвөр нас бол хүний өсөлт бойжилт сэтгэл санааны хамгийн чухал үе, энэ үед хүүхдийн бие физиологи, сэтгэлзүй, харилцаа, хандлага, гэх мэт зүйлсэд гэнэтийн өөрчлөлтүүд гарч, олон асуудалтай нүүр тулгардаг.

Өсвөр насны хүүхдийн сэтгэл зүйн онцлог нь дараах байдлаар илэрдэг

- Бусдыг өрөвдөх, хайрлах, бусдад хайрлуулахыг хүсдэг,
- Хэн нэгэнтэй ойр дотно харилцаатай байх, хайрлаж дурлах хүсэл сонирхолтой болох,
- Нийгэмших хэрэгцээ бий болох,

⁸¹ Лхагварачаа.Б, Эрүүгийн процессын эрх зүй /сурах бичиг/. УБ.,2021

- Тулгамдаж байгаа асуудлаа нээлттэй ярилцаж, санал бодлоо хуваалцдаг болох, өөр талаараа зөвлөгөө авахыг хүсэх,
- Уурлах бухимдах, бага зэрэг түрэмгий аашлах,
- Амархан баярлах, гомдож уйлах,
- Уйтгарлах, ганцаардсан мэдрэмж төрөх,
- Ямар нэгэн зүйлд идэвхгүй болж сонирхол төрөхгүй байх
- Дуугаа хураах зэрэг сэтгэл зүйн хариу урвал үзүүлдэг.⁸²

Монгол улсын Үндсэн хуулийн “Хүний эрх, эрх чөлөө” гэсэн бүлэгт Монгол улсын иргэн бүр, амьдах явах, хууль шүүхийн өмнө эрх тэгш байх, гэм буруутай нь хуулийн дагуу шүүхээр нотлогдох хүртэл хэнийг ч гэмт хэрэг үйлдсэн гэм буруутайд тооцохгүй байх, иргэний халдашгүй чөлөөтэй байх, иргэний хувийн гэр бүл, захидал харилцааны нууц, орон байрны халдашгүй байдлыг хамгаалах, зөрчигдсөн эрхээ хамгаалуулахаар шүүхэд гомдол гаргах, бусдын хууль бус ажиллагааны улмаас хохирсон бол түүнээ нөхөн төлүүлэх, өөрийгөө өмгөөлөх, өмгөөлүүлэх эрхээр хангагдах эрхийг баталгаажуулсан билээ.

Хүүхэд Монгол Улсын иргэн бөгөөд гэр бүлийнхээ нэг гишүүний хувьд төрөлхөөс заяагдмал, хуулиар баталгаажсан эрхээ насан хүрэгчийн нэгэн адил эрх тэгш, бүрэн эдлэх учиртай.

1. Амьд явах эрх,
2. Хүүхэд бүр эрүүл аюулгүй орчинд амьдрах эрхтэй,
3. Хүүхэд зөрчигдсөн эрхээ хуулиар хамгаалуулах
4. Өөрийн болон гэр бүлийн гишүүд, эцэг эхийнхээ эсрэг мэдүүлэг өгөхгүй байх,
5. Эрүүгийн хэрэг болон иргэний маргаанд оролцогч хэн боловч өөрөө өөрийгөө өмгөөлөх эрхтэй,
6. Аливаа хэрэг, маргааныг шударга шүүхээр шүүлгэх эрхийг хүүхэд эдэлнэ.

⁸³

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх,

Насанд хүрээгүй гэмт хэрэгтнүүдэд дараах шинжүүд харьцангуй түгээмэл ажиглагддаг Үүнд:

- Ёс суртахуун, зан төлөвийн доголдолтой. Тэр байдал нь амьдрал үйл хөдлөл дээр бага илэрдэг.
 - Мөрийтэй тоглох, согтууруулах ундаа хэрэглэх, зан заншлыг үл тоомсорлох,
 - Сургалт хүмүүжлийн болон албан газар, гэрээсээ оргон зайлах, тэнүүчлэх байдлаар амьдрах,
 - Бэлгийн харьцаанд эрт орох, бэлгийн замбараагүй амьдралд дасах,
 - Хүчирхийлэх зан үйлүүд, бүдүүлэг авирлах, өш хонзон авах, хорон муу санах,
 - Эцэг эх болон гэр бүлийн гишүүдээ заналхийлэх гэх мэт байнгын хэрүүлтэй, зөрчилдөөний үндсэн өдөөгч нь байх.
 - Сахилга сайтай, сурлагын амжилтаар сайн хүүхдэд дайсагнах,
 - Буруу зүйлийг тусган сурч авахдаа хурдан, түүнийгээ даруй хэрэгжүүлдэг.
- Насанд хүрээгүй хүүхдийг гэмт хэрэг зөрчил үйлдэхэд хүргэдэг шалтгаан нөхцөл нь:

Гэр бүл хүмүүжлийн сөрөг нөлөөллийн улмаас хэрэг үйлдсэн байдаг. Гэр бүлийн гишүүдийн доторх нийгэмд харш үзэл бодол, дадал заншил, эцэг эх нь

⁸² Википедия eagle.mn “Өсвөр нас бол хүний өсөлт бойжилт, сэтгэл санааны хамгийн чухал үе”

⁸³ Батсуурь.М, Хүүхэд ба хууль ёс / хуульчдад зориулсан сургалтын гарын авлага/,2008.,УБ 5,6 дахь тал

хүүхдээ хүмүүжүүлэх хүндэт үүргээ үл биелүүлж хайхрамжгүй хандаж хараа хяналтгүй орхисон байдаг. Эцэг эх хоёулаа байхгүй үед хүүхдийг асран хамгаалагч болох төрөл төрөгсөд, иргэд хариуцлагагүй хандсан зэргээс шалтгаалж хүүхэд хараа хяналтгүй болдог байна. Хүүхдээр наймаа хийлгэх, хулгай хийлгэх, мөрийтэй тоглоом тоглуулах зэргээр хүүхдийг хүсээгүй байхад хөдөлмөр эрхлүүлэх, мөн найз нөхдийн нөлөө их байдаг байна.

Өнөө үеийн нийгэм эдийн засгийн хямрал / нийгэм бичил орчны сэтгэл зүйн зохих түвшингийн харьцааны доголдол, сургалт, хүмүүжлийн ажиллагааны хайхрамжгүй байдал, бага наснаас мэдээллийн хомсдолд орох/ зэрэг нь хүүхэд залуучуудын дунд оюуны хомсдол, ёс зүй, зан үйлийн этгээд өөрчлөлтүүд гаргах явдлыг мэдэгдэхүйц нэмэгдүүлж байна. Гол төлөв 16 хүртэлх насны хүүхдүүд хараа хяналтгүй, асран хамгаалагчгүй байгаагаас болж сургууль завсардаж дэмий сэлгүүцэж яваад өөртэйгөө төстэй найз нөхдийг олж үерхэн уруу татагдах эсвэл насанд хүрсэн хүний хатгалгаар гэмт хэргийн ертөнц рүү хөл тавьдаг байна. Тэд сургалт, хүмүүжлийн ажил, хамт олны нөлөөнөөс хөндийрснөөс мэдлэг боловсрол, багатай, зан төлөв, ёс суртахууны доголдолтой, ирээдүйдээ ямар ч итгэлгүй болдог.⁸⁴

Өсвөр насны хүний үйлдсэн гэмт хэргийг мөрдөн шалгах ажиллагаа

Улсын хэмжээнд өсвөр насны хүүхдийн үйлдсэн гэмт хэргийн тоо хоёр жилийн өмнө 3.7 хувь байсан бол өнгөрсөн 5.4 хувь болж өсжээ.

Хэрэгт холбогдсон хүүхдүүдийн 98 шахам хувь нь санаатай 1.5 хувь нь болгоомжгүй байдлаар гэмт хэрэгт холбогджээ.

Улсын хэмжээнд өсвөр насны хүүхдийн үйлдсэн гэмт хэргийн тоо хоёр жилийн өмнө 3.7 хувь байсан бол өнгөрсөн 5.4 хувь болж өсжээ.

Хэрэгт холбогдсон хүүхдүүдийн 98 шахам хувь нь санаатай 1.5 хувь нь болгоомжгүй байдлаар гэмт хэрэгт холбогджээ.

Хүүхэд гэмт хэрэгт холбогдох болсон шалтгаан, нөхцөлийг мэргэжлийнхэн “Нийгмийн байдал, ажилгүйдэл, архидалт, өрхийн амьжиргааны түвшин, сургууль, цэцэрлэгт хүмүүжээгүй. Ялангуяа Эцэг, эх, асран хамгаалагчийн хүүхдэдээ тавих анхаарал сул, цахим орчны зохисгүй хэрэглээ, аливаа мэдээ мэдээлэлд, бодитой дүгнэлт хийх чадамжгүй байдал” нь өсвөр насны хүүхдийг гэмт хэрэгт холбогдоход шууд нөлөөлсөн гэж дүгнэжээ.⁸⁵

Цагдаагийн байгууллагад энэ оны эхний 9 сарын байдлаар 22941 гэмт хэрэг бүртгэгдсэн байна. Бүртгэгдсэн гэмт хэрэгт хүүхэд холбогдсон 15 хүртэлх насны 320, 16-17 насны 337, 18-24 насны 3134 хүн холбогдон шалгагдсан байна.⁸⁶

Насанд хүрээгүй хүний үйлдсэн гэмт хэрэгт мөрдөн шалгах ажиллагаа явуулахдаа мөрдөгч тодорхой төрлийн гэмт хэргийг мөрдөн шалгах нийтлэг журмыг мөрдөхөөс гадна насанд хүрээгүй хүний нас, бие сэтгэл зүйн онцлог, сурган зүйн зохих мэдлэг эзэмшсэн байхын зэрэгцээ хуульд заасан тусгай журмыг мөрдөнө.

Насанд хүрээгүй хүний үйлдсэн гэмт үйлдэл нь ухамсарласан /өөрөө хүсэж/ санаатай үйлдсэн шинжтэй ч тэдний сэтгэл зүйн онцлогтой холбоотойгоор ойр зуурын хэрэгцээгээ хангах, насанд хүрэгчдийг дуурайх, бодит байдлыг зөв үнэлж чаддаггүйгээс мөн бие хүн гэдгээ харуулах гэсэн хүслээс эрсдэлтэй алхам хийж гэмт хэрэг үйлдэх нь цөөнгүй. Тэдэнд түгээмэл илэрдэг зөрүүдлэх, худал ярих,

⁸⁴ Хишиг-Ундрах., “Хуулийн сэтгэл судлал” УБ., 2021.,

⁸⁵ Mnb.mn МҮОНП-ийн “Хурд агентлэг”

⁸⁶ <https://information.police.gov.mn/as/staticnum>

бүдүүлэг авирлах, цочмог зантай байх нь насны онцлогтой холбоотой гэхээс илүүтэй өсөж хүмүүжсэн орчин, амьдралын нөхцөл, хүмүүжилтэй нь холбоотой.

Насанд хүрээгүй хүний онцлог нь Физиологи, оюун санааны хөгжлийн хувьд гүйцэт боловсроогүйн улмаас өөрийн үйлдлийн мөн чанарыг ойлгохгүй байх, эцэг эхийн хайхрамжгүй байдал, амьдралын нөхцөл (эцэг эх нь нас барсан, салсан, өвчтэй, архи уудаг, байнга зодолдож, хэрэлдэх, хүүхдийг хүчирхийлдэг зэрэг сөрөг нөлөөлөл), өсөж торнисон орчны нөлөөлөл болон насанд хүрэгчийн хууран мэхлэлт, айлган сүрдүүлэлт, ятгалаг, зэрэг хүчин зүйлээс шалтгаалан гэмт хэрэг үйлдэх нь бий.⁸⁷

Өсвөр насны сэжигтэн, яллагдагч, шүүгдэгчийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд өмгөөлөгчийг заавал оролцуулах бөгөөд өсвөр насны сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч, түүний хууль ёсны төлөөлөгч, өмгөөлөгч, сонгоогүй бол томилогдсон өмгөөлөгчийг оролцуулна.

Хүүхдийн асуудал эрхэлсэн төрийн байгууллагын ажилтныг дараах тохиолдолд өсвөр насны сэжигтэн, яллагдагчийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд байлцуулж болно.

- Өсвөр насны сэжигтэн, яллагдагч гэр бүлийн хүчирхийлэл, эцэг эхийн нөлөөлөлд автаж гэмт хэрэг үйлдсэн,
- Өсвөр насны сэжигтэн, яллагдагч нь сэтгэцийн өвчингүй боловч ухаан санаа нь гүйцэд хөгжөөгүйн улмаас өөрийн үйлдэл холбогдлыг бүрэн ойлгож, болсон хэргийн талаар үнэн зөв мэдүүлэг өгөх эсэхэд эргэлзээ төрвөл,
- Хууль ёсны төлөөлөгч нь өсвөр насны сэжигтэн, яллагдагчийн эрх, хууль ёсны ашиг сонирхолд хохирол учруулж болзошгүй гэж үзвэл,

Мөрдөгч нь өсвөр насны сэжигтэн, яллагдагчийг албадан ирүүлсэн, баривчилсан, цагдан хорьсон тухай түүний гэр бүлийн гишүүн, хууль ёсны төлөөлөгч, эсхүл өмгөөлөгчид нь 6 цагийн дотор мэдэгдэх үүрэгтэй.

Мэдүүлэг авах үед мөрдөгчийн зөвшөөрснөөр хууль ёсны төлөөлөгч, сурган хүмүүжүүлэгч арван найман насанд хүрээгүй хүнээс асуултыг зөв ойлгосон эсэх тодруулж, тайлбарлан өгч болно.⁸⁸

Өсвөр насны яллагдагч, шүүгдэгчийн хувийн байдалтай нь холбоотой дараах мэдээллийг тогтоосон байна.

- Төрсөн он, сар, өдөр, нас
- Амьдралын нөхцөл байдал, ба хүмүүжил
- Гэмт хэрэг үйлдэхэд нөлөөлсөн шалтгаан нөхцөл
- Гэмт хэрэг хамтран үйлдэгч байсан эсэх,
- Сэтгэцийн өвчинтэй холбогдолгүй боловч ухаан санаа нь гүйцэт хөгжөөгүйн улмаас өөрийнхөө үйлдлийн холбогдлыг бүрэн ойлгож байгаа эсэхэд эргэлзээ төрвөл шинжилгээ томилох,
- Өсвөр насны яллагдагч, шүүгдэгчийн насыг хуулийн дагуу авсан иргэний бүртгэлийн бичиг баримтаар тодорхойлно.⁸⁹

Шүүхийн ерөнхий зөвлөлөөс гаргасан статистик мэдээгээс үзвэл ял шийтгүүлсэн нийт 14192 хүнийг зарим бүлгээр нь авч үзвэл 1702 буюу 12 хувь нь эмэгтэй, 222 буюу 1.6 хувь нь өсвөр насны хүн ял шийтгүүлсэн бол 3091 буюу 21.8 хувь нь урьд ял шийтгүүлсэн, 665 буюу 4.7 хувь нь бүлэглэж үйлдсэн 2999 буюу 21.1 хувь нь согтуугаар гэмт хэрэг үйлдсэн байна. Ял шийтгүүлсэн эмэгтэйчүүдийн тоо өмнөх оноос 71 хүн буюу 4.4 хувь, өсвөр насны хүний тоо 13 хүн буюу 6.2

⁸⁷ Оюунчимэг.Т "Криминалистикийн арга зүй" УБ.2024.,276 дахь тал

⁸⁸ Лхагварачаа.Б, Эрдэнэбаатар.П, Эрүүгийн процессын эрх зүй /сурах бичиг/. УБ.,2021.,328 дахь тал

⁸⁹ Бат-Эрдэнэ.Б "Монгол Улсын эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх эрх зүй" /альбом-схем/ УБ.2018. 214 дэх тал

хувиар өссөн бол бүлэглэж үйлдсэн хүний тоо 47 хүн буюу 6.6 хувиар, согтуугаар үйлдсэн хүний тоо 895 хүн буюу 22.9 хувиар тус тус буурсан дүнтэй гарсан байна.

90

Хүснэгт №1. Ял шийтгүүлэгчид, зарим бүлгээр:

№	Утга	2022	2023	Өсөлт, бууралт	Хувь
1	Урьд шийтгүүлсэн ял	3627	3091	-536	-14.7
2	Бүлэглэж үйлдсэн	712	665	-47	-6.6
3	Согтуугаар үйлдсэн	3894	2999	-895	-22.9
4	Эмэгтэй	1631	1702	71	4.4
5	Өсвөр насны хүн	209	222	13	6.2

Өсвөр насны хүнд эрүүгийн хариуцлага хүлээлгэх онцлог

Эрүүгийн хуулийн дагуу гэмт хэрэг үйлдэхийн өмнө 16 насанд хүрсэн хүнд эрүүгийн хариуцлага хүлээлгэхээр заасан байдаг боловч зарим тодорхой гэмт хэргийн хувьд 14 насанд хүрсэн хүнд эрүүгийн хариуцлага хүлээлгэнэ.

Өсвөр насны хүнд эрүүгийн хариуцлага хүлээлгэх үндэслэл нь:

1. Өсвөр насны хүнд хүлээлгэх эрүүгийн хариуцлага нь түүний нас, биед тохирсон, эрүүл мэнд, ёс суртахуун, сэтгэцийн онцлогийг харгалзсан, нийгэмд өөрийн байр суурийг олоход туслах, боловсрол, эзэмшүүлэх, үйлдсэн гэмт хэргийнх нь хор уршгийг ухамсарлуулах, гэмт хэрэг үйлдэхэд хүргэсэн орчин, хүмүүсийн нөлөөнөөс тусгаарлах, шаардлагатай тохиолдолд гэмт хэрэг үйлдсэн өсвөр насны хүнийг хорьж хүмүүжүүлэхэд чиглэсэн байх,
2. Шүүх гэмт хэрэг үйлдсэн өсвөр насны хүний хувийн байдал, гэмт хэрэг үйлдсэн нөхцөл байдлыг харгалзан Эрүүгийн хуулийн өсвөр насны хүнд эрүүгийн хариуцлага хүлээлгэх бүлэгт заасан журмын дагуу ял оногдуулж, оногдуулсан ял дээр нэмж эсхүл ял оногдуулахгүйгээр хүмүүжлийн чанартай албадлагын арга хэмжээ хэрэглэж болно,
3. Хорих ялын доод хэмжээг таван жилээс дээш хугацаагаар тогтоосон гэмт хэрэг үйлдсэн өсвөр насны хүнд ял оногдуулахгүйгээр хүмүүжлийн чанартай албадлагын арга хэмжээг дангаар хэрэглэж болохгүй.

Гэмт хэрэг үйлдсэн өсвөр насны хүнд дараах ял оногдуулна:

- Нийтэд тустай ажил хийлгэх
- Зорчих эрхийг хязгаарлах
- Сургалт-Хүмүүжлийн тусгай байгууллагад хорих

Нийтэд тусгай ажил хийлгэх ял- Нийтэд тустай ажил хийлгэх ялыг өдөрт гурваас дээшгүй цагаар эдлүүлж нэг зуун хориос гурван зуун жаран цагаар тогтооно.

Шүүх нийтэд тустай ажил хийлгэх ял дээр нэмж хүмүүжлийн чанартай албадлагын арга хэмжээ хэрэглэж болно.

Зорчих эрхийг хязгаарлах ял- Шүүх эрүүгийн хуулийн тусгай ангид зорчих эрхийг хязгаарлах ял оногдуулахаар заасан гэмт хэрэг үйлдсэн өсвөр насны хүнд Эрүүгийн хуулийн 5.5 дугаар зүйлд заасан журмаар тусгай ангид заасан зорчих эрхийг хязгаарлах ял оногдуулж эдлэх ялыг хоёр дахин багасгана.

Сургалт-Хүмүүжлийн тусгай байгууллагад хорих ял- Эрүүгийн хуулийн тусгай ангид хорих ял оногдуулахаар заасан гэмт хэрэг үйлдсэн өсвөр насны хүнд

⁹⁰ Монгол Улсын шүүхийн 2023 оны бүтэн жилийн шүүн таслах ажиллагааны нэгдсэн дүн мэдээ

Эрүүгийн хуулийн 5.6 дугаар зүйлд заасан журмаар тусгай ангид хорих ял оногдуулж эдлэх ялыг хоёр дахин багасгана.⁹¹

Хүмүүжлийн чанартай албадлагын арга хэмжээ:

Эрүүгийн хуулийн тусгай ангид хорих ялын дээд хэмжээг найман жил, түүнээс доош хугацаагаар тогтоосон, эсхүл энэ хуулийн тусгай ангид хорих ял оногдуулахаар заагаагүй гэмт хэрэг үйлдсэн өсвөр насны хүнийг гэмт хэрэг үйлдсэн нөхцөл байдал, учруулсан хохирол, хор уршгийн шинж чанар, хувийн байдлыг харгалзан ял оногдуулахыг тэнсэж нэг жилээс гурван жил хүртэл хугацаагаар хянан хүмүүжүүлэхээр шийдвэрлэж болно.⁹²

Хүүхдийн эрхийн тухай болон Хүүхэд хамгааллын тухай хуулиуд батлагдан гарсантай холбогдуулан өсвөр насны сэжигтэн, яллагдагчид холбогдох хэргийг шүүхээр хянан шийдвэрлэх ажиллагаанд баримтлах нийтлэг шаардлагыг тусгаж, хүүхдийн эрхийн тухай олон улсын баримт бичгийн заалтад нийцүүлэн эдгээр шаардлагыг шүүх энэ тэргүүнд хэрэгжүүлж, хангаж ажиллахыг Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд хуульчилсан болно. Үүнд:

1. Шүүх өсвөр насны шүүгдэгчид холбогдох хэргийг хянан шийдвэрлэх ажиллагаа явуулах, шийдвэр гаргахдаа түүний эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах,
2. Өсвөр насны шүүгдэгчтэй харьцахдаа түүний нэр төрийг хүндэтгэн харьцаж, насны онцлогийг харгалзан хүмүүжих, алдаагаа засах боломж олгохыг анхаарч ажиллана.
3. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг хаалттай явуулж шийдвэрийг олон нийтэд мэдээлэхдээ өсвөр насны шүүгдэгчийн эрх, хууль ёсны ашиг сонирхол, түүнд учирч болох бусад хор уршгийг тусгайлан харгалзана.
4. Өсвөр насны шүүгдэгчид холбогдох хэргийг хянан шийдвэрлэх ажиллагааг энэ хуульд заасан ердийн журмаар явагдах ажиллагаанаас шуурхай, богино хугацаанд явуулах нөхцөлийг шүүх хангаж ажиллана.⁹³

Аливаа этгээд эрүүгийн эрх зүйн харилцаанд оролцоход түүний нас, төлөвшил, эрх зүйн чадамж, хариуцлага, ухамсар, чадвар зэргээс шууд шалтгаалдаг. Ямар ч улс үндэстэн, нийгэм, иргэншлийн хувьд насанд хүрээгүй хүн гэмт хэрэг үйлдсэн бол түүнд ял оногдуулах асуудлыг насанд хүрсэн хүнтэй адилгүйгээр тусгайлан авч үздэг нь түгээмэл ажээ. Өөрөөр хэлбэл, насанд хүрээгүй хүн нь биологийн хөгжил, ухамсар, санаа, мэдлэг, оюун ухаан, бүрэн төлөвшөөгүй, нийгмийн амьдрал, харилцаанд бие даан оролцох арга, чадвар, туршлага хараахан бий болоогүй, бүрэн бүрэлдээгүй зэрэг хүндэтгэн үзэх шалтгаанууд нь тухайн субъектийн статусыг онцлон үзэх гол үндэслэл болдог.

Насанд хүрээгүй этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэхэд дор дурдсан зарчим, хандлагыг анхаарч, хуульчлан зохицуулсан байдаг.

- Цаазаар авах ба бүх насаар нь хорих ялыг хэрэглэхгүй байх,
- Хугацаатай хорих ялын дээд хэмжээг аль болох хязгаарлах,
- Ялтай байх хугацааг тооцохоос татгалзах,
- Хөөн хэлэлцэх хугацааг богиносгох, хязгаарлах,
- Болгоомжгүй, санамсаргүйгээр үйлдсэн хөнгөн гэмт хэрэгт ял онохоос татгалзах,
- Хугацаанаас өмнө ялаас чөлөөлөх нөхцөлд хугацааг богиносгох,

⁹¹ Нямбаатар.Х, Мөрөн.Д “Эрүүгийн эрх зүй /ерөнхий ба тусгай анги/.УБ.,2017., 65 дахь тал

⁹² Монгол Улсын хууль /Эрүүгийн хууль/ УБ.,2022.,

⁹³ Лхагварагчаа.Б, Эрдэнэбаатар.П, Эрүүгийн процессын эрх зүй /сурах бичиг/. УБ.,2021.,330 дахь тал

- Аль болох хорихоос өөр төрлийн хүмүүжлийн болон нийгэмшүүлэхэд чиглэгдсэн арга хэмжээ санхүүг нэмэгдүүлэх,⁹⁴

Дүгнэлт

Өсвөр насны хүүхдээс үйлдсэн гэмт хэргийг мөрдөн шалгах ажиллагаа явуулахдаа хуульд заасан ердийн журмаас гадна эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тусгай журмыг баримталж тухайн сэжигтэн, яллагдагчийн хувийн байдлыг тогтоох, амьдралын нөхцөл байдал, гэмт хэрэг үйлдсэн шалтгаан нөхцөлийг бүрэн тогтоож, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд өмгөөлөгч, түүний хууль ёсны төлөөлөгчийг байлцуулан мэдүүлэг авах, бусад мөрлөн шалгах ажиллагаа явуулж хууль ёсны эрх ашиг, сонирхлыг хамгаалж оролцох нь эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны зорилтыг хангах чухал ач холбогдолтой билээ. Мөн үүнээс өсвөр насны яллагдагчийн гэмт хэрэг үйлдэхэд сургуулийн орчин, гэр бүлийн гишүүдийн анхаарал халамж, харилцан ярилцах, тэдний бодол санааг цаг үргэлж сонсож байх, найз нөхдийн хүрээлэл, мөн сургуулийн орчинд дугуйлан, секц, олон нийтийн үйл ажиллагаанд хамруулж байх хэрэгцээ шаардлагатай байна.

Ашигласан материал:

1. Лхагварагчаа.Б, Эрүүгийн процессын эрх зүй /сурах бичиг/. УБ.,2021
2. Батсуурь.М, Хүүхэд ба хууль ёс / хуульчдад зориулсан сургалтын гарын авлага
3. Хишиг-Ундрах.,Б “Хуулийн сэтгэл судлал” УБ.,2021.,
4. Оюунчимэг.Т “Криминалистикийн арга зүй” УБ.2024
5. Лхагварагчаа.Б, Эрдэнэбаатар.П, Эрүүгийн процессын эрх зүй /сурах бичиг/. УБ.,2021.
6. Бат-Эрдэнэ.Б “Монгол Улсын эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх эрх зүй” /альбом-схем/ УБ.2018.
7. Нямбаатар.Х, Мөрөн.Д “Эрүүгийн эрх зүй /ерөнхий ба тусгай анги/.УБ.,2017.,
8. Монгол Улсын хууль /Эрүүгийн хууль/ УБ.,2022
9. Азжаргал.Т. “Хууль зүйн хариуцлага” УБ.,2024.,144 дэх тал
Цахим эх сурвалж
1. [https: Википедия eagle.mn](https://eagle.mn)
2. [Mnb.mn](https://mnb.mn) МҮОНП-ийн “Хурд агентлэг”
3. <https://information.police.gov.mn/as/staticnum>
4. <https://judcouncil.mn/>
5. <https://prosecutor.mn/main>

⁹⁴ Азжаргал.Т. “Хууль зүйн хариуцлага” УБ.,2024.,144 дэх тал

ШҮҮХИЙН ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭХ ЭРХ ЗҮЙН ОНОЛ, ПРАКТИКИЙН ТУЛГАМДСАН АСУУДАЛ

ОХУ-ЫН ХОЛБООНЫ ЯЛ ЭДЛҮҮЛЭХ АЛБА, ТҮҮНИЙ ХАРЬЯА СУРГАЛТ, ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ БАЙГУУЛЛАГУУДЫН ТОГТОЛЦОО

ON THE PENAL SERVICE OF THE RUSSIAN FEDERATION AND ITS RELATED
EDUCATIONAL AND RESEARCH INSTITUTIONS

О.Зоригт

Монгол Улсаас ОХУ-д суугаа ЭСЯ-ны зөвлөх бөгөөд
ХЗДХЯ-ны ОХУ дахь байнгын төлөөлөгч,
доктор (Ph.D), дэд профессор, цагдаагийн хурандаа

Орос Улсад хорих ял эдлүүлэх байгууллага эзэнт гүрний нутаг дэвсгэр Сибирь тийш эрчимтэй тэлж эхэлсэн 1560-аад оноос үүсэж эхэлсэн гэж судлаачид үздэг.⁹⁵ Энэ үеэс гэмт хэрэг үйлдэж, ял шийтгүүлсэн хүмүүсийг үнэгүй ажиллах хүч болгон ашиглаж, улсын эдийн засгийн хөгжил, бүтээн байгуулалтын ажилд зүтгүүлж эхэлсэн байна. 1645 он гэхэд жилд 1500 орчим хоригдлыг Сибирь рүү цөллөгт илгээж байсан ба XIX зууны эхэн үе хүртэл жилд дунджаар тогтмол хоёр мянга гаруй хүн Сибирьд цөллөгт явж, янз бүрийн хүнд хүчир ажил хөдөлмөр эрхэлдэг болсон байв.

Их Петр хааны үеэс Оросын эзэнт гүрэнд салбарын удирдлагын чиг үүргийг “коллеги” буюу “зөвлөл” нэртэй байгууллагууд гүйцэтгэж байсан бөгөөд эдгээр байгууллагууд шинэ зууны хэрэгцээ, шаардлагыг хангахаа больсон тул I Александр хаан 1802 онд төрийн удирдах байгууллагын шинэчлэл хийж, анхны яамдыг бий болгосон түүхтэй.

I Александр хааны 1802 оны 9 дүгээр сарын 20-ны өдөр баталсан “Яамд байгуулах тухай” тунхаг бичгээр зөвлөл буюу коллегиудын оронд Цэрэг-хуурай замын хүчний, Тэнгисийн хүчний, Гадаад хэргийн, Хууль зүйн, Дотоод хэргийн, Сангийн, Худалдааны, Ардын гэгээрлийн гэсэн анхны 8 яам байгуулагджээ.

Тунхаг бичгийн 4 дүгээр зүйлд зааснаар Дотоод хэргийн яам эзэнт гүрний нийт нутаг дэвсгэрт нийгмийн дэг журмыг хангах ажлыг зохион байгуулах, хот, хөдөөгийн цагдаагийн байгууллагыг удирдахаас гадна, улсын аж үйлдвэр, барилга, хөдөө аж ахуй, нийтийн аж ахуй, хүнс, эрүүл мэнд, галын аюулгүй байдлыг хангах зэрэг олон чиг үүргийг хэрэгжүүлж байсан байдаг.⁹⁶

Түүхэн цаг хугацааны явцад Дотоод хэргийн яамны гүйцэтгэх чиг үүрэг өөрчлөгдөж, аж ахуйн шинжтэй чиг үүргүүд нь хасагдаж, гэмт хэрэгтэй тэмцэх, нийгмийн хэв журмыг хангах, хоригдогч, ялтныг хянах, харгалзах, хуяглан хүргэх зэрэг чиг үүрэг нь давамгайлах болсон юм.

Анх 1802 оны 9 дүгээр сард Дотоод хэргийн яамны бүтцэд шорон болон нийтээр жигшүүлэх газруудыг удирдах чиг үүрэг бүхий 4 дүгээр экспедиц байгуулагдсан бол 1817 оны 2 дугаар сард ялтныг хуяглан хүргэх нэгж байгуулагдаж байсан түүхтэй. Улмаар 1879 онд Дотоод хэргийн яаманд “Шоронгийн удирдах газар”⁹⁷ байгуулагдан ажиллаж эхэлсэн бөгөөд энэ тогтолцоо, харьяалал Хаант орос улс, ЗХУ, ОХУ-ын үед ч хэвээр байсаар 1998

⁹⁵ <http://fsin.gov.ru/history/chronology/index.php>

⁹⁶ <https://cyberleninka.ru/article/n/k-voprosu-o-sozdanii-ministerstva-vnutrennih-del-rossiyskoy-imperii/viewer>

⁹⁷ <http://fsin.gov.ru/history/chronology/index.php>

оны 8 дугаар сарын 31-ний өдөр өөрчлөгдөж, тухайн үедээ “Ял эдлүүлэх ерөнхий газар” нэртэй ОХУ-ын Дотоодыг хамгаалах яамны харьяанд үйл ажиллагаагаа явуулж байсан энэ байгууллага ОХУ-ын Хууль зүйн яамны харьяа байгууллага болсон байна.

Бүтэц, зохион байгуулалтын ийм шинэчлэл хийгдэх болсон гол шалтгаан нь 1996 онд ОХУ “Шүүх, эрх зүйн тогтолцоогоо олон улсын хэм хэмжээ, стандартад нийцүүлэн шинэчлэх”-ийг шинээр гишүүнээр элсэх хүсэлт гаргасан улс орнуудад гол шалгуур болгон тавьдаг Европын зөвлөлд элссэн явдал юм. Үүнтэй холбоотойгоор ОХУ “Эрүүдэн шүүх, хүнлэг бусаар нэр төрийг доромжлон харьцахаас урьдчилан сэргийлэх тухай”, “Хүний эрх, үндсэн эрх чөлөөг хамгаалах тухай”, “Эрүүгийн хэргийн талаар харилцан туслалцаа үзүүлэх тухай”, “Гэмт хэрэг, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх, мөнгө угаах, илрүүлэх, хураах тухай” зэрэг Европын хэд хэдэн конвенцыг соёрхон баталсан байдаг.

Өөр нэг шалтгаан нь хүнийг гэмт хэрэгт холбогдуулан түр хугацаагаар саатуулах, баривчлах, тодорхой эрхийг нь хязгаарлах, улмаар мөрдөн шалгах ажиллагаа явуулах эрх бүхий байгууллагууд /цагдаа, тагнуул г.м/ болон саатуулах, цагдан хорих, хорих ял эдлүүлэх зэрэг хүний эрхийг хязгаарлах арга хэмжээг хариуцан хэрэгжүүлдэг байгууллагууд “нэг толгой”-той бус байх нь хууль дээдлэх, хүний эрхийг хангах гол баталгаа болно гэж үздэг олон улсын шинжээчдийн нийтлэг байр суурьтай холбоотой.

Эдгээр шалтгаануудын нөлөөн дор ОХУ-д эрүүгийн ял эдлүүлэх ажиллагааг хариуцан гүйцэтгэдэг байгууллага Дотоод хэргийн яамны бүтцээс гарч, Хууль зүйн яамны харьяанд шилжсэн бөгөөд 2004 он хүртэл хуучин нэрээрээ /Ял эдлүүлэх ерөнхий газар/ нэрээр үйл ажиллагаа явуулж байгаад 2004 онд “Холбооны ял эдлүүлэх алба” нэртэй болж, үйл ажиллагаа нь тусдаа дүрмээр зохицуулагддаг, харьцангуй бие даасан статустай, төрийн тусгай байгууллага болсон байна.

Холбооны ял эдлүүлэх алба дараах үндсэн чиг үүргийг хэрэгжүүлдэг.⁹⁸

Үүнд:

1. ОХУ-ын хууль тогтоомжийн дагуу эрүүгийн ял шийтгэлийг эдлүүлэх, сэжигтэн, яллагдагч, шүүгдэгчийг цагдан хорих шийдвэрийг хэрэгжүүлэх;
- 1.1. Гэмт хэрэгт сэжиглэгдэж, яллагдаж буй этгээдүүдэд шүүхээс авсан гэрийн хорио таслан сэргийлэх арга хэмжээ бусад хорио, хязгаарлалтын хэрэгжилтэд хяналт тавих;
2. Ял хойшлуулсан, ялыг тэнсэн харгалзсан ялтнуудад хяналт тавих;
3. Цагдан хоригдогч, ял эдлэгсдийн хууль ёсны ашиг сонирхол, эрх, эрх чөлөөг хангах;
4. Хорих, албадан хөдөлмөр эрхлүүлэх ял эдлүүлэх байгууллага, цагдан хорих байранд дэг журам, хууль ёсыг сахиулах, тэдгээрт хорих ял эдэлж буй болон цагдан хоригдож буй этгээдүүд, ял эдлүүлэх байгууллагын алба хаагчид, иргэдийн аюулгүй байдлыг хангах;
5. Ялтан, цагдан хоригдогсдыг батлагдсан маршрутын дагуу хамгаалж, хуяглан хүргэх, ОХУ-ын иргэд, харьяалалгүй этгээд, гадаад улсын иргэдийг шилжүүлэн өгөх үеийн хуяглан хүргэх ажиллагааг зохион байгуулах;
- 5.1. Эрүүл мэнд, нийгмийн хамгааллын Холбооны агентлагийн харьяа эрчимжсэн хяналттай сэтгэцийн тусгай эмнэлгүүдийг хамгаалах, эмчлүүлэгч, ажиллагсдын аюулгүй байдлыг хангах, албадан эмчилгээ хийх, өөр эмнэлэгт шилжүүлэх үед дагалдан хамгаалах;

⁹⁸ <https://fsin.gov.ru/fsin/status/>

6. Ялтан, цагдан хоригдогсдод ОХУ-ын Холбооны хуулиуд, Олон улсын гэрээний заалт, олон улсын эрх зүйн холбогдох хэм хэмжээнд нийцсэн ял эдлэх, цагдан хоригдох нөхцөлийг бүрдүүлэх;
7. Ялтныг нийгэмшүүлэхэд чиглэсэн үйл ажиллагаа зохион байгуулах;
8. Шууд удирдлагын болон нутаг дэвсгэрийн ял эдлүүлэх байгууллагуудын үйл ажиллагааг нэгтгэн удирдах зэрэг болно.

Холбооны ял эдлүүлэх алба "улсын доторх улс" хэлбэрээр үйл ажиллагаагаа явуулдаг бөгөөд өөрийн гэсэн эрүүл мэндийн үйлчилгээ, тээвэр, боловсролын систем, худалдаа, хангалтын албатай байдгаас гадна тус албаны үйлдвэрлэл, эдийн засгийн шинжтэй үйл ажиллагааны талаарх мэдээлэл олон нийтэд төдийлөн нээлттэй бус байдаг.

Оросын Холбооны Улс эрүүгийн ял эдлүүлэх үйл ажиллагаанд зарцуулдаг төсвийн зардлын хэмжээгээр Европт нэгдүгээрт ордог бөгөөд энэ зардал нь Засгийн газрын нийт зардлын 1.5 орчим хувийг эзэлдэг байна. Үүний зэрэгцээ 2003-2015 онд тус албаны төсөв бараг 7 дахин өссөн. 2017 оны байдлаар Хорих ял эдлүүлэх алба нь ОХУ-ын бүх яам, албадын дунд төсвийн хэмжээгээр 6-рт орж байсан бөгөөд 2023 онд Холбооны ял эдлүүлэх албаны төсөв 232.4 тэрбум рубль болсон байна.

Засгийн газрын төсвөөс гадна ХЯЭА нь хорих ангиудад үйл ажиллагаа явуулж буй үйлдвэрлэлийн орлогоосоо мөн санхүүждэг бөгөөд 2016 оны байдлаар үйлдвэрлэлийн орлого нь 50 тэрбум рубльд хүрч байжээ.

Сэтгүүлчдийн хийсэн судалгаагаар Хорих ял эдлүүлэх албаны зардлын дийлэнх хувийг (ойролцоогоор 67-75%) ажилтнуудын цалин, тэтгэвэр, урамшуулалд зарцуулдаг байна. Мөн ихэнх хорих байгууллагын барилга, байгууламж нь Сталины үеийн хуучин барилга, байшин байдаг тул сүүлийн жилүүдэд шинээр хорих ангиуд барих, хуучнуудыг засварлахад ихээхэн хөрөнгө зарцуулдаг талаар тус байгууллагын албан ёсны сайтад тавигдсан мэдээлэлд дурдсан байна. Түүнчлэн, хоригдлуудын хоол хүнсэнд жилд 50 орчим тэрбум рубль зарцуулдаг ажээ. Нэг хоригдолд зарцуулж буй зардлын хэмжээг Европын дундаж түвшинтэй харьцуулахад 50 дахин бага мөнгө зарцуулдаг гэсэн байна.

Хоригдлуудын хөдөлмөрийг ашиглан хорих ангийн нутаг дэвсгэрт тахиа, гахай, үхрийн аж ахуй, ногооны хүлэмж зэрэг туслах аж ахуй эрхэлснээр шаардлагатай хүнсний бүтээгдэхүүнийхээ дийлэнхийг бие даан үйлдвэрлэдэг.

Бүтэц, зохион байгуулалт: Холбооны ял эдлүүлэх алба Төв аппарат, ОХУ-ын бүрэлдэхүүн /субъект/ БНУ, муж, хязгаарын удирдах газар, газрууд, нутаг дэвсгэрийн байгууллагуудад шууд харьяалагддаг хорих байгууллагуудаас бүрддэг.

Төв аппаратыг ОХУ-ын Ерөнхийлөгчийн томилсон захирал удирдах бөгөөд 2021 оны 11 дүгээр сараас хойш энэ албан тушаалд дотоод албаны генерал Аркадий Гостев томилогдон ажиллаж байна. Тус албаны захирал нь зургаан орлогч, түүний дотор нэг нэгдүгээр орлогчтой бөгөөд орлогч нарыг мөн ОХУ-ын Ерөнхийлөгчийн зарлигаар томилж, чөлөөлдөг. Төв аппарат нь чиг үүргийн дараах Ерөнхий газрууд болон бусад хэлтэс, нэгж, албатай. Үүнд:

1. Төвлөрсөн цагдан хорих байруудыг удирдах газар;
2. Шуурхай удирдлагын ерөнхий газар;
- 2.1. Дотоод аюулгүй байдлын ерөнхий газар; (Тус газар ОХУ-ын Ерөнхийлөгчийн 2024 оны 5 дугаар сарын 10-ны өдрийн 321 дүгээр зарлигаар байгуулагдсан)
3. Дэглэм, хяналтын газар
4. Хүмүүжил, нийгэм-сэтгэл зүйн газар

5. Хамгаалалт, хуяглан хүргэлтийн газар
 6. Тусгай бүртгэл, тогтоол гүйцэтгэлийн газар
 7. Хорихоос өөр төрлийн ял эдлүүлэх газар
 8. Хүний нөөцийн газар
 - 8.1. Бие бүрэлдэхүүнтэй ажиллах газар (Тус газар мөн ОХУ-ын Ерөнхийлөгчийн 2024 оны 5 дугаар сарын 10-ны өдрийн 321 дүгээр зарлигаар байгуулагдсан)
 9. Санхүү, эдийн засгийн газар
 10. Их барилга, үл хөдлөх хөрөнгө, засвар, ашиглалтын газар
 11. Ар тал, хангалтын газар
 12. Үйлдвэрлэлийн үйл ажиллагаа, ялтны хөдөлмөр эрхлэлт зохион байгуулах газар
 13. Эрх зүйн газар
 14. Тамгын газар
 15. Эмнэлэг, эрүүл ахуйн хангалтын газар
 16. Төлөвлөлт, дүн шинжилгээний газар
 17. Инженер техникийн хангалт, холбоо, зэвсгийн газар (Тус газар ОХУ-ын Ерөнхийлөгчийн 2022 оны 4 дүгээр сарын 11-ний өдрийн 201 дүгээр зарлигаар байгуулагдсан)
 18. Цахим шилжилтийн газар (Тус газар мөн ОХУ-ын Ерөнхийлөгчийн 2022 оны 4 дүгээр сарын 11-ний өдрийн 201 дүгээр зарлигаар байгуулагдсан)
 19. Төрийн нууц хамгаалах хэлтэс
 20. Гэрээ хариуцсан алба (Тус алба ОХУ-ын Ерөнхийлөгчийн 2019 оны 9 дүгээр сарын 9-ний өдрийн 434 дүгээр зарлигаар байгуулагдсан)
 21. Дайчилгааны бэлэн байдал, иргэний хамгаалалтын хэлтэс (Тус хэлтэс ОХУ-ын Ерөнхийлөгчийн 2019 оны 9 дүгээр сарын 9-ний өдрийн 434 дүгээр зарлигаар байгуулсан)
- Түүнчлэн, төв аппаратад “Ял эдлүүлэх албаны эрдэм шинжилгээ-үйлдвэрлэлийн нэгдэл”, “Эрдэм шинжилгээний хүрээлэн”, “ХЯЭА-ны хэвлэлийн нэгдсэн редакц”, “Гэм зэм”, “Эрүүгийн ял эдлүүлэх албаны мэдээ” мэргэжлийн сэтгүүлүүд, “Улсын байр /Казённый дом/” сонины редакц зэрэг нэгжүүд мөн харьяалагддаг.⁹⁹
- Эрүүгийн ял эдлүүлэх тогтолцоонд Холбооны субъектууд дахь Ерөнхий газар, Газрууд тэргүүлэх үүрэг гүйцэтгэнэ. 2015 оны байдлаар ОХУ-д 80 ийм газар ажиллаж, орон даяар тархсан 1000 гаруй янз бүрийн төрөл, ангиллын ял эдлүүлэх байгууллагыг өдөр тутмын удирдлагаар хангаж байсан бол 2023 оны байдлаар 204 цагдан хорих байр, 642 хорих анги, үүний дотор онц аюултай, давтан гэмт хэрэг үйлдсэн этгээдүүдэд зориулсан онцгой дэглэмтэй хорих анги 35, бүх насаар нь хорих ял шийтгүүлсэн этгээдүүдэд зориулсан онцгой дэглэмтэй хорих анги 7, чанга дэглэмтэй хорих анги 251, гяндан 8, насанд хүрээгүйчүүдийн хорих анги 17, жирийн дэглэмтэй эрэгтэйчүүдийн хорих анги 164, эмэгтэйчүүдийн хорих анги 35, 106 суурин хэлбэрийн хорих анги /колония поселение/ зэрэг нийт 872 хорих газар ажиллаж, тэдгээрт шашны зан үйл үйлдэх мөргөлийн 1508 газар үйл ажиллагаа явуулж байна¹⁰⁰.
- Тус улсын хорих анги, цагдан хорих байрууд нийт 714 253 хүний багтаамжтай бөгөөд дүүргэлтийн хувь нь сүүлийн 3 жилийн дунджаар 67 орчим хувьтай явж иржээ. ОХУ-д Холбооны ял эдлүүлэх албаны харьяа хорих, цагдан

⁹⁹ <https://forum.amazing-online.com/threads/fsin-organizacionnaja-struktura-fsin.930973/>

¹⁰⁰ Russian Federation. World Prison Brief.

хорих газруудад 2023 оны эцсийн байдлаар нийт 433 003 хүн хоригдож байсан байна.

Хорих ял эдлүүлэх албаны харьяа сургалт, эрдэм шинжилгээний байгууллагууд

ОХУ-ын Холбооны ял эдлүүлэх албаны харьяа сургалт, эрдэм шинжилгээний байгууллагууд нь тус албаны хүний нөөцийг бэлтгэх, мэргэжил дээшлүүлэх, давтан сургах, эрдэм шинжилгээ, судалгааны ажил эрхлэх чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг. Эдгээр сургалт, эрдэм шинжилгээний байгууллагууд нь хууль зүй, нийгэм судлал, эдийн засаг зэрэг олон чиглэлээр сургалт явуулж, тус албаны хэрэгцээ, шаардлагад нийцсэн өндөр ур чадвартай мэргэжилтнүүдийг бэлтгэх гол бааз суурь болдог.

ОХУ-ын Холбооны ял эдлүүлэх албаны харьяанд 8 их, дээд сургууль, мэргэжил дээшлүүлэх 2 институт, 1 бүсийн сургалтын төв, нутаг дэвсгэрийн байгууллагуудын харьяаны сургалтын 10 төв, эрдэм шинжилгээний хүрээлэн, мэдээллийн технологийн судалгааны хүрээлэн ажилладаг.

Холбооны Ял эдлүүлэх Албаны эрх зүй, удирдлагын академи (Академия права и управления ФСИН России) – Анх 1934 онд цагдан сэргийлэхийн хэсгийн байцаагчийн курс нэртэй байгуулагдаж байсан тус сургууль 1947 оноос “Рязаны цагдан сэргийлэхийн дарга нарыг бэлтгэх сургууль”, 1954 оноос “Цагдан сэргийлэхийн дарга нарыг давтан сургах сургууль” нэртэй үйл ажиллагаа явуулж байгаад 1971 онд “ЗХУ-ын Дотоодыг хамгаалах яамны Рязаны дээд сургууль” болсон байна.

1995 оноос ОХУ-ын Дотоодыг хамгаалах яамны “Рязаны эрх зүй, эдийн засгийн дээд сургууль”, 1999 оноос ОХУ-ын Хууль зүйн яамны “Рязаны эрх зүй, эдийн засгийн дээд сургууль”, 2001 оноос ОХУ-ын ХЗЯ-ны “Эрх зүй, удирдлагын академи”, 2005 оноос Хорих ял эдлүүлэх албаны “Эрх зүй, удирдлагын академи” болон хэд хэдэн удаа өөрчлөн зохион байгуулагдаж ирсэн 80 жилийн түүхтэй энэ сургууль ял эдлүүлэх байгууллагын хүний нөөцийг бэлтгэх, мэргэжил дээшлүүлэх, эрдэм шинжилгээний ажил эрхлэх чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг.

Дээд сургуулийн статустай болсноос хойшхи 40 гаруй жилийн хугацаанд 20,000 гаруй мэргэжилтэн, түүний дотор 500 гаруй гадаад улсын алба хаагчдыг бэлтгэж ирсэн түүхтэй. Хуулийн, эдийн засгийн, сэтгэл судлал-пробацын, эрдэм шинжилгээний ажилтан болон багшлах бүрэлдэхүүн бэлтгэх /докторын сургалт/, мэргэжлийн болон нэмэлт боловсрол олгох сургалтын гэсэн 5 факультет, мэргэжлийн 24 тэнхимтэй¹⁰¹. Мөн тус академийн салбар Псков хотод 2013 оноос үйл ажиллагаа явуулж байна.

Хорих ял эдлүүлэх албаны Эрх зүй, удирдлагын академи гүйцэтгэх ажил, хүмүүжил-эрх зүйн ажил, ял эдлүүлэх ажиллагааны сэтгэл зүй, ял эдлүүлэх байгууллагын ар тал хангалт, хорих байгууллагын эдийн засаг, үйлдвэрлэлийн ажиллагаа, санхүү, аж ахуйн ажиллагааны аюулгүй байдал, дэглэм, харуул хамгаалалт зохион байгуулалт зэрэг мэргэжлийн сургалтыг өдөр /5 жил/, эчнээ /6 жил/ халбэрээр явуулдаг бол Псков хот дахь салбар нь хорихоос өөр төрлийн ял эдлүүлэх ажиллагааны зохион байгуулалт мэргэжлээр алба хаагчдыг бэлтгэн гаргадаг байна.

Хорих ял эдлүүлэх албаны “Эрх зүй, удирдлагын академи” бакалавр, мэргэжилтэн / 5 жилээр төгсгөдөг/, магистр, докторын түвшний сургалт эрхлэхийн зэрэгцээ Хорих ял эдлүүлэх албаны үйл ажиллагааны олон чиглэлээр судалгаа шинжилгээний ажил явуулдаг тус системийн хамгийн том эрдэм, шинжилгээний

¹⁰¹ <https://apu.fsin.gov.ru/>

байгууллага юм. ХЯЭА-ны хэмжээний захиалгат судалгааны ажлын 95 хувийг академи дангаараа гүйцэтгэдэг байна.

Хорих ял эдлүүлэх албаны Их сургууль (Университет ФСИН России)

- Хорих ял эдлүүлэх албаны их сургууль нь Санкт-Петербург хотод байрладаг бөгөөд анх Ленинград мужийн Засан хүмүүжүүлэх, нийгэмшүүлэх ажлын бүсийн сургалтын төвийн суурин дээр 2001 онд байгуулагдсан. Энэ сургууль нь 2020 онд Санкт-Петербургийн их сургууль болон өргөжсөн. Их сургууль мэргэжлийн болон мэргэшүүлэх сургалтын, хуулийн гэсэн 2 факультет, мэргэжлийн 9 тэнхимтэй¹⁰².

Владимирын хуулийн дээд сургууль (Владимирский Юридический Институт ФСИН России) - 1943 онд анх ЗХУ-ын Дотоод хэргийн ардын комиссарын газрын хорих байгууллагын дарга нарын сургууль нэртэйгээр байгуулагдсан Владимирын хуулийн дээд сургууль нь 1999 онд ОХУ-ын Хууль зүйн яамны харьяанд шилжиж, хуулийн дээд сургууль болсон. Энэ сургууль нь олон жилийн түүхтэй, тус улсын хорих ял эдлүүлэх албаны тогтолцоонд чухал байр суурь эзэлдэг сургалт, эрдэм шинжилгээний байгууллага юм. Хуулийн, мэргэжил дээшлүүлэх, давтан сургалтын, эрх зүй, удирдлагын гэсэн 5 факультет, 15 тэнхимтэй. Дотоодыг хамгаалах яам, Онцгой байдлын яам, Холбооны ял эдлүүлэх алба гэсэн тусгайлсан чиг үүрэгтэй 3 төрийн байгууллагын хүний нөөцийг бэлтгэдэг онцлогтой¹⁰³.

Вологда хотын эрх зүй, эдийн засгийн дээд сургууль (Вологодский институт права и экономики ФСИН России) - 1999 онд Рязанийн эрх зүй, эдийн засгийн дээд сургуулийг өөрчлөн зохион байгуулах ажлын хүрээнд байгуулагдсан энэ сургууль нь хууль эрх зүй, сэтгэл зүй, хүний нөөцийн менежмент, хөнгөн үйлдвэрлэл зэрэг төрөл бүрийн мэргэжлээр боловсрол олгодог. Хуулийн, сэтгэл судлалын, инженер эдийн засгийн, төсвийн бус боловсрол олгох, эчнээ болон мэргэжил дээшлүүлэх гэсэн таван үндсэн факультеттай, 15 тэнхим, 2000 гаруй багш, алба хаагч, суралцагсадтай¹⁰⁴.

Воронежийн дээд сургууль (Воронежский институт ФСИН России) - 2001 онд Воронеж хотод байсан нэгэн цэргийн ангийн үндсэн дээр Хууль зүйн яамны колледж нэртэй байгуулагдсан Воронежкийн дээд сургууль нь эрх зүй, нийгмийн болон тусгай техникийн чиглэлээр сургалт явуулдаг. Энэ сургууль нь 2006 онд коллежийн статусаас институт болон өргөжиж, Липецк хотод салбартай болсон. Хуулийн, инженер-техникийн, эрдэм шинжилгээний ажилтан болон багшлах бүрэлдэхүүн бэлтгэх /докторын сургалт/, мэргэжлийн болон нэмэлт боловсрол олгох сургалтын факультет гэсэн 5 факультеттай¹⁰⁵.

Тус сургууль нь удирдлага, мэдээллийн системийн автоматжуулалт, мэдээллийн нэгдсэн системийн хөгжүүлэлт, видео хяналтын системийн хөгжил, хорих байгууллагын инженер-техникийн хэрэгсэл, системийн сайжруулалт, холбооны систем зэрэг эрүүгийн ял эдлүүлэх байгууллагын үйл ажиллагааны техник, аюулгүй байдлын чиглэлээр сургалт явуулдаг системийн хэмжээний ганц сургууль юм.

Кузбасын дээд сургууль (Кузбасский институт ФСИН России) –

Кемеров мужийн Новокузнецк хотод орших тус сургууль 2006 онд Владимирын хуулийн дээд сургуулийн Кузбас дахь салбар сургуулийн суурин дээр анх байгуулагдсан. Кузбассын дээд сургууль нь эрх зүй, хууль сахиулах ажил, мэргэжлийн болон давтан сургалтын гэсэн 3 факультет, мэргэжлийн 10 тэнхимтэй.

¹⁰² <http://spbu.fsin.gov.ru>

¹⁰³ <https://vui.fsin.gov.ru/>

¹⁰⁴ <https://viipe.fsin.gov.ru/>

¹⁰⁵ <http://vi.fsin.gov.ru>

Тус дээд сургууль хорих байгууллагын даргаас эхлээд төрийн байгууллагад ажил, үйлчилгээ худалдан авах мэргэжилтэн, авилгаас урьдчилан сэргийлэх чиг үүрэг бүхий нэгжийн ажилтан, анхан шатны мэргэжилтэн зэрэг төрөл бүрийн мэргэжлээр өдөр, эчнээ сургалт эрхэлдэг¹⁰⁶.

Пермийн дээд сургууль (Пермский институт ФСИН России) - ОХУ-ын Засгийн газрын шийдвэрээр "Холбооны ял эдлүүлэх албаны Пермийн коллеж"-ийн суурин дээр 2008 онд байгуулагдсан Пермийн дээд сургууль 3 факультет, 12 тэнхимтэй, 5 мэргэжлээр өдөр, эчнээ сургалтын хэлбэрээр алба хаагчдыг бэлтгэн гаргадаг.

Тус сургууль нь хамгаалалт, хуяглан хүргэлтийн мэргэшсэн алба хаагчдыг бэлтгэдэг бөгөөд ОХУ-ын Хорих ял эдлүүлэх албаны хэмжээнд албаны нохойн чиглэлээр сургалт эрхэлдэг цорын ганц сургууль юм¹⁰⁷.

Самарагийн хуулийн дээд сургууль (Самарский юридический институт ФСИН России) – Анх 1943 онд ЗХУ-ын Дотоод хэргийн ардын комисарын Засан хүмүүжүүлэх хөдөлмөрийн байгууллагын тусгай сургууль нэртэй байгуулагдаж, засан хүмүүжүүлэх хөдөлмөрийн байгууллагын удирдах ажилтнуудыг 6 сарын хугацаатай сургалтаар бэлтгэж байсан тус сургууль 1946 онд татан буугдаж, 1963 онд Елабугын цагдаагийн тусгай дунд сургуулийн сургалт, дадлагын төв нэртэй дахин байгуулагдаж, 1963-1989 оны хооронд 1500 гаруй дунд боловсролтой офицер бэлтгэн гаргажээ. Тус сургалт, дадлагын төвийн бааз дээр 1994 онд Самара мужийн цагдаагийн байгууллагын гүйцэтгэх ажилтнуудыг сургаж бэлтгэх зорилгоор Елабугын цагдаагийн тусгай дунд сургуулийн салбарыг байгуулжээ. Энэ салбар 1999 онд ОХУ-ын Хууль зүйн яамны Самарагийн дээд сургууль, 2005 онд Холбооны ял эдлүүлэх албаны Самарагийн дээд сургууль болж, тус тус өөрчлөн зохион байгуулагдаж байжээ.

Өнөөдөр тус дээд сургууль хуулийн, мэргэжил дээшлүүлэх, давтан сургах, төрийн болон захиргааны албан хаагчдын сургалтын гэсэн гурван факультет, 11 мэргэжлийн тэнхимтэй үйл ажиллагаа явуулж байна¹⁰⁸.

Холбооны ял эдлүүлэх албаны сургалт, эрдэм шинжилгээний эдгээр байгууллагууд нь ОХУ-ын эрүүгийн ял эдлүүлэх системийн хүний нөөцийг бүх түвшинд бэлтгэж, ял эдлүүлэх ажиллагааны онол, практикийн олон чиглэл, сэдвээр эрдэм, шинжилгээ судалгааны ажлыг тогтмол гүйцэтгэдэг бөгөөд энэ утгаараа тус албаны үндсэн зорилго, зорилт, чиг үүргийг амжилттай хэрэгжүүлэхэд чухал байр суурь, үүрэгтэй байдаг.

¹⁰⁶ <https://ki.fsin.gov.ru/>

¹⁰⁷ <https://vuz.edunetwork.ru/59/37/v2930/>

¹⁰⁸ <https://sui.fsin.gov.ru/>

МОНГОЛ УЛСАД ХОРИХООС ӨӨР ТӨРЛИЙН ЯЛ ЭДЛҮҮЛЖ ИРСЭН ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТЫН ТҮҮХЭН УЛАМЖЛАЛ

THE HISTORICAL TRADITION OF LEGAL REGULATION IN MONGOLIA OTHER THAN IMPRISONMENT

*Т.Манлайбаатар
ДХИС-ийн магистрант,
цагдаагийн дэслэгч*

Товч агуулга: Хорихоос өөр төрлийн ял нь үйлдсэн гэмт хэргийн шинж байдлаас шалтгаалан ялыг ялгамжтай оногдуулах, гэмт хэрэг үйлдсэн этгээдийг гэр бүл, нийгэмд нь байлган, гэмт хэргийн нийгмийн хор аюулыг ухамсарлуулахад чиглэсэн ялын бодлогыг баримтлах хандлагатай болж байгаа энэ цаг үед хорихоос өөр төрлийн ялын хэрэгжилтийг “ял шийтгэл гарцаагүй байх” зарчмын хүрээнд бүрэн биелүүлэх шаардлага тулгарч байна.

Шүүхээс хорихоос өөр төрлийн ялыг оногдуулах, оногдуулсан ялыг хуулийн хүрээнд нэг мөр эдлүүлэх, хэрэгжилтийн тогтвортой тогтолцоог бий болгох, шуурхай гүйцэтгэх, улмаар уг ялын үр нөлөөг дээшлүүлэх чиглэлээр анхаарал хандуулах зайлшгүй шаардлага бий болсныг харгалзан практикт тулгамдаж буй асуудлыг шийдвэрлэх арга замыг эрэлхийлэн түүхэн уламжлал талаас нь судалгааны ажил хийхийг зорьсон болно.

Abstract: In this era, where non-custodial punishments tend to be applied differently depending on the nature of the crime committed, keeping the perpetrators in their families and communities, and making people aware of the social dangers of crime, we are considering the implementation of non-custodial punishments as "punishment". There is a need to fully fulfill the principle of "certainty of punishment".

In view of the urgent need to pay attention to the issue of punishments other than imprisonment by the court, to serve the sentences imposed within the framework of the law, to create a stable system of implementation, to quickly execute them, and to improve the effectiveness of the punishments, looking for ways to solve the problems in practice, from the perspective of historical tradition aims to do research work.

Түлхүүр үгс: Хорихоос өөр төрлийн ял, ялтан, хууль, эрх зүйн зохицуулалт

Keywords: Non-imprisonment punishments, convicts, laws and legal regulations

Төрөлжсөн эрүүгийн хууль тогтоомжид хорихоос өөр төрлийн ял, шийтгэлийг шүүхээс оногдуулж ирсэн байдал, хорихоос өөр төрлийн ял эдлүүлэх ажиллагааны эрх зүйн зохицуулалтын уламжлалд шинжилгээг хийж үзлээ.

Монгол ардын хувьсгалт намын анхны программ хэмээх удирдамжийн баримт бичигт хувьсгалын эхний жилүүдэд хуучин ёс журмыг /хууль ёс/ халж, шинэ журам тогтоох байдлаар “Эрх биш боловсрол нь дундад зууны үеэс дэмий хол өнгөрөөгүй бүхнийг харгалзуулж эдүгээгийн байдлыг зүйгээр шинэчлэн халах явдлыг үйлдвэл зохино”¹⁰⁹ гэжээ.

Энэ үеийн эрүүгийн эрхийн үйлчилгээний онцлогийг хувьсгалыг үндэслэгч удирдагчдын нэг Д.Сүхбаатарын шууд санаачилгаар 1922 оны 3 дугаар сарын 3-ны өдөр гаргасан Захирах захирагдах журмын тогтоолд “...ардын эрхт хэмжээт цаазат засгийн ёсон болбоос захирах захирагдахын ёсон ба эрүү шүүлт яллах

¹⁰⁹ БНМАУ-ын түүх. УБ., 1984, 363 дахь тал: МАХН-ын түүхэнд холбогдох баримт бичгүүд. УБ., 1966, I Дэвтэр 17 дахь тал.

залхаахыг бүрнээ устгасан ус гагцхүү дээдэс нь доордыг учиргүйгээр эзэрхэж дарлах ба доордос нь мөн түүний эрх сүрт дарагдаж өгүүлэх газаргүй болон зүдэж дарлагдах муу суртлыг халж, ард түмэнд эрх чөлөө олгосон нь болой”¹¹⁰ гэж тодорхойлжээ.

Ардчилсан төрийн эрүүгийн эрх зүйн эх сурвалж болох түүхэн баримт бичгүүд нь:

а/Ардын засгийн газрын хурлаас гаргасан хуульчилсан акт /хурлын тогтоол, бичиг/

б/Улс төрд онц ноцтой хэргийг таслуулахаар засгийн газраас байгуулсан комиссын тогтоол зэрэг хэлбэрээр гарч байв.¹¹¹

Ардын Засгийн газар 1921 оны 7 дугаар сарын 16-ны өдрийн 4 дүгээр хурлын 8 дугаар тогтоолын 10, 11 дүгээр зүйлд тус улсад оршин сууж буй гадаадын харьяат ба ОХУ-ын харьяат хүнийг Монголын хуулиар шийтгэх, хэрэгт холбогдогчийн гэм бурууг тогтоохдоо эд мөрийн баримт, гэрчийн мэдүүлгийг баримтлах, бие махбодыг зовоох, эрүү шүүлт хэрэглэхийг хоригложээ¹¹².

1921 оны 7 дугаар сарын 30-ны өдрийн “Эрүү шүүлтийн тухай” Засгийн газрын 8 дугаар хурлын тогтоолын 10 дугаар зүйлд “Аливаа гадаад, дотоодын хүмүүсийн эрүү шүүлтийн тухай хэлэлцээд аливаа гадаадын хүнтэй холбогдсон монгол хүнийг мөн гадаадын хүний адил эрүү шүүлт хүлээлгэхгүй, эд мөр /нотлох баримт/ хөндлөнгийн гэрчийг баримтлан шийтгэсүгэй. Дан ганц монгол хүн гэрээ, гэрчгүйд хэргийг хүлээхгүй бол юуны урьд эрүү шүүлт хэрэглэхгүйгээр үнэнийг олохыг хичээх ба хэрэв үнэн өчиг илрэхгүйд хүрвэл шүүлтийг зохисыг нь үзэж хэвээр хэмнэн хэрэглэхээр тогтов”. Мөн тогтоолын 11 дүгээр зүйлээр хуучин хуульд байсан алах, цөлөх, дөнгө дөнгөлөх, пүнлүү хасах, золио авах ялуудыг хувьсгаж хорих, торгох ял болгон өөрчилсөн.

1921 оны 8 дугаар сарын 3-ны өдрийн Ардын Засгийн газрын хурлын 9 дүгээр тогтоолын 5 дугаар зүйлд “Эх орноосоо урвах гэмт хэргээс бусад гэмт хэрэгт алах, цөлөх, дөнгөлөх ялыг өөрчилж алах ялыг 10 жил хорих, алгуурлан алах ялыг 7 жил хорих, улсын хязгаарт цөлөх ялыг 3 жил хорих, зэргэлдээ аймагт цөлөх ялыг 1 жил хорих ял болгон өөрчилж хоригдлын ял эдлэх хугацаанд нь хөдөлмөр хийлгэх болгожээ. Мөн пүнлүү хасах, золио авах ялыг торгуулийн ял болгож, ял оногдуулахдаа тайж, ард гэж ялгаварлан үзэхийг зогсоосон юм”¹¹³.

Монгол ардын намын Төв Хорооны Тэргүүлэгчдийн VII хурлын тогтоолоор “Үндсэн хуулийн төслийг хянан зөвшөөрч, улмаар түүнийг зарим үл зохилдох утга, үг үсгийг шинэчлэн залруулан засамжлахаар гишүүдэд хүргүүлж гүйцэтгүүлэхээр тогтсон байна.”¹¹⁴ Улсын анхдугаар их хурал 1924 оны 11 дүгээр сарын 08-ны өдөр нээгдэж, улс орны тулгамдсан олон асуудал шийдвэрлэсний дотор тус улсын анхны Үндсэн хуулийг 1924 оны 11 дүгээр сарын 26-ны өдөр санал нэгтгэйгээр баталж, хувьсгалын ялалтыг хуульчлан бэхжүүлж, ард түмний ардчилсан эрхийг тунхаглан зарлаж өгсөн нь хувьсгалт эрүүгийн эрхийн үндсэн бааз гол эх сурвалж болсон юм.¹¹⁵

Шүүх цаазын бичгийн Нэгдүгээр бүлэгт уг хуулийг журамлан дагаж явуулах хэмжээ, хязгаарыг заасан. Тухайлбал, энэ бүлгийн 1 дүгээр зүйлд “Энэхүү шүүх

¹¹⁰ МАХН-ын түүхэнд холбогдох баримт бичгүүд. I боть. УБ., 196, 124 дэх тал

¹¹¹ Б.Содовсүрэн. БНМАУ-ын Эрүүгийн хууль тогтоомжийн хөгжилт. УБ., 1971, 29 дэх тал.

¹¹² “Ардын засгаас 1921-1924 онуудад авсан хувьсгалт арга хэмжээнүүд” 1954., 127-128 дахь тал.

¹¹³ Б.Баярсайхан, С.Жанцан “Монгол Улсын эрүүгийн хууль тогтоомжийн түүхэн уламжлал (1911-2009) 78 дахь тал.

¹¹⁴ Б.Баярсайхан, С.Жанцан “Монгол Улсын эрүүгийн хууль тогтоомжийн түүхэн уламжлал (1911-2009) 80 дахь тал.

¹¹⁵ Г.Совд. “БНМАУ-ын эрүүгийн эрхийн курс” (ерөнхий анги). УБ., 1973 он 58 дахь тал

цаазын бичгийг зарласан өдрөөс хойш гарсан аливаа гэмт явдал, үйлдсэн хэрэг дор журамлан дагаж шийтгэвээс зохино” гээд зөвхөн ялгүй болгож заасан буюу ялыг хөнгөрүүлсэн бол буцаан хэрэглэх хүчинтэй бах зарчмыг тогтоон хууль үйлчлэх нутаг дэвсгэр, хамаарах этгээдийг тодорхойлж өгсөн. Энд гагцхүү гадаад улсын элчин, консулд үл хамаарахыг шууд заасан.¹¹⁶

1926 оны Шүүх цаазын бичигт ялын тогтолцоо, төрлийг тодорхойлж, ял оногдуулах үндэслэл, журмыг нарийвчлан хуульчилсан. Ялын төрөлд:

1. Онц аюултай гэмт хэрэгтнүүдэд шүүх цаазын бичгийн тусгай ангид хэрэглэхээр заасан алах ял:
2. 1 өдрөөс 10 жил хүртэл хугацаатай, албадан хөдөлмөрлүүлэх явдалтай хослуулан хэрэглэх хорих ял:
3. 100 өдрөөс хэтрэхгүй хугацаатай засан хүмүүжүүлэх ажил хийлгэх ял:
4. Хөрөнгө хураах ял
5. 10 төгрөгөөс дээш хэмжээтэй торгох ял
6. Албан тушаалаас огцруулах ял
7. БНМАУ-ын нутгаас хөөн зайлуулах ял
8. Шүүхээс донгодох ял:
9. Аливаа эрхийг бүрэн буюу эсхүл заримыг хугацаагаар буюу үүрд эвдэх зэрэг үндсэн ба нэмэгдэл ялууд хамаарч байв.

Энэ хуулиар хэргийн учир байдлыг харгалзан оногдуулсан хорих ялыг биечлэн эдлүүлэхийг түдгэлзүүлэн тэнсэн 5 жил хүртэл хугацаагаар хянан харгалзахаар зааж, хэрэв тэнсэгдсэн ялтан энэ хугацаанд дахин тэр хэргийг үйлдвэл хуучин тэнсэгдсэн ялыг сэргээж шинээр оногдуулсан ял дээр нь нэмж нэгтгэх боловч 10 жилийн хугацаанаас хэтрүүлж үл болохоор заажээ.

Энэ хуулийн 13 дугаар зүйлд “аливаа ял халдагсдыг Шүүх таслах газар байцаах дор гэмт явдлыг үйлдсэн нь хуучин шийтгэсэн, ухаан балар өвчин буюу эсвээс ухаан төөрөлдөх шинэ өвчин олсон нь магад болох авч түүнийг яллаж үл болох боловч сул тавилбаас бусад дор аюултай хэрэг гаргаж болзошгүй тул тусгай эмнэлгийн газар агуулж сувилбал зохино” гэж эмнэлгийн шинжтэй албадлагын арга хэмжээ хэрэглэх үндэслэлийг хуульчлан тогтоожээ.

Шинэ Шүүх цаазын бичгийн ерөнхий ангийг 1934 оны 5 дугаар сарын 4-ний өдөр Сайд нарын Зөвлөлийн хурлаар хэлэлцэж, мөн сарын 24-ний өдөр Улсын Бага Хурлын Тэргүүлэгчдийн газраас 6 бүлэг, 41 зүйлтэйгээр, тусгай ангийг 8 бүлэг, 113 зүйлтэйгээр нь 1934 оны 8 дугаар сарын 24-ний өдөр Сайд нарын Зөвлөлийн хурлаар хэлэлцэж, мөн оны 10 дугаар сарын 8-ны өдөр Улсын Бага Хурлын Тэргүүлэгчдийн газраас тус тус баталжээ.

Уг Шүүх цаазын бичигт 1/ буудан алах: 2/ хорих: 3/ албадан ажил хийлгэх: 4/ улс төрийн болон хувийн зарим эрхийг 1-5 жилийн хугацаагаар хасах: 5/ нутаг зайлуулах буюу нутаг зааж суулгах: 6/ албан тушаалаас огцруулах буюу ажлаас хөөх: 7/ донгодох буюу олон нийтийн өмнө буруутгах: 8/ хөрөнгийг бүрэн буюу зорилгыг хураах: 9/ мөнгө торгох: 10/ учруулсан гэм хорыг арилгах үүрэг даалгах: 11/ гадаадын иргэдэд бол улсын хязгаараас хугацаагаар буюу бүр мөсөн хөөх гэж ялын тодорхой төрлүүдийг хуульчилсан төдийгүй эмнэлгийн чанартай албадах болон сурган хүмүүжүүлэх албадах арга хэмжээнүүдийг нарийвчлан тогтоожээ.

1942 оны Эрүүгийн хууль:

1940 оны 6 дугаар сард хуралдсан VIII Их хурал БНМАУ-ын шинэ Үндсэн хуулийг шинэчлэн баталж, улмаар 1942 оны 1 дүгээр сарын 17-ны өдөр Улсын XXV

¹¹⁶ Б.Баярсайхан, С.Жанцан “Монгол Улсын эрүүгийн хууль тогтоомжийн түүхэн уламжлал (1911-2009) 81 дэх тал.

Бага Хурлаас Эрүүгийн хуулийн ерөнхий ангийг 6 бүлэг, 54 зүйл, тусгай ангийг 10 бүлэг, 165 зүйлтэйгээр баталжээ.

Эрүүгийн хуулийн ерөнхий анги нь 6 бүлэгтэй бөгөөд 1 дүгээр бүлэгт Эрүүгийн хуулийн зорилт, 2 дугаар бүлэгт Эрүүгийн хуулийг хэрэглэх хэмжээ хязгаар, 3 дугаар бүлэгт Эрүүгийн хуулийн улс төрийн бодлогын ерөнхий үүсэл, 4 дүгээр бүлэгт гэмт хэрэг үйлдэгчдэд оногдуулах ялын тухай, 5 дугаар бүлэгт ял оногдуулах журам, 6 дугаар бүлэгт тэнсэн шийтгэх ба хугацаа дуусахын өмнө суллаж тэнсэх тухай хэм хэмжээнүүдийг хуульчилжээ.

Гэмт хэрэг үйлсэн этгээдэд оногдуулах ялын тухайд уг эрүүгийн хуулийн 4 дүгээр бүлэгт: 1/ Донгодох 2/ учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх үүргийг даалгах, 3/ гадаадын харьяат нарыг хөөж гаргах 4/ эцэг, эх байх тэтгэвэр авах эрхийг хасах, 5/ буудан алах зэрэг ялуудыг гэмт хэрэг үйлдэгчид оногдуулахаар хуульчлан өгсөн байна.

1942 оны Эрүүгийн хуулийн зарим зүйл, заалтууд болон ялын бодлогод Улсын Бага Хурлын Тэргүүлэгчдийн тогтоолоор хэд хэдэн удаа нэмэлт, өөрчлөлт оруулж засан сайжруулж байсан бөгөөд тус нэмэлт, өөрчлөлтүүд нь тухайн үеийн төрийн бодлогыг хэрэгжүүлэх, ялангуяа улс хоршоолол, иргэдийн өмчийг хамгаалах, хууль ёсыг бэхжүүлэх, иргэдийн эрх зүйн ухамсрыг дээшлүүлэхэд чухал үүрэг гүйцэтгэсэн нь тодорхой.

Бүгд Найрамдах Монгол Ард Улсын Их Хурлын 4 дэх удаагийн сонгуулийн анхдугаар чуулган 1960 оны 7 дугаар сарын 6-ны өдөр манай улсын түүхэн дэх 3 дахь Үндсэн хуулийг батлан гаргав. Энэ суурь хуульдаа Эрүүгийн хуулийг нийцүүлэн боловсруулж, 1961 оны 1 дүгээр сарын 31-ний өдөр АИХ-ын II чуулганаар баталж, мөн оны 4 дүгээр сарын 1-ний өдрөөс дагаж мөрдсөн түүхтэй. Энэ хуулийн ерөнхий анги нь 5 бүлэг, 44 зүйлтэй, тусгай анги нь 11 бүлэг, 221 зүйлтэйгээр батлагджээ.

Тус хуульд тусгагдсан ял шийтгэлийн тухайд:

Ял шийтгэлийн тухай 3 дугаар бүлэгт шинээр цэргийн ба тусгай алдар цолыг хасах ялыг хуульчилж, 1942 оны хуульд байсан 1/ Донгодох 2/ учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх үүргийг даалгах, 3/ гадаадын харьяат нарыг хөөж гаргах 4/ эцэг, эх байх тэтгэвэр авах эрхийг хасах зэрэг ялуудыг хассан бөгөөд буудан алах ялыг өөрчилж, 18 дугаар зүйлд нэрлэж заасан долоон төрлийн хүнд, онц хүнд гэмт хэргүүдэд хэрэглэх болсноор энэ ялыг оногдуулах хэргийн хүрээ хумигдаж, эмэгтэйчүүд, 60-аас дээш насны эрэгтэйчүүд, насанд хүрээгүй хүмүүст энэ ялыг хэрэглэхгүй гэж байхаар хуульчлав. 1961 оноос батлагдан мөрдөгдөж 1986 онд шинэчлэн найруулсан Эрүүгийн хууль нь бүтэц, хэлбэрийн хувьд өмнөх хуулиас харьцангуй сайжирсан хууль боловч социалист өмчийн харьцааг хамгаалан дэмжих, төлөвлөгөөт эдийн засаг, захиран тушаах дэглэмийн тогтвортой байдлыг энэ хуулийн албадлагаар баталгаажуулахад чиглэгдсэн заалтууд хуульд хадгалагдаж үлдсэн.¹¹⁷

1961-1980 он дахь хорихоос өөр төрлийн ялын эрх зүйн зохицуулалт:

1961 оны Эрүүгийн хуульд ял шийтгэлийн зорилгыг тодорхойлохдоо ял шийтгэх явдал бол шийтгэгчдийг хөдөлмөрт үнэнч шударга ханддаг, хуулийг нарийн чанд сахидаг, хамтын аж байдлын социалист хэв журмыг хүндэтгэн үздэг болгож засаж хүмүүжүүлэх, тэрчлэн шийтгэгчдийг дахин гэмт хэрэг үйлдэхээс ба бусад хүмүүсийг гэмт хэрэг үйлдэхээс урьдчилан сэргийлэх зорилготой

¹¹⁷ Б.Баярсайхан, С.Жанцан "Монгол Улсын эрүүгийн хууль тогтоомжийн түүхэн уламжлал (1911-2009) 105-109 дэх тал

гэжээ.Түүнчлэн, ял шийтгэх явдал нь хүний бие махбодыг зовоох, хүн гэсэн нэрийг нь гутаан доромжлох зорилгогүй гэж заасан байна.

Тухайн үеийн эрүүгийн хууль тогтоомжид дараах үндсэн ялын төрөл байсан байна. Үүнд:

- 1.хорих
- 2.нутаг зааж суулгах
- 3.уг нутгаас зайлуулах
- 4.засан хүмүүжүүлэх ажил хийлгэх
- 5.ямар нэгэн тодорхой албан тушаал гүйцэтгэх буюу ажил хэрэг эрхлэхийг

хориглох

- 6.торгох
- 7.олон нийтийн өмнө буруушаах.

Дээрх ялын төрлүүдээс хорихоос өөр төрлийн ялыг хэрхэн эдлүүлж байсан талаар авч үзвэл:

-Нутаг зааж суулгах:

Шийтгэгдсэн этгээдийг оршин суугаа нутгаас нь хугацаатайгаар зайлуулан тодорхой нутаг зааж суулгахыг хэлэх ба үндсэн ба нэмэгдэл ялын шинжтэйгээр 2-5 жилийн хугацаагаар тогтоодог байсан байна. Нутаг заан суулгагдсан этгээдийг хөдөлмөрт хамруулах ажлыг тухайн орон нутгийн ардын депутатын хорооны гүйцэтгэх захиргаа хариуцдаг байжээ.

-Уг нутгаас зайлуулах:

Шийтгэгдсэн этгээдийг оршин суугаа нутгаас нь хугацаатай албадан зайлуулахыг хэлэх ба үндсэн ба нэмэгдэл ялын шинжтэйгээр 2-5 жилийн хугацаагаар тогтоодог байсан байна.

-Засан хүмүүжүүлэх ажил хийлгэх:

Засан хүмүүжүүлэх ажил хийлгэх ялыг нэг сараас доошгүй, нэг жил зургаан сараас дээшгүй хугацаагаар тогтоож, шийтгэгчдийн ажиллаж байсан газар буюу оршин суугаа газарт нь ойролцоо өөр газарт нь ажиллуулж, цалин хөлсний 10-25 хүртэл хувийг шүүхийн тогтоолд заасны дагуу суутган авч улсын санд нийлүүлдэг байсан байна.

-Ямар нэгэн тодорхой албан тушаал гүйцэтгэх буюу ажил хэрэг эрхлэхийг хориглох:

Тодорхой албан тушаал гүйцэтгэх буюу ажил хэрэг эрхлэхийг хориглох ялыг 1-5 жил хүртэл хугацаагаар үндсэн ба нэмэгдэл ялын шинжтэй оногдуулдаг байсан байна.

-Торгох:

Эрүүгийн хуульд заасан хэрэг, хэмжээгээр зохих тооны мөнгө гаргуулахыг торгууль гэж нэрлэн торгууль төлөх хугацааг 2 сараас дээшгүйгээр тогтоодог байжээ.Хэрэв торгуулийн мөнгийг төлөхгүй бол шүүх торгуулийн 75 төгрөг бүрийг нэг сарын засан хүмүүжүүлэх ажилтай тэнцүүлэн бодож сольж болох ба 1 жил 6 сараас хэтрүүлэхгүй байхаар заасан байна.

- Олон нийтийн өмнө буруушаах:

Шүүхээс гэмт этгээдийг олон нийтийн өмнө буруушаан зэмлэж, шаардлагатай гэж үзвэл хэвлэлд нийтлүүлэх буюу өөр аргаар олон нийтийн сонорт хүргэхийг тухайн ялд ойлгодог байжээ.

Ял шийтгэгдсэн этгээдэд дээрх үндсэн ялаас гадна хөрөнгийг хураах /ялтны амины өмч буюу бусадтай хамтарсан дундын өмч болох хөрөнгөнөөс түүнд оногдох хэсгийг бүгдийг буюу заримыг үнэ төлбөргүйгээр хурааж улсын санд нийлүүлэх/, цэргийн алдар цол, тусгай алдар цолыг хасах /цэргийн болон бусад алдар цолтой хүмүүс/ ялыг нэмэгдэл ялын шинж чанартай оногдуулж байжээ.

1980-1990 он дахь хорихоос өөр төрлийн ялын эрх зүйн зохицуулалт:

1986 оны Эрүүгийн хуульд ялын зорилгыг ялтныг үйлдсэн гэмт хэрэгт нь цээрлүүлэх, хөдөлмөрт үнэнч шударга ханддаг, хуулийг нарийн чанд биелүүлдэг, хамтын аж байдлын социалист хэв журмыг хүндэтгэдэг үзэлтэй болгон засан хүмүүжүүлэх, дахин хүмүүжүүлэх, түүнчлэн ялтныг болон бусад хүнийг гэмт хэрэг үйлдэхээс урьдчилан сэргийлэхэд оршино гэж тодорхойлжээ. Ялын төрөл:

- 1.хорих
- 2.нутаг заах
- 3.уг нутгаас зайлуулах
- 4.засан хүмүүжүүлэх ажил хийлгэх
5. тодорхой албан тушаал эрхлэх буюу тодорхой үйл ажиллагаа явуулах эрхийг хасах
- 6.торгох
- 7.сахилгажуулах ангид явуулах
- 8.олон нийтийн өмнө буруушаах
- 9.эд хөрөнгө хураах
- 10.цэргийн болон тусгай алдар цолыг хасах.

Дээрх ялын төрлүүдээс хорихоос өөр төрлийн ялыг хэрхэн эдлүүлж байсан талаар авч үзвэл:

-Нутаг заах:

Ялтныг оршин суугаа газраас нь зайлуулан тодорхой нутагт албадан суулгахыг хэлэх ба үндсэн ба нэмэгдэл ялын шинжтэйгээр 2-5 жилийн хугацаагаар тогтоодог байсан байна. Нутаг заан суулгагдсан этгээдийг хөдөлмөрт хамруулах ажлыг тухайн орон нутгийн ардын депутатын хорооны гүйцэтгэх захиргаа хариуцдаг байжээ.

-Уг нутгаас зайлуулах:

Ялтныг тодорхой нутагт оршин суухыг хориглож, оршин суугаа газраас нь зайлуулахыг хэлэх ба үндсэн ба нэмэгдэл ялын шинжтэйгээр 2-5 жилийн хугацаагаар тогтоодог байсан байна.

-Засан хүмүүжүүлэх ажил хийлгэх:

Засан хүмүүжүүлэх ажил хийлгэх ялыг 3 сараас нэг жил зургаан сар хүртэл хугацаагаар оногдуулж, ялтны ажиллаж байсан газар эсхүл засан хүмүүжүүлэх ажил хийлгэх ялыг биелүүлэх байгууллагын заасан, оршин суугаа газарт нь ойролцоо өөр газарт эдлүүлнэ.

Ялтны цалин хөлсний 10-25 хүртэл хувийг шүүхийн тогтоолд заасны дагуу суутган авч улсын орлогод оруулдаг байна.

-Тодорхой албан тушаал эрхлэх буюу тодорхой үйл ажиллагаа явуулах эрхийг хасах:

Тодорхой албан тушаал эрхлэх буюу тодорхой үйл ажиллагаа явуулах эрхийг хасах ялыг шүүх 1-5 жил хүртэл хугацаагаар үндсэн болон нэмэгдэл ялын чанартай оногдуулж байжээ.

-Торгох:

Шүүхээс гэмт хэргийн хүнд, хөнгөн, гэм буруутай этгээдийн эд хөрөнгийн байдлыг харгалзан 250-1500,2000-5000 хүртэл төгрөгөөр тогтоож байжээ.

Үндсэн ялын чанартай оногдуулсан торгох ялаас ноцтойгоор зайлсхийвэл шүүх торгуулийн 75 төгрөгийг засан хүмүүжүүлэх ажил хийлгэх ялын 1 сартай тэнцүүлэн бодож, төлөгдөөгүй торгуулийг 1 жил 6 сараас дээшгүй хугацаагаар засан хүмүүжүүлэх ажил хийлгэх ялаар сольж болдог байжээ.

-Сахилгажуулах ангид явуулах:

Ялтны хувийн байдал болон хэргийн нөхцөл байдлыг харгалзан 2 жил хүртэл хугацаагаар хорих ялын оронд мөн хугацаагаар сахилгажуулах ангид явуулах нь зохистой гэж шүүх үзсэн тохиолдолд гэмт хэрэг үйлдсэн цэргийн жинхэнэ хугацаат алба хаагчийг 6 сараас 2 жил хүртэл хугацаагаар сахилгажуулах ангид явуулж байжээ.

-Олон нийтийн өмнө буруушаах:

Шүүх гэмт этгээдийг олны өмнө буруушаах, зэмлэх шаардлагатай гэж үзвэл хэвлэлд нийтлүүлэх буюу өөр аргаар олон нийтийн сонорт хүргэхийг тухайн ялд ойлгодог байжээ.

-Эд хөрөнгө хураах:

Ялтны өрхийн буюу гэр бүлийн амины өмчид байгаа хөрөнгөнөөс түүнд оногдох хэсгийг бүгдийг буюу заримыг үнэ төлбөргүйгээр албадан гаргуулж улсын өмчид шилжүүлэхийг хэлнэ.

-Цэргийн болон тусгай алдар цолыг хасах:

Цэргийн болон бусад тусгай цолтой этгээд хүнд гэмт хэрэгт шийтгүүлбэл түүний цолыг шүүхийн таслан шийдвэрлэх тогтоолоор хасаж болно.

1990-2000 он дахь хорихоос өөр төрлийн ялын эрх зүйн зохицуулалт:

1993 оны Эрүүгийн хуульд ялын зорилгыг гэмт халдлагаас иргэн, нийгмийг хамгаалах, гэмт хэрэг үйлдсэн этгээдийг цээрлүүлэх, засан хүмүүжүүлэх, түүнчлэн ялтныг болон бусад хүнийг гэмт хэрэг үйлдэхээс урьдчилан сэргийлэхэд оршино гэжээ.

Уг хуульд ялын төрлийг:

1.торгох

2.тодорхой албан тушаал эрхлэх буюу тодорхой үйл ажиллагаа явуулах эрхийг хасах

3.эд хөрөнгө хураах

4.засан хүмүүжүүлэх ажил хийлгэх

5.хорих

6.цаазаар авах гэж тогтоож байжээ.

2002 оны Эрүүгийн хууль:

2002 оны эрүүгийн хууль нь ерөнхий, тусгай ангиас бүрдсэн 11 хэсэг, 30 бүлэг, 305 зүйлтэйгээр батлагдаж хэрэгжих явцдаа 13 удаагийн нэмэлт өөрчлөлт орж байсан байна. Уг хуульд тусгагдсан хорихоос өөр төрлийн ялын тухайд

1. торгох;

2. тодорхой албан тушаал эрхлэх, үйл ажиллагаа явуулах эрхийг хасах;

3. эд хөрөнгө хураах;

4. албадан ажил хийлгэх гэсэн төрлүүдтэй байсан бөгөөд торгох, албадан ажил хийлгэх, баривчлах, хорих, цаазаар авах ялыг үндсэн ялын чанартай, тодорхой албан тушаал эрхлэх, үйл ажиллагаа явуулах эрхийг хасах ялыг үндсэн ба нэмэгдэл ялын чанартай, эд хөрөнгө хураах ялыг зөвхөн нэмэгдэл ялын чанартай хэрэглэхээр зохицуулагдсан байна.

Торгох ял: Энэ хуулийн тусгай ангид заасан тохиолдолд шүүхээс мөнгөн төлөөс оногдуулахыг торгох ял гэх бөгөөд торгох ялын хэмжээг гэмт хэрэг үйлдэх үед мөрдөгдөж байгаа хууль тогтоомжид заасан нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг таваас таван зуу дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр тогтоохоор зааж өгсөн.

Торгох ялаас ноцтойгоор зайлсхийвэл уг ялын хэмжээнээс хамааруулан шүүх торгох ялыг гурван жил хүртэл хугацаагаар хорих ялаар сольж болох Албадан ажил хийлгэх, баривчлах, хорих ялыг торгох ялаар солихыг хориглоно.

Тодорхой албан тушаал эрхлэх, үйл ажиллагаа явуулах эрхийг хасах: Гэмт хэрэг үйлдсэн этгээдийн төрийн албан тушаал эрхлэх, тодорхой мэргэжлийн болон бусад үйл ажиллагаа явуулах эрхийг энэ хуулийн тусгай ангид заасан тохиолдолд нэгээс таван жил хүртэл хугацаагаар хязгаарлахыг тодорхой албан тушаал эрхлэх, үйл ажиллагаа явуулах эрхийг хасах ял гэнэ.

Тодорхой албан тушаал эрхлэх, үйл ажиллагаа явуулах эрхийг хасах ялыг баривчлах, хорих ялд нэмэгдэл ялын чанартай оногдуулсан бол хугацааг нь үндсэн ялыг эдэлж дууссан үеэс эхлэн тоолох ба хорих ялыг тэнссэн бол хугацааг нь шүүхийн шийтгэх тогтоол хүчин төгөлдөр болсон үеэс эхлэн тоолно.

Тодорхой албан тушаал эрхлэх, үйл ажиллагаа явуулах эрхийг хасах ялыг торгох, албадан ажил хийлгэх ялд нэмэгдэл ялын чанартай оногдуулсан бол хугацааг нь шүүхийн шийтгэх тогтоол хүчин төгөлдөр болсон үеэс эхлэн тоолно гэж үзсэн байдаг.

Эд хөрөнгө хураах ял гэж энэ хуулийн тусгай ангид заасан тохиолдолд гэмт хэрэг үйлдсэн этгээдийн хувьд ногдох эд хөрөнгийг бүгдийг буюу заримыг үнэ төлбөргүйгээр албадан гаргуулж, төрийн өмчлөлд шилжүүлэхийг эд хөрөнгө хураах ял гэнэ.

Гэмт хэрэг үйлдэж олсон эд зүйл буюу түүний үнэ, гэмт хэрэг үйлдэхэд хэрэглэсэн зэвсэг, тээврийн хэрэгсэл, унаа хөсөг болон бусад хэрэгслийг эд хөрөнгө хураах ялаас гадуур заавал хураана. Шүүх эд хөрөнгө хураах ял оногдуулахдаа хураах эд зүйл, эд хөрөнгийг шийтгэх тогтоолдоо нэг бүрчлэн заана.

Албадан ажил хийлгэх ял нь энэ хуульд заасан хугацаагаар шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын тодорхойлсон газарт нийгэмд ашигтай ажлыг цалин хөлс олгохгүйгээр хийлгэхийг албадан ажил хийлгэх ял гэнэ. Албадан ажил хийлгэх ял нь нэг зуугаас таван зуун цагийн хугацаатай байна. Албадан ажил нь нэг өдөрт гурван цагаас доошгүй хугацаагаар үргэлжилнэ.

Албадан ажил хийлгэх ял эдлэхээс санаатайгаар зайлсхийсэн ялтны эдлээгүй үлдсэн ялын найман цагийн ажлыг нэг хоног баривчлах ялаар тооцож солино.

Хөдөлмөрийн чадваргүй этгээд, жирэмсэн эмэгтэй, гурав хүртэлх насны хүүхэдтэй эх буюу ганц бие эцэг, түүнчлэн тавин таваас дээш насны эмэгтэй, жараас дээш насны эрэгтэй, цэргийн жинхэнэ хугацаат алба хааж байгаа этгээдэд албадан ажил хийлгэх ял оногдуулахгүй гэж тус тус заасан байна.

Эрүүгийн хууль тогтоомжийн түүхэн уламжлалыг судлан үзэхэд ялын зорилгыг дараах байдлаар тодорхойлсон байна.

1.1926, 1929, 1934 оны Шүүх цаазын бичгүүдэд ялын зорилгыг:

- Гэмт хэрэг үйлдэгсдийг дахин шинээр гэмт хэрэг үйлдэхээс сэргийлэх
- Бусад тогтворгүй хүмүүст сануулга болгох
- Нэгэнт гэмт хэрэг үйлдэгсдийг засруулах гэж тодорхойлоод ял шийтгэх явдал нь хүний бие мах бодыг зовоох буюу хүн гэсэн нэр төрийг доромжлох зорилготой байж үл болно гэж заасан байна.

2.1942 оны Эрүүгийн хуульд ялын зорилгыг:

- Гэмт хэрэг үйлдэгсдийг дахин шинэ гэмт хэрэг өдүүлэхээс цээрлүүлэх
- Нийгмийн бусад тогтворгүй хүмүүст сануулга болгох
- Гэмт явдал үйлдэгсдийг засан хүмүүжүүлэх гэж тодорхойлжээ.

3.1961 оны Эрүүгийн хуульд ял шийтгэх явдал бол шийтгэгчдийг хөдөлмөрт үнэнч шударга ханддаг, хуулийг нарийн чанд сахидаг, хамтын ажил байдлын социалист хэв журмыг хүндэтгэн үздэг болгон засан хүмүүжүүлэх, тэрчлэн шийтгэгчдийг дахин гэмт хэрэг үйлдэхээс ба бусад гэмт хэрэг үйлдэхээс урьдчилан

сэргийлэх зорилготой. Ял шийтгэх явдал нь хүний бие махбодыг зовоох, хүн гэсэн нэрийг доромжлон гутаах зорилгогүй.

4.1986 оны шинэчлэн найруулсан Эрүүгийн хуульд өмнөх хуулийн ялын зорилго дээр

- Цээрлүүлэх
- Засан хүмүүжүүлэх болон дахин хүмүүжүүлэх зорилго шинээр нэмэгдэж хуульчлагдсан.

5.1993 оны Эрүүгийн хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуульд ялын зорилгыг:

- Гэмт халдлагаас иргэн, нийгмийг гэмт халдлагаас хамгаалах
- Гэмт хэрэг үйлдсэн этгээдийг цээрлүүлэх
- Засан хүмүүжүүлэх
- Ялтныг болон бусад хүнийг гэмт хэрэг үйлдэхээс урьдчилан сэргийлэх явдал

6.2002 оны Эрүүгийн хуульд:

- Иргэн, нийгмийг гэмт халдлагаас хамгаалах
- Гэмт хэргийн улмаас зөрчигдсөн эрхийг сэргээх
- Цээрлүүлэх
- Хүмүүжүүлэх
- Гэмт хэрэг үйлдэхээс урьдчилан сэргийлэх гэсэн эрүүгийн хариуцлагын зорилгыг хуульчилсан байна.

7.2015 оны Эрүүгийн хуульд эрүүгийн хариуцлагын зорилгыг:

- Гэмт хэрэг үйлдсэн хүн, хуулийн этгээдийг цээрлүүлэх
- Гэмт хэргийн улмаас зөрчигдсөн эрхийг сэргээх
- Хохирлыг нөхөн төлүүлэх
- Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх

Гэмт хэрэг үйлдсэн хүнийг нийгэмшүүлэхэд оршино гэж тодорхойлсон байна.

Дүгнэлт

Монгол Улсын эрүүгийн хууль тогтоомжийн түүхэн хөгжлийн явцад хорихоос өөр төрлийн ял нь нийтлэг шинжтэй, олон төрөл, хэлбэрийг хуульчлан хэрэгжүүлж ирсэн ба гэмт хэрэг үйлдсэн этгээдийг хүмүүжүүлэх, дахин гэмт хэрэг үйлдэх явдлаас урьдчилан сэргийлэх зорилгыг агуулж ирсэн байна.

2015 оны Эрүүгийн хуульд зорчих эрхийг хязгаарлах ялыг нэмж хуульчилсан боловч тодорхой оршин суух хаяггүй этгээдэд хэрхэн оногдуулах талаар зохицуулалтыг хуульчлаагүй, албадан ажил хийлгэх ялыг халж, нийтэд тустай ажил хийлгэх ялыг ялын төрөлд шинээр хуульчилсан боловч уг ялын албадан ажил хийлгэх ялаас ялгагдах онцлог, хийх ажлын хүрээ, хязгаарыг тогтоож өгөөгүй, өмнөх ялын агуулга хэвээр байна гэж дүгнэж байна.

Санал

-Хорихоос өөр төрлийн ял шийтгүүлсэн этгээдэд цагдаагийн байгууллагаас хяналт тавих эрх зүйн орчныг бүрдүүлэх, захиргааны хяналтыг боловсронгуй болгох

Ашигласан материал

1. БНМАУ-ын түүх. УБ., 1984
2. МАХН-ын түүхэнд холбогдох баримт бичгүүд. I боть. УБ., 1966
3. Б.Содовсүрэн. БНМАУ-ын Эрүүгийн хууль тогтоомжийн хөгжилт. УБ., 1971

4. “Ардын засгаас 1921-1924 онуудад авсан хувьсгалт арга хэмжээнүүд” 1954
5. Б.Баярсайхан, С.Жанцан “Монгол улсын эрүүгийн хууль тогтоомжийн түүхэн уламжлал (1911-2009). УБ., 2010
6. Б.Баярсайхан, С.Жанцан “Монгол улсын эрүүгийн хууль тогтоомжийн түүхэн уламжлал (1911-2009)
7. Г.Совд. “БНМАУ-ын эрүүгийн эрхийн курс” (ерөнхий анги). УБ., 1973